

Хутагт Хос судрын Номын зүйл Их хөлгөн судар

Энэтхэгийн хэлээр: Арьяа Сангади судра дарма бараяа

Түвдийн хэлээр: འཕགས་པ་བླུང་གི་མདོའི་ཚོས་ཕྱི་རྣམ་གྲངས།

(Пагва сүнгийн до чойжи намдан)

Монгол хэлээр: Хутагт Хос судрын Номын зүйл

Хамаг бурхад, бодьсадвад мөргөмү!

Ийн хэмээн миний сонссон цагт Ялж төгөлдөр нөгчигсөн Бурхан бээр Тасын цогцост уулнаа Ража-гриха (*мон: Хааны орд хари*)—д, дээдэс хуврагууд болоод 32,000 аяга тахэмлиг тэдгээртэй хамт оршвой. Тэдгээр нь насан гавъяат Ажната-каундиня (*түвд: Гүншэй говинда*), насан гавъяат Маха-мудгальяана (*Их Монголжийбуу*), насан гавъяат Шари-путра (*Шаарийбуу*), насан гавъяат Маха-кашяапа (*Одсүрэн жимбуу*), насан гавъяат Рахула (*Дажинзэн*), насан гавъяат Бакула, насан гавъяат Бхадра-пала (*Санжон*), насан гавъяат Бхадра-шри (*Санбал*), насан гавъяат Чандана-Шри (*Занданбал*), насан гавъяат Жангула (*Дугсэл*), насан гавъяат Субхути (*Равжир*), насан гавъяат Рэвата (*Намдуу*), насан гавъяат Нанда-сэна (*Гадэ*) тэргүүтэн гурван түм, хоёр мянган аяга тахэмлиг болон; 62,000 бодьсадва нар нь энэ адил буюу; бодьсадва, их бодьсадва Майтрея (*Жамбаа*), бодьсадва, их бодьсадва Сарва-шура (*Гүндүбаваа*), бодьсадва, их бодьсадва Кумара-шри (*Шонубал*), бодьсадва, их бодьсадва Кумара-васин (*Шонунайва*), бодьсадва, их бодьсадва Кумара-бхадра (*Шонусамбуу*), бодьсадва, их бодьсадва Ануна (*Мидрээ*), бодьсадва, их бодьсадва Манжушри (*Жамбал*), бодьсадва, их бодьсадва Саманта-бхадра (*Гүндүсамбуу*), бодьсадва, их бодьсадва Сударшана (*Данаадүг*),

бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна (*Манжсидэ*), бодьсадва, их бодьсадва Ваджра-сэна (*Доржсидэ*) тэргүүтэн бодьсадва, их бодьсадва зургаан түм хоёр мянга, 12,000 тэнгэрийн хөвгүүд энэ мэт буюу. Тэнгэрийн хөвгүүн Аржуна (*Сэрдүү*), тэнгэрийн хөвгүүн Бхадра (*Самбуу*), тэнгэрийн хөвгүүн Субхадра (*Шиндүсамбуу*), тэнгэрийн хөвгүүн Дхарма-ручи (*Чойжод*), тэнгэрийн хөвгүүн Чандана-гарбха (*Занданьямбуу*), тэнгэрийн хөвгүүн Чандана-васин (*Занданнай*), тэнгэрийн хөвгүүн Чандана (*Зандан*) тэргүүтэн тэнгэрийн хөвгүүд нэг түм хоёр мянга болой. Тэнгэрийн охид найман мянга энэ адил буюу. Тэнгэрийн охин Мирдамжини (*А дан*), тэнгэрийн охин Прасадавати (*Зэдан*), тэнгэрийн охин Махатма-сампраюкта (*Дагнидчидан*), тэнгэрийн охин ‘Цогт мэлмий’ (*Мигбал*), тэнгэрийн охин Пражапати-васини (Жигүүдагмонайва), тэнгэрийн охин Балини (*Довзин*), тэнгэрийн охин ‘Эдийн Цогт’ (*Норбал*), тэнгэрийн охин Субаху-юкта (*Лавгасандан*) тэргүүтэн тэнгэрийн охид найман мянга хийгээд найман мянга лусын хаад энэ адил буюу. Лусын хаан Апалала (*Согмамэд*), лусын хаан Элапатра (*Иладамба*), лусын хаан Тиминжила (*Нямэн*), лусын хаан Кумбхасара (*Бумбиньямбуу*), лусын хаан Кумбха-ширша (*Бумбагоо*), лусын хаан ‘Буяныг төрүүлэгч’ (*Гэжид*), лусын хаан Сунанда (*Шиндгаваа*), лусын хаан Сушакха (*Давсан*), лусын хаан Гава-ширша (*Ламбуугоо*) тэдгээр тэргүүтэн найман мянган лусын хаан лугаа хамт залран авай.

Тэд бүгдээр Ража-гриха хаана байгаа, Тасын цогцост уул хаана байгаа, Ялж төгөлдөр нөгчигсөн хаана заларч буй тэр газар очоод, Бурханы өлмийд толгойгоороо мөргөн, Бурханыг гурвантаа эргэж, Бурханы мэлмийн өмнө суух агаад Бурхан бээр тэдний ирснийг болгоон таалж, дуугүй залрав.

Тэндээс бодьсадва, их бодьсадва Сарва-шура (*түвд: Гүндүбаваа*) суудлаасаа босож, орхимжоо нэг мөрнөөсөө буулгаад, баруун өвдгөө газарт нугалан суугаад, Бурханы зүг алгаа хавсран мөргөж, ийн хэмээн Бурханаа айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөн Бурхаан!, живаа тоотой тэнгэрс, живаа тоотой тэнгэрийн охид, олон живаа тоотой бодьсадва нар хуран чуулсан бөгөөд олон живаа тоотой

Сонсоод сонсогч нар бас лусын олон хаад нар номыг сонсохын тулд хуран цуглараад байна. Тиймээс Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Бурхан бээр номын ёсноо орох учрыг ямар мэтээр болгоовоос хөгшин амьтан бүгд сонссон дарууд үйлийн түйтгэрүүд нь арилах бөгөөд идэр залуу амьтан бүхэн буяны Номонд илт хичээх бөгөөд ялгамжаатай хутгийг олох буюу. Буяны Номоос үл няцах бөгөөд үл доройтох бөгөөд огтоос үл доройтох тэр адилын номын ёсноо орохуй түүнийг сайтар номлон соёрх оо.”

Ийн хэмээн айлтгасан ба Бурхан бээр бодьсадва, их бодьсадва Сарва-шурад ийн хэмээн зарлиг болбой: “Сарва-шура, та Бурханаас энэ адилын утгыг асуухыг санадаг чинь машид их баатарлаг бөгөөд сайн болой. Сайн болой. Тийм учраас, Сарва-шура, та машид сайтар сонсогтун. Сэтгэлдээ баригтун. Би танд номлосугай.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэр дагуу болсугай” хэмээн айлтгаад, бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр Бурханы айлдсан дагуу сонссон ба Бурхан бээр түүнээ ийн хэмээн зарлиг буулгавай:

“Сарва-шура, *Хос судар* хэмээгдэх номын зүйл нь өнөөдөр хүртэл Замбу тивд оршсоор байна. Хэн нэгэн хүн тогтоолын *Номын зүйл* үүнийг сонсвоос түүний завсаргүй таван нүгэл арилах бөгөөд ханьцашгүй үнэхээр төгс бодийн хутгаас үл буцах болой. Сарва-шура, энэ талаар юу гэж бодож байна? Хэрэв хэн хүн бээр энэхүү *Хос судрыг* сонссоноор нэг бурханы хураах буяны цогцсоос илүү их буяныг хураана гэж бодно уу? Та тэр адил буяныг хэмжиж чадахгүй билээ.”

Сарва-шура бээр, “Тэгвэл яаж мэдэх вэ?” гэж асуув.

Бурхан бээр зарлиг болруун: “Сарва-шура, тэрхүү бодьсадва, их бодьсадва нар Ганга мөрний элсний тоо шиг Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад буяны чуулган хэдий чинээ их хураасантай адил, төдий чинээ их буяныг хураах болой. Сарва-шура, алин *Номын зүйл* үүнийг сонссоноор тэдгээр бүгд үл буцах болой. Тэдгээр бүгд Бурханыг үзэх болой. Тэдгээр бүгд нь Бурханыг үзэхээс үл хагацах болой. Тэдгээр бүгд нь ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг илт болгож, бурхан болох болой. Тэдгээр

бүгд бээр буяны ном алин бүгдийг олох бөгөөд чөтгөр шимнус бээр эднийг үл дийлэх болой. Сарва-шура, хэн хүн энэхүү *Хос судрыг* сонссоноор тэд бүгдээр төрөх ба түрдэхээ мэдэх болой.”

Тэр цагт тэдгээр бодьсадва бүгдээр суудлаасаа босоод, орхимжоо мөрнөөсөө буулгаж, баруун өвдгөө газарт хатгаад, Бурханаас ийн асуув: “Ялж төгөлдөр нөгчигсөөн! Тэрчлэн заларсан нэгний буяны цогцос ямар хэмжээтэй байх вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүдээ, ганц бурханы буяны цогцсын хэмжээг сонсогтун. Энэ адил буюу, үлгэрлэвээс, их далайн усны дусал хийгээд Замбу тивийн нарийн тоос хичнээн байдаг хийгээд Ганга мөрний элсний тоотой сацуу аравдугаар газарт орших бодьсадва, тэдгээр бүгдийн буяны чуулганаас ганц бурханы буяны чуулган нь үлэмж их болой. Хэн хүн *Хос судрын* номын зүйл үүнийг сонссоноор тэдгээр амьтны буяны чуулган нь түүнээс олон болох бөгөөд түүний буяны цогцос хичнээн тоотой болохыг онож чадахгүй болой, Сарва-шура, тэр цагт тэд энэхүү үгийг сонсоод хэн нэгэнд баясах сэтгэл төрснөөр түүнээ буяны цогцос хэмжээлшгүй ихээр төрөх болой.”

Улмаар бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр Бурханаа ийн хэмээн айлтгав: “Бурхаан, Номоор цангаж байгаа нь хэн бэ? Тэдгээр нь алин бэ?” хэмээн айлтгасан ба Бурхан бээр бодьсадва их бодьсадва Сарва-шурад ийн хэмээн зарлиг болов: “Сарва-шура, Номонд ихээр цангах хоёр амьтан бий. Хоёр алин хэмээвээс, Сарва-шура, энэ адил буюу. Нэг нь хамаг амьтан бүхнийг тэгш үзэх болой. Хоёрдугаар нь, Сарва-шура, аливаа Номыг сонсоод хамаг амьтанд адил тэнцүү зөвөөр заах болой.”

Бодьсадва Сарва-шура бээр айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, Номыг сонсоод хамаг амьтанд адил тэгш машид зөв заадаг хүн хэн бэ?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, нэг нь Номыг сонсоод бодийн хутагт төгс зорьсон тэр буюу. Хэзээд бодийн хутагт төгс зорьсон тэр нь хамаг амьтны тухайд Номоор ихэд цангах болой. Сарва-шура, удаах нь их хөлгөнөө орох тэр буюу. Тэрээр

үргэлжид Номоор машид цангах мөн болой.”

Чингээд тэнгэр, лус, хүмүүн, тэнгэрийн охид живаа тоот нар суудлаас босож, Ялж төгөлдөр нөгчигсөний мэлмийн өмнө алгаан хавсран, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, бид нар ч Номоор огоот цангасан болохоор Ялж төгөлдөр нөгчигсөн та бидний болоод хамаг амьтны санаа сэтгэлийг төгс төгөлдөр болгон зохиосугай.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчсөн бээр тэр цагт инээмсэглэн зохиов.

Бодьсадва, их бодьсадва Сарва-шура суудлаасаа босож, Ялж төгөлдөр нөгчигсөн залран байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Ялж төгөлдөр нөгчсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчсөөн, инээмсэглэн зохиосны үндэс алин, шалтгаан юу вэ?” хэмээв.

Ялж төгөлдөр нөгчсөн бээр бодьсадва, их бодьсадва Сарва-шурад зарлиг болруун: “Сарва-шура, энд байгаа амьтан бүгд нь ханьцашгүй туулсан бурхан болж, илт туулсан бурхан тэдгээр бүгдийн явдал орныг төгс бүтээж чадах болой.”

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар шалтгаан, ямар үндэсний учир энд байгаа амьтан ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг илт төгсгөж, бурхан болох вэ?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, та Түүнчлэн залрагсанаас энэ утгыг асуудаг чинь сайн болой, сайн болой. Тийм учраас Сарва-шура, та огоот зориулахын ялгамжааг энд сонсогтун:

“Сарва-шура, өнгөрсөн тоолшгүй олон галвын тэртээ, тэр цагт Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан Ратна-шири (*Ринчэнбал*) хэмээгдэх язгуур өлмий төгөлдөр, амгалантай заларсан, ертөнцийг болгоогч, ардыг номхотгогч ханьцашгүй сартваахь, тэнгэр хүмүүний багш, Ялж төгөлдөр нөгчигсөн бурхан ертөнцөд заларч байжээ.

“Сарва-шура, тэр цаг, тэр үед би бээр бярмань хөвүүн болж, аливаа

амьтныг бурханы билгэ билгүүнд тус тус байгуулж, тэр цаг, тэр үед гөрөөс болж төрөөд, би бээр ийн ‘эдүгээ хүртэл аливаа адгуус бүхэн гөрөөсний зовлонгоор хүлэгдсэн тэдгээр бүгд миний бурханы оронд төрөх болтугай. Тэдгээр бүгдийг би бээр бурханы билгэ билгүүнд тус тус байгуулах болтугай’ хэмээн ерөөл тавьсан билээ. Тэдгээр гөрөөс тэрхүү үгийг минь сонсоод, ‘тэр ёсоор болтугай’ хэмээн өгүүлсэн билээ. Сарва-шура, тэр буяны үндэс учраар тэдгээр амьтан энд цугласан бөгөөд ханьцашгүй үнэхээр туулсан бодийг олж, илт туулсан бурхан болох болой.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр Ялж төгөлдөр нөгчигсөнөөс дуртайяа сонсоод, Ялж төгс нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, эдгээр амьтны насны хэмжээ хэд хүрсэн бэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Эдгээр амьтны насны хэмжээ наян галав болой.”

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, галав гэдэг хэдий хэмжээтэй вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хүү минь сонсогтун, энэ адил буюу, үлгэрлэвээс, зарим хүний үздгээр 12 багцадын (*мон: бээр*) урт, гурваас дөрвөн багцадын өргөнтэй дөрвөн тал хашаа бариад, тэр хашаан дотроо дэл будааны үрээр бүрэн дүүргэе. Нөгөө хүн мянган жил болоод хашаа дүүрэн дэл будаанаас ганцхан үрийг гадагш цацъя, энэ мэтээр нөгөө хүн дэл будааны үр бүгдийг гаргаж гүйцээд дараа нь тэр хашааны суурь шороо бүгдийг байхгүй болтол гаргах хүртэл хугацаанд нэгэн галав барагдахгүй болой.

“Сарва-шура, бас бус энэ адил буюу, үлгэрлэвээс тавин багцадын өндөртэй уул, өргөнөөрөө арван хоёр багцадын хэмжээтэй уул байх юм. Нэг хүн тэнд гэрээ бариад, зуун жилийн дараа гашгайн торгоор нэг удаа арчиж цэвэрлэх буюу, тэр мэтээр үйлдсээр уул хэзээ барагдах хүртэл галав барагдахгүй буюу. Сарва-шура, галвын хэмжээ тэр мэт буюу.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура суудлаасаа босоод, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ганцхан зориулгаар ч гэсэн буяны цогцос олныг үйлдэж болдог нь энэ адил буюу. Амгалантай болгосноор насны хэмжээ наян галавт хүрч болдог болохоор Түүнчлэн залрагсдын ном дор хэн хүн бээр олонтаа хүндэлж үйлдсэнийг хэлж яаж барах вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Язгуурын хөвүүн сонсогтун, *Хос номын* зүйлийг сонссон хэн хүн бээр тэдгээрийн насны хэмжээ наян дөрвөн мянган галав ч хүрч болох бөгөөд, Сарва-шура, хэн хүн *Хос судрыг* үсгэн дор оруулсан, уншсан зэргийг хэлээд яах вэ? Сарва-шура, тэдгээр нь буяны чуулган машид олныг төрүүлэх болой.

“Сарва-шура, сэтгэлээр сүсэглэж, *Хос сударт* зүрхнээсээ мөргөсөн хэн хүн бээр ерэн таван галвын төрлөө дурьдан санах болой. Жаран галвыг хүртэл Хүрдэн эргүүлэгч хаан болох болой. Энэ насанд ч хамаг бүгдээр баясгалантай болох бөгөөд мэсийн үхлээр үл үхэх буюу, хорын үхлээр үл үхэх буюу, хараал зүхлээр үл чадагдах буюу. Өөд болсны дараа ч ерэн есөн сая тоот бурханыг илт үзэх буюу тэдгээрүүд. Сарва-шура, Ялж төгөлдөр нөгчигсөн бурхад бээр тэдгээрт, ‘Төрөлхтөний дээд та нар сайтар номносон *Хос судрын* номыг зүйлийг сонссоноор буяны цаглашгүй чуулганыг хураав’ гэж айлдана. Мөн ерөн есөн живаа тоот бурхад бүгдээр ертөнцийн орон тус бүрт эш бошгыг үзүүлэх буюу.

“Сарва-шура, хэн хүн бээр *Хос судрын* номын их зүйл бүгдийг нь төгс дэлгэрэнгүй сонссон нь юу болохыг хэлээд яах вэ? Хэн хүн тэдгээрт ‘айх хэрэггүй’ хэмээн сэтгэлийг амраах буюу.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, *Хос судрын* номын их зүйлийг би бээр сонсож үйлдэх болбоос надад ямар хэмжээний буяны цогцос төрөх вэ?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, Ганга мөрний элсний тоотой сацуу Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадын буяны чуулган хэдий чинээ тийм буяны чуулганыг амьтан тэдгээрүүд олно” хэмээв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, *Хос судрын* номын их зүйлийг сонсоод миний сэтгэл үл ханамуй.”

Бурхан бээр зарлиг болруун: “Сарва-шура, та Номын зүйлээр сэтгэл ханахгүй байгаа чинь сайн болой. Сарва-шура, та Номын зүйлээр сэтгэл ханахаа мэдэхгүй байгаа хэдий ч нялхас эгэл төрөлхтөн нар ч үүнийг үлж мэдэхгүйг хэлээд яах вэ?

“Сарва-шура, язгуурын хөвүүд хийгээд язгуурын охид хэн нэгнээ Их хөлгөнөө сүслэх сэтгэл нэгэн төрвөөс мянган галавт буруудаж унахгүй болох, таван мянган галавт адгуусанд үл төрөх, нэг түм хоёр мянган галавт буруу үзэлтэнд үл төрөх, нэг түм найман мянган галавт буйд бөглүү газарт үл төрөх, хоёр түмэн галавт өглөгт машид эрэмгий баатар болох, хоёр түм таван мянган галавт тэнгэрийн оронд төрөх, гурван түм таван мянган галавт ариун явдлаар явах болой. Мөн дөрвөн түмэн галавт гэрээс гарч орших бөгөөд таван түмэн галавт Номыг барих, зургаан түм таван мянган галавт төрлөө дурьдах бясалгалд төгөлдөр болох болой.

“Сарва-шура, язгуурын хөвүүн буюу язгуурын охин түүнээ хилэнцийн үйл өчүүхэн төдий ч үл гарах, тэднийг хилэнцэт шимнус хорлох чөлөө үл олох болой. Эхийн умайд төрөл үл авах болой. Сарва-шура, энэхүү *номын зүйлийг* сонсогч тэдгээр нь аливаа оронд төрөл авсан ч тоолшгүй 95 галавт буруудаж унах гэж үгүй болой. Найман түмэн галавт сонсголон төгөлдөр болох болой. Мянган галавт амь таслахыг тэвчих болой. Есөн түм есөн мянган галавт худал хэлэхийг тэвчих болой, Нэг түм гурван мянган галавт ховын үгийг тэвчих буюу.

“Сарва-шура, алин *номын зүйл* үүнийг сонссон амьтан тэдгээр нь олдоход бэрх болой.”

Бодьсадва, их бодьсадва Сарва-шура суудлаасаа босоод, номын хувцсаа нэгэн мөрөндөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаж, Бурхан заларч буй тэр газарт алгаа хавсран мөргөж, Ялж төгөлдөр нөгчигсөн түүнээ ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, *номын зүйл* үүнийг хэн хүн бээр тэвчсэн нүглийн үйлийн чуулган хэр зэрэг байх болоо?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, олон болой” хэмээн айлтгав.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэдгээр амьтны нүглийн үйлийн цогцос нь хэр зэрэг болох вэ?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, тайван бай. Нүглийн үйлийн чуулганы тухай надаас бүү асуугтун. Сарва-шура, хэн хүн бээр 12 Ганга мөрний элсний тоотой сацуу Түүнчлэн заларсан, дайснаа зарсан, үнэхээр туулсан бурхатад хорлохын сэтгэлийг үүсгэснээс хэн хүн бээр энэхүү *судрыг* муушаасан тэдгээрийн нүглийн цогцос нь машид илүү болой. Сарва-шура, хэн хүн Их хөлгөнөө хорлохын сэтгэлийг үүсгэсэн тэдгээр бүгд ч мөн үүнээс машид илүүтэй нүглийн чуулганыг хураах бөгөөд тэдгээр амьтан бүгд нь эвдрэх бөгөөд эвдрэх чанарт болой.”

Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэдгээр амьтад чинь гэтэлж чадахгүй гэж үү дээ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, тэд тэр дагуу болой. Гэтэлж үл чадах болой.

“Сарва-шура, энэ адил буюу, үлгэрлэвээс, хэн нэг хүний толгойг тасалчихаад түүнээ эм тан, зөгийн бал, бурам, тос, үрийн тос, түрхэх эм аль нэгийг толгойд нь түрхлээ ч юу болохыг бод доо, Сарва-шура? Тэр амьтан дахиж босож чадна гэж үү дээ?”

Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ухаарлаа.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, өөр бусад нэгэн байлаа, түүнийг хурц сэлмээр цавчиж, хурц мэсийг буулгавч амийг нь таслалгүй орхиё, энэ үест шарх сорви үлдэх бөгөөд эмийг найруулж өгөхөд шарх нь эдгэрэх буюу. Шарх эдгэрэнгүүт зовж байснаа санаж, өөрөө мэдэх ухаарах болсноор хэзээ ч дахиж хилэнц нүглийн үйлийг огт үл үйлдэх болой. Зовж билээ гэж санаснаар тэдгээр хүмүүс зовлонг ухаарч, хилэнцээ тэвчих больюу. Тэр цагт Ном буян бүхнийг илтээр үйлдэх больюу. Ном буян бүхнийг илтээр үйлдсэнээр тэр цагт буяны Ном бүхэн төгс төгөлдөр болох болой.

“Сарва-шура, энэ адил буюу, үлгэрлэвээс, үхэж байгаа хэн нэг хүн гасалж, уйлж, орилж чарлавч түүний эх, эцэг нь тусалж чаддаггүйтэй адилаар нялхас эгэл төрөлхтөн нар нь өөрт туслах, бусдад туслах алиныг нь ч үйлдэж чаддаггүй бөгөөд горьдлого тасарсан эх, эцэг мэт тэдгээр амьтан ч үхэхийн цагт горьдлого тасардаг болой.

“Сарва-шура, амьтны горьдлыг таслагч хоёр зүйл буй. Хоёр алин хэмээвээс, энэ адил буюу. Нэг нь амьтан хилэнц нүгэл үйлдэх буюу, үйлдэхээр оруулах болой. Нөгөөх нь, дээдийн Номыг тэвчих болой. Эдгээр хоёр нь үхэхийн цагт амьтны горьдлыг таслагч болой.

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Тэдгээр амьтан ямар төрөлд очих вэ? Хойдын төрөл нь юу вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, дээдийн Номыг муушаагч амьтан тэдгээрийн төрөл заяа нь хэмжээлшгүй хойд нас нь ч хэмжээлшгүй болой. Сарва-шура, дээдийн Номыг тэвчсэн амьтан тэдгээр нь галвын хугацаанд Уухилан дуудах их тамд амсуургыг амсах болой. Галвын хугацаанд Хураан дарах, галвын хугацаанд Халуун, галвын хугацаанд Машид халуун, галвын хугацаанд Хар шугамт их там, галвын хугацаанд Аюус там, галвын хугацаанд Шар үс босох их там, галвын хугацаанд ‘Аяа хоохой’ хэмээх их там зэрэг найман их галавт найман их тамд найман галвын туршид их зовлонг эдэлж амсах болой.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар их зовлонтой юм бэ. Амгалан залрагсадаа, зовлон мөн болой. Сонсоод баясал үл төрнө.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр тэр цагт эдгээр шүлгээр зарлиг болгов:

Амьтны их тамд суугч амьтад
Ямаршуу зовлонг эдэлдэг тухай
Ихэд аймшигтай үг эдгээрийг
Чи сонсовч баясал үл төрөх биз.

Алин нэгэн буяны үйлийг үйлдсэн бол
Тэр нь буянт болох мөн.
Алин нэгэн нүглийн үйлийг үйлдсэн бол
Тэр нь явчиг зовлонт болох буюу.

Хэн нэгэн жаргахын үндсээ үл мэдснээр
Төрөл авч үхэхийн зовлон хийгээд
Гаслангаар хүлэгдсэн энэлэл шаналлаар
Эрхгүй нялхас үргэлжид зовох больюу.

Алин бурхадыг дурьдан санасан
Мэргэд тэдгээр нь жаргалтай мөн.
Их хөлгөнөө сүслэн биширсэн
Тэдгээр нь муу заяанд үл одох.

Сарва-шура, тэр адилаар
Урьдын үйлээр баттай хөлөглөж
Өчүүхэн үйлийг үйлдсэн байсан ч
Хэмжээлшгүй үрийг эдлэх болдог.

Бурханы орны дээд оронд
Хөрөнгө талбиваас их үр гарах.
Хэрхэн бага хөрөнгө тавьсан ч
Олон үрийг эдэлж болдогтой адил

Ялгуугсадын номонд баясан үйлдэгч
Мэргэд нар жаргах больюу.
Элдвийн хилэнцийг сайтар тэвчин
Их буяныг олонтаа үйлдэнэ.

Алин миний ном дор
Үсний ширхэг төдий өглөг өгөгч тэр нь
Наян мянган галавт
Эд баялаг ихтэй, төгс эдлэл олонтой.

Алин ямар төрөлд төрөвч
Үргэлжид өглөг буянтай явах,
Тэр мэтээр бурханы
Өлөгийн орон гүн гүнзгий түүний үр жимс нь их.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, хэрхэн Ялж төгөлдөр нөгчигсөн таны үзүүлсэн Номыг эрэлцэх вэ? Хэрхэн Ялж төгөлдөр нөгчигсөн таны *Хос судрын* номын зүйлийг сонсож буяны үндсийг төгс барих вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, алин хэн бээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад тэдгээрийг 12 Ганга мөрний элсний тоотой тэнцэх амгалан жаргалант төгс эдлэл бүхнээр өргөн хүндэлсэн мэтээр хэн хүн бээр *Хос судрын* номын зүйл үүнийг сонссоны буяны чуулган тэр адил гэж мэдээрэй.”

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, хэрхэн буяны үндсийг төгс гүйцээж үйлдэх вэ?” хэмээн айлтгасанд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр бодьсадва, их бодьсадва Сарва-шурад ийн хэмээн зарлиг болов: “Алин буяны ёзоор тэр нь Тэрчлэн залрагсад лугаа адил гэж мэдээрэй.”

“Буяны үндэс тэдгээр нь Тэрчлэн залрагсад лугаа адил гэдгийг яаж мэдэх вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Сарва-шура, Номыг өгүүлэгч гэдэг Тэрчлэн залрагсад лугаа адил гэж мэдээрэй.”

Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, Номыг өгүүлэгч гэж хэн бэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Хэзээд *Хос судрыг* дуурсгах нь номыг өгүүлэх болой.”

Сарва-шура бээр айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, хэн хүн *Хос судрын* номын зүйлийг сонссоноор тэд бүгд энэ адил буяны чуулганыг хураадаг болохоор алин хэн хүн үсгэн дор байгуулах, асуух унших зэргийг хэлээд яахав. Гэсэн ч тэдгээр буяны цогцос чухам хэр зэрэг гарах бол?”

Ялж төгөлдөр нөгчигсөн зарлиг болруун: “Сарва-шура, энэ адилаг сонсогтун. Үлгэрлэвээс, дөрвөн зүгийн зүг нэжгээдэд Тэрчлэн

заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад 12 Ганга мөрний элсний тоотой оршиж, 12 галвын турш оршиж Ном заажээ. *Хос судар* үүний үг үсгийг үсгэн дор нэгэнтээ байгуулсны буяны цогцсыг өгүүлж болох боловч тэдгээр бүгдийн буяны цогцсыг хэмжээлж онох мэдэх юмуу, үгээр өгүүлж чадашгүй билээ. 48 Ганга мөрний элсний тоотой тэнцүү бурхад, түүнчлэн залрагсад үсгэн дор буулгасны буяны чуулганыг хэлж чадахгүй болохоор алин үг үсгийг асуусан, эргэцүүлж санасан, уншсан, Номыг хүү сан болгосон зэргийг хэлээд яахав?”

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, хэн хүн уншсаны буяны чуулган хэр зэрэг болох бол?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр тэр цагт шүлэглэн ийн зарлиг болов:

Дөрвөн мөрт шүлэг төдийг
Уншсаны буян алин хэмээвэл,
Наян дөрвөн Ганга мөрний
Элсний тоотой ялгуугсад бээр
Энэхүү *Хос судрыг*
Уншсан тэдгээрийн буяныг
Үргэлжид тасралтгүй өгүүлсэн ч
Тэр буян нь хэмжиж үл барагдах.

Бурхадын заасан Ном
Олоход бэрхтэй бөгөөд хэмжишгүй буянт болой.

Мөн тэр цагийн тэр үед, найман мянга наян дөрвөн живаа тагтаг тоот тэнгэрс бээр *Хос судрын* номын зүйлийг зааж байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөн юун тухайд энэ адилын Номын хүү санг, Ялж төгөлдөр нөгчигсөн та бээр, Замбу тивд энэ мэтээр заадаг нь сайн болой, сайн болой” хэмээв.

Мөн найман түм арван найман живаа тагтаг тоот нүцгэчин (*дияанчид*) нар Бурханы залрах тэр газар хүрч ирээд, Ялж төгөлдөр нөгчигсөнд ийн хэмээн айлтгав: “Ай буяны явдалт Гаутамын хаан, та ялагч болой!”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Түүнчлэн залрагсад нь үргэлжид ялах болой. Аяа тэрсүүд нүцгэчид, та нар нүцгэчин хэрхэн яаж ялах билээ?”

Эдгээрийг өгүүлвээс “Буяны явдалт Гаутама ялах болой. Та ялан зохиох болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун:

Би та нараас ялалт үзэхгүй байна
Харин та нар чанх буруугаар оршсон болохоор л
Та нар хэрхэн ялах билээ?
Нүцгэчин та нар сонсогтун,
Та нарт тустай нэгийг өгүүлсүгэй.
Нялхасын ухаанд жаргал үгүй.
Та нар хэрхэн ялах билээ?
Би бурхадын мэлмийн өмнө
Гүн гүнзгий мөрийг заая.

Чингээд нүцгэчин тэдгээр Ялж төгөлдөр нөгчигсөнөө хилэгнэж, үл сүслэхийн сэтгэл төрөв. Тэр үеийн тэр цагт Хурмастын Эрхэт Индра (*Жажин*) бээр очроор чичилж, 18 сая тоот нүцгэчин нарыг айлган цочоож, их зовлонг амсуулсанд нулимс асгаруулж уйлан зохиов. Бурханы лагшинг ч үл харах болов. Чингээд нүцгэчин нар уйлан хайлж, нулимсаар нүд нь дүүрэхүйеэ Бурхан үзэгдэхээ больсонд дараахь шүлгийг ийн өгүүлэв:

Ингээд өмөг садан хэн ч үгүй болов.
Эцэг, эх гэх нь ч ерөөс үгүй болов.
Хээр цөл газар хаягдсан мэт бодогдов.
Орох оронгүй, суух гэргүй болов.

Ойчих аягагүй, амсах усгүй болов.
Ой мод ч үгүй, орогнох шувуу ч үгүй болов.
Энэ газар амьтан ч үл үзэгдэх бөгөөд
Аврал үгүй болохын алжаасыг амсаж,
Амгалан залрагсад эс үзэгдэх болсноор
Аймшиг ихийг амсах болов.

Мөн тэр цагт 18 сая тоотой нүцгэчин нар суудлаасаа босож, хоёр өвдгөө газар хатгаад, цурхирах дуу эгшгээр ийн өгүүлэв:

Тэрчлэн заларсан их нигүүлсэлт минь ээ,
Хоёр хөлтний дээд туулсан Бурхан минь ээ,
Бид бүхэнд туслан зохиогооч.
Ядарсан амьтан биднийг авран зохиогтун, хэмээв.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр инээмсэглээд, бодьсадва Сарва-шурад: “Сарва-шура, нааш ирэгтүн. Нүцгэчин тэргүүтэй бусад тэрсүүд нарт Ном заагтун” хэмээн зарлиг болов.

Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, нэг Хар уул нь уулсын хаан Сүмбэр уулын оройг мөргөж хад чулуу нураах гэсэнтэй адил бус уу. Тэрчлэн Бурхад заларсаар байтал над мэтийн амьтан хэрхэн Ном заах билээ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүн ээ, чимээгүй бай. Амгалан заларсан бүхэнд мэргэн арга нь олон бий. Тиймээс явагтун, Сарва-шура. Арван зүгийн ертөнцийн оронд бурхан үзэгдэх ба тэд бурханы олбог суудлаа хаана тавьж буйг үзэгтүн. Сарва-шура, би нүцгэчин нарт Номыг зааж өгье.”

Бодьсадва Сарва-шура бээр айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, Би өөрийнхөө рид хувилгаанаар, эсвэл Бурханы рид хувилгаанаар, аль эсвэл өөр хэн нэгний рид хувилгаанаар явах уу?”

Бурхан зарлиг болруун: “Сарва-шура, өөрийнхөө рид хувилгааны хүчээр явагтун. Сарва-шура, харин буцахдаа Бурханы хүчээр ирэгтүн.”

Чингээд бодьсадва Сарва-шура бээр суудлаасаа босож, Ялж төгөлдөр нөгчигсөнийг тойрон мөргөөд, тэр даруйд үл үзэгдэх болов.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр бусад нүцгэчин нарт ном номнов:

“Нөхөд өө, төрөхүй нь зовлон мөн бөгөөд төрсөн нь ч
зовлонт болой.

Төрсний хойно зовлон болоод аюул олонтаа гарах болой.
Төрсний хойно өвдөж шаналахын аюул гарах болой.
Өвчлөхийн дээр өтлөхийн зовлон ч олонтаа гарах болой.
Өтлөхийн зовлонгийн дээр үхэх аюул зовлон гарах болой.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, төрөхүйгээс төрөхийн аюул төрнө гэж юу хэлнэ вэ?”

“Хүмүүн болж төрсөн ч олон аюул гарах буюу.
Хааны аюул гарах болой.
Хулгайн аюул гарах болой.
Галын аюул гарах болой.
Хорын аюул гарах болой.
Усны аюул гарах болой.
Хий салхины аюул гарах болой.
Аянга цахилгааны аюул гарах болой.
Өөрөө үйлдсэн үйлийн аюул гарах болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр төрөх тэргүүтэн тэр мэтийн олон зовлон гарахыг номлосон бөгөөд тэр цагийн тэр үед нүцгэчин тэрсүүд нар ихэд айн цочиж, “бид нар дахиад төрөл авахыг үл хүснэ” хэмээлдэв.

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр энэхүү *Хос судрын* номын зүйлийг ийнхүү номлосноор 18 сая тоотой бас бус нүцгэчин тэрсүүд нар ханьцашгүй туулсан бурханы хутгийг олох болов.

Өөрсдийн нөхдөөс 18 мянган бодьсатва нар арван газрын эрдмийг олж, тэд бүгдээр рид хувилгаанаар элдвийг хувилган үзүүлсэн нь энэ адил буюу. Морины дүрс, их зааны дүрс, барын дүрс, ханьгардын дүрс, сүмбэр уулын дүрс, хасын дүрс хийгээд зарим нь найлзуур модны дүрс зэргийг үзүүлж, бас бүгдээрээ лянхуат ширээнд завилан сууж үзэгдэв.

Есөн мянган живаа тоот бодьсатва нар нь Бурханы баруун суганд сууж, есөн мянган живаа тоот бодьсатва нар Бурханы зүүн суганд сууж, Бурхан үргэлжид бясалгалд оршсон хэрнээ мэргэн аргаар Ном зааж үзэгдэв. Долоо дахь хоногийн өдөр нь Бурхан мутраа сунгаж,

бодьсадва, их бодьсадва Сарва-шура Падмоттара (*мон: Лянхуат багшийн*) ертөнцийн орноос энд ирж явааг болгоов. Бодьсадва, их бодьсадва Сарва-шура тэр нь Падмоттара ертөнцийн оронд өөрийн рид хувилгааны хүчийн адистидаар долоо хоног зорчоод ирэв. Бурхан мутраа тэнийлгэх тэр цагт бодьсадва Сарва-шура бээр Ялж төгөлдөр нөгчигсөний мэлмийн өмнө суух ажгуу.

Чингээд Бурханыг гурвантаа эргээд, Бурханаа сэтгэлд сүслэн, Ялж төгөлдөр нөгчигсөн залран байгаа тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, түүнээ ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, би бээр арван зүгийн орон бүгдээр зорчоод ирлээ. Ялж төгөлдөр нөгчигсөөн, би ганцхан рид хувилгаанаар 99 мянган сая тоотой бурханы орныг тойрсон ба хоёрдугаар рид хувилгаанаар мянган живаа тоотой бурхадыг үзэв. Долоо дахь өдрөө Падмоттара хэмээх ертөнцийн оронд хүрээд түүний завсарт зуун мянган живаа тоотой үл хямрах бурхадын орныг үзэв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, цаашид бурхад Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадын рид хувилгаан болоод 92 мянган сая тоотой бурханы оронд бурхад Ном заахыг үзлээ. Тэр өдрөө 80 мянган сая тоотой бурханы орон ба бас 80 мянган сая тоотой Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад ертөнцөд гарахыг үзэв. Тэдгээр бурхан бүгдэд мөргөл буяныг үйлдсэн минь хязгаарлашгүй болов.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэрхүү өдрөө 39 мянган сая тоотой бурхадын орноор өнгөрөхөд 39 мянган сая тоотой бурханы орон тэдгээр бүгд дотор 39 мянган сая тоотой бодьсадва нар суух буюу. Тэдгээр бээр тэр өдөр ханьцашгүй үнэхээр туулсан бодийн дээд дор илт туулсан бурхан болох буюу. Ялж төгөлдөр нөгчигсөөн, Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан тэдгээрийг гурвантаа эргэж мөргөөд, рид хувилгаанаар үл үзэгдэх болов.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, 60 сая тоотой бурханы оронд бурхад Ялж төгөлдөр нөгчигсөн нугуудыг үзсэн бөгөөд бурханы орон тэдгээр хийгээд Ялж төгөлдөр нөгчигсөн бурхан тэдгээрт би эргэл мөргөлийг үйлдсэнээ тоолж чадахгүй байна.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, 8 сая тоотой бас бус бурхадын оронд ч Түүнчлэн залрагсад огоот гаслангаас нөгчихийг үзлээ. Би бээр тэдгээр бурхадад тэрчлэн эргэл мөргөлийг үйлдээд цааш замдаа гарав.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, би бас 95 сая тоотой бурханы оронд дээдийн Ном жаргахыг үзэв. Ялж төгөлдөр нөгчигсөөн, түүнийг үзээд сэтгэл алдарч, нулимсаа барьж чадсангүй. Бас тэнгэр, лус, ягчис, мангас, хүсэлт ертөнцийн олон амьтад уухилан гасалж, зовлонгийн хатгуураар хатгуулж байхыг үзлээ. Тэрчлэн бас далай адил бурхадын орон, ус мөрөн, уул мод, газар дэлхий, Сүмбэр уул сэлт бүгдээрээ шатаж байхыг үзээд мөргөсөн хэдий ч урам хугарч сэтгэл гансрав.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, би Падмоттара ертөнцийн оронд хүрэхийн зуур 500 мянган сая тоотой бурханы ширээ зассан байхыг харав. Өмнө зүгт нь 100 мянган сая тоотой ширээ зассан ба умар зүгт нь 100 мянган сая тоотой ширээ зассан, дорно зүгт нь 100 мянган сая тоотой ширээ зассан, өрнө зүгт нь бас 100 мянган сая тоот ширээ зассан, дээд талд нь бас 100 мянган сая тоот ширээ зассан байхыг үзэв. Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэдгээр зассан ширээ бүхэн 7 зүйлийн эрдэнээр бүтсэн агаад тэдгээр ширээ бүхнээ бурхад залран Ном заах буюу.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, энэ бүгдийг хараад надад бишрэл төрсөн бөгөөд тэдгээр бурхадаас энэхүү ертөнцийн орны нэр юу болохыг айлтгав. Бурхад бээр зарлиг болгож, ‘Язгуурын хөвгүүнээ, энэ ертөнц Падмоттара ертөнц хэмээх болой’ хэмээв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, чингээд би Түүнчлэн заларсан тэдгээрийг эргэж мөргөөд, ‘Бурханы орон үүний Түүнчлэн заларсаны алдар хэн вэ?’ гэж айлтгасанд тэд зарлиг болруун: ‘Түүнчлэн залрагсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан Падма-гарбха (түвд: *Бадманинбо*) хэмээгдэх буюу. Энэхүү бурханы оронд бурханы үйлийг үйлдэх болой.’

“Би бээр ийн хэмээн айлтгав: ‘Олон зуун мянган живаа бурхад байгаа тул би Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан

Падма-гарбха бурханыг мэдэхгүй байна. Аль нь вэ?

“Ялж төгөлдөр нөгчигсөн зарлиг болруун: ‘Язгуурын хөвгүүнээ, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан Падма-гарбха хэмээх түүнийг би чамд үзүүлье.’ хэмээв.

“Чингээд тэдгээр Түүнчлэн заларсан бурхад бүхний лагшин нь алга болов. Тэд зөвхөн бодьсадвын дүрээр л үзэгдэв. Зөвхөн ганцхан Түүнчлэн заларсан үзэгдэхэд, би бээр Түүнчлэн заларсан түүний өлмийд толгойгоороо мөргөв. Тэнд хүрэнгүүт нэгэн ширээ үзэгдэхэд би тэр ширээнд хүрэв. Ингээд Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэр цагт олон ширээ үзэгдэхэд тэдгээр ширээн дээр бурхад заларч үзэгдсэнгүйд би бээр Бурханд өгүүлэв: ‘Түүнчлэн заларсаан, би ширээн дээр ямар ч амьтан үл заларсныг үзнэ.’ Ялж төгөлдөр нөгчигсөн зарлиг болруун: ‘Буян үйлдээгүй бол ямар ч амьтан хүн эдгээр ширээн дээр суухын чадал үгүй болой.’

“‘Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар буяны үндсийг бүтээвэл тэр ширээн дээр суух юм бэ?’ гэж би айлтгав.

“Бурхан зарлиг болруун: ‘Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Алин *Хос судрын* номын зүйл үүнийг сонссон тэдгээр амьтанд буяны үндэс төрснөөр тэр ширээнд суух буюу. Алин хэн хүн үсгийг бичсэн, уншсан зэргийг хэлээд яахав. Сарва-шура, та бээр *Хос судрын* номын зүйл үүнийг сонссоноор, та энэ ширээнд суух болсон бөгөөд хэрвээ тийм бус бол та эдгээр бурханы оронд очих хаанаас байх вэ?’

“Бурхан ийн зарлиг болсон ба би Бурханаас ийн хэмээн айлтгав: ‘Ялж төгөлдөр нөгчигсөөн! Хэн хүн *Хос судрын* номын зүйлийг сонссоноор тэр хүн хэр зэргийн буяны чуулганыг хураах вэ?’

“Бас, Ялж төгөлдөр нөгчигсөөн, Падма-гарбха бурхан мөшөөн зохиов. Юуны тухайд тэр Бурхан мөшөөв зэргийн учрыг би Бурханаас асуув: ‘Ялж төгөлдөр нөгчигсөөн, чухам ямар учраас юуны тулд Бурхан мөшөөн зохиов?’

“Ялж төгөлдөр нөгчигсөн тэрээр зарлиг болруун: ‘Язгуурын хөвгүүнээ, их чадлыг олсон бодьсадва, их бодьсадва Сарва-шура, та сонсогтун. Энэ адил буюу. Үлгэрлэвээс, зарим нэг нь дөрвөн тивийг

эрхшээсэн хүрдэн эргүүлэгч хаан байна. Тэрээр дөрвөн тивийнхээ нутагт дэл будаа тарилаа гэхэд Сарва-шура, та үүнийг юу гэж ойлгох вэ? Түүний тариалан их олон ургах болов уу?”

Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, олон ургах болой. Түүнчлэн залрагсаан, олон ургах болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, зарим амьтан дэл будааны тэр үрийг нэг дор овоолоод, тэр будаанаас нэжгээд нэжгээд дэл будааг авч өөр бусад газар тавилаа гэвэл Сарва-шура, чи үүнийг юу гэж бодох вэ? Нөгөө амьтан дэл будааны үр бүгдийг тоолох буюу жишиж ухаарч чадах билүү?”

Бодьсадва, их бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, үүнийг чадахгүй болой. Амгалан залрагсаан, үүнийг тоолж чадахгүй болой. Дэл будааны үр тэдгээрийг тоолох буюу жишиж дийлэхгүй болой.”

“Сарва-шура, үүнтэй адилхан *Хос судрын* номын зүйлийн буяны чуулган ямар болохыг Бурханаас өөр хэн ч жишиж чадахгүй болой. Сарва-шура, энэ адил буюу. Үлгэрлэвээс, хичнээн дэл будааны үр байгаа тоотой сацуу түүнчлэн залрагсад байгаа юм. Тэд бүгдээр *Хос судрын* номын зүйлийг сонссон буяны үндэс буяныг огоот хэлэх бөгөөд жишиж үзээд ч буяныг тоолж барахгүй билээ. Тиймээс хэн хүн үсгээр бичсэн, уншсан, залсан зэргийг хэлээд яах вэ?”

Бодьсадва Сарва-шура айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, үсгээр бичсэний буян юу болох бол?”

Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Хэн нэгэн нь тарт ертөнцийн орны өвс ургамал, ой мод тэд бүгдийг нэгэн хурууны өргөний төдий хэмжээтэй жижиглэн тайрах хэд болж хураахыг ба, хоёрдугаар үлгэрийг Сарва-шура та сонсогтун. Бас живаа ертөнцийн орны хад, чулуу, шороо, нарийн тоос юу байгаа бүгдийн тоотой дөрвөн тивийг эрхшээгч хүрдэн эргүүлэгч хаан болоход ямар буян хэрэгтэйг жишиж хэлж чадах билүү?”

Сарва-шура хариулав: “Бурхаан, түүнийг хэмжиж чадахгүй болой.

Бурхадаас бусад нь чадахгүй болой.”

“Сарва-шура, түүнтэй адил *Хос судрын* номын зүйлийн үсгийг бичсэний буяны чуулганыг ч жишиж үл чадах буюу. Хэдий их тоот Хүрдэн эргүүлэгч хааны буяны чуулганаас наанадаж номын зүйл үүний нэгэн үсгийг бичих, залах зэргийн буян нь үлэмж илүү билээ. Буян ихтэй Хүрдэн эргүүлэгч хаан тэдгээрт тэр нь үгүй болой. Сарва-шура, түүнтэй адилхан бодьсадва, их бодьсадва нар Их хөлгөний дээдийн Номыг барих болон бүтээхүй дор орших ийм буянд, Хүрдэн эргүүлэгч хааны буян хэдий их ч, тэнцэж хүрч чаддаггүй билээ. Энэ адилаар *Хос судрын* номын зүйлийн үсгийг бичсэний буяны чуулган үүнийг жишиж харьцуулагтун.

“Сарва-шура, *Хос судар* энэ нь буяны хүү санг заасан болой.

Тэр нь нисваанис бүхнийг амирлуулж үйлдэх болой.

Ном бүгдийн зул болж бадрах болой.

Хилэнцэт шимнус бүгдийг ялах болой.

Бодьсадва бүгдийн орныг гийгүүлж үйлдэх болой.

Хамаг Номыг илт бүтээх болой” хэмээн зарлиг болов.

Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура ийн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, энэхүү зөв явдал нь машид их хатуужлыг судалснаар болой. Юуны тулд хэмээвээс, Ялж төгөлдөр нөгчигсөөн, түүнчлэн заларсан бурханы явдал гэдэг ховор чухаг мөн. Тэрчлэн зөв явдал нь ховор чухаг мөн. Алин хэзээд зөв явдлаар явах тэр цагт Түүнчлэн заларсан бурхадыг илт үзэх буюу, өдөр, шөнөд тэднийг үзэх болой. Алин хэзээ Бурханыг илт үзэх ба өдөр, шөнө бурхадыг үзэх болсноор бурханы орныг ч үзэх болой. Хэзээ бурханы орныг үзснээр тэндээс хүү сан бүхнийг үзэх болой. Тийм хүн үхэхийн цагт айх цочих зүйл үл төрөх болой. Хэзээд эхийн умайд үл төрөх болой. Хэзээд гаслант мууд үл төрөх болой. Хүсэл шуналын цалмаар үл хүлэгдэх болой” хэмээн айлдав.

Бурхан бээр бодьсадва, их бодьсадва Сарва-шурад ийн хэмээн зарлиг болов, “Сарва-шура, тэрчлэн залрагсад гарна гэдэг маш ховор болой.”

Өгүүлрүүн: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ховор болой. Түүнчлэн залрагсаан, олоход бэрх болой.”

Бурхан бээр зарлиг болруун: “Сарва-шура, үүнтэй адилхан *Хос судрын* номын зүйл үүнийг ч олоход бэрх болой. Сарва-шура, *Хос судрын* номын зүйл үүнийг хэн хүний чихэнд сонссон тэрээр наян галвыг хүртэлх төрлөө дурьдан санах болой. Зургаан түмэн галвыг хүртэл Хүрдэн эргүүлэгч хааныг олох болой. Найман мянган галав хүртэл Хурмастыг олох болой. Хоёр түмэн галвыг хүртэл ариун орны язгуурын тэнгэр лугаа хувь сацуу төрөх болой. Гурван түмэн найман мянган галав хүртэл Брахма (*Их Эсүрва*) тэнгэрт төрөх болой. Есөн түмэн есөн мянга галав хүртэл муу заяанд үл одох болой. Нэгэн буман галав хүртэл бирдийн дотор үл төрөх болой. Хоёр түм найман мянган галвыг хүртэл адгуусны оронд үл төрөх болой. Нэг түм гурван мянган галвыг хүртэл асурын оронд үл төрөх болой. Хутга мэсээр үхэж үл үйлдэх болой. Хоёр түм таван мянган галав хүртэл ухаан үл цалхайрах болой. Долоон мянган галвыг хүртэл оюун ухаанаар амьдрах болой. Ерэн мянган галвыг хүртэл үзвээс үзэсгэлэнт гоо болох болой. Бурханы дүрст лагшин огоот бүтсэн тэр адил болох болой. Нэгэн түм таван мянган галвыг хүртэл бүсгүйн төрөлд үл төрөх болой. Нэг түм зургаан мянган галвыг хүртэл биенд өвчин үл гарах болой. Гурван түм таван мянган галвыг хүртэл тэнгэрийн нүдтэн болж төрөх болой. Нэгэн түмэн есөн мянган галвыг хүртэл лусын оронд үл төрөх болой. Зургаан түмэн галвыг хүртэл уур хилэнгийн хүчинд үл дийлдэх болой. Долоон мянган галвыг хүртэл ядуусын гэрт үл төрөх болой. Найман түмэн галвыг хүртэл хоёр тивийг эдлэх болой. Хэдий үгээгүй байсан ч энэ адил амгалан жаргаланг эдлэх бөгөөд нэг түм хоёр мянган галвыг хүртэл балай сохрын газар үл төрөх болой. Нэг түм гурван мянган галвыг хүртэл муу заяаны төрөлд үл төрөх болой. Нэг түм нэг мянган галвыг хүртэл тэсвэрийг өгүүлэх болой.

“Үхэл ирэхийн цагт ч сүүлийн тийн мэдэл хаагдах болоход буруу бодол үл төрөх болой. Уур хилэнгээр үл дарагдах болой. Тэрбээр зүүн зүгт арван хоёр Ганга мөрний элсний тоотой сацуу Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг үзэх болой. Өмнө зүгт хорин живаа

тоотой Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг үзэх болой. Өрнө зүгт хорин таван Ганга мөрний элсний тоотой сацуу Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг үзэх болой. Умар зүгт наян Ганга мөрний элсний тоотой сацуу Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг үзэх болой. Дээд зүгт ерэн мянган живаа тоотой Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг илт үзэх болой. Доод зүгт зуун живаа тоотой Ганга мөрний элсний тоотой сацуу Ялж төгөлдөр нөгчигсөн бурхадыг илт үзэх бөгөөд тэд бүгдээрээ: ‘Язгуурын хөвгүүнээ, та бээр *Хос судрын* номын зүйл үүнийг сонссоноор бусад төрөлдөө эрдэм ухаан, тус эрдэм, амгалан жаргалан энэ бүгдийг олох болохоор бүү айгтун’ хэмээн захицгаана.

“Аяа, Язгуурын хөвгүүнээ, та бээр Ганга мөрний элсний тоо сацуу зуун мянган живаа тагтаг бурхадыг үзэв үү?”

“Айлтгах буюу: ‘Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэдгээрийг үзэх мөн. Амгалан заларсаан, үзсэн мөн.’

“Зарлиг болруун: ‘Аяа, Язгуурын хөвгүүнээ, тэдгээр түүнчлэн залрагсад нь өөртэй чинь уулзахаар залрах билээ.’

“Би бээр ямар буян хийснээр ийм олон бурхад над дээр ирэх болов?” гэж асуув.

”Зарлиг болруун: ‘Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Та хүний биеийг олоод *Хос судрын* номын зүйлийг чихэндээ сонссон болохоор түүний учир та энэ адилын буяны чуулганыг олжээ.’

Айлтгаруун: ‘Ялж төгөлдөр нөгчигсөөн, миний буяны чуулган тэр ямагтаас болсон бол хэн хүн бүгдийг бүтнээр нь сонссоныг хэлээд яах вэ.’

Зарлиг болруун: “Аяа, Язгуурын хөвгүүнээ, зөвхөн дөрвөн мөр шүлэг сонсохын буяныг хэлсүгэй, сонсогтун: Язгуурын хөвгүүнээ, энэ адил буюу. Үлгэрлэвээс, 13 Ганга мөрний элсний тоотой сацуу Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхадын буяны цогцоос ч илүүтэй их буяны цогцыг үйлдэх болой. Хэн хүн бээр 13 Ганга мөрний элсний тоотой сацуу Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхадыг тахиснаас хэн хүн бээр *Хос номын зүйл* үүний 4 мөр шүлэг төдийг сонссоны буяны цогцос нь

үлэмж илүү болох тул бүгдийг нь сонссон хэн хүнийг хэлээд яах вэ? Язгуурын хөвгүүнээ, хэн хүн бээр *Хос судрын* номын зүйл үүнийг бүгдийг нь сонссоны тусын тухай сонсогтун. Хэрэв хэн хүн бээр гурван мянган их мянган ертөнцийн орон бүгдэд дэл будаа тарьсны тоотой тэнцэх Хүрдэн эргүүлэгч хаад байгаад, мөн баян чинээлэг, эд баялаг олонтой, төгс эдлэл ихтэй зарим нэгэн төрөлхтнүүд тэр хаадад өргөл өргөж болно. Тэд бээр хүрдэн эргүүлэгч хаадад өглөг өгсөнөөс хэн нэг “үргэлжид оршигч нэгнээ” өглөг өгсөний буяны чуулган нь машид илүүтэй гардаг билээ. Гурван мянган их мянган ертөнцийн орны амьтан бүгд “үргэлжид оршихуйн хутагт” орших бөгөөд хэн хүн тэр бүгдэд өглөг өгсөний буяны чуулган нь хэн хүн “нэгэн удаа эргэн ирэгч” нэгнээ өглөг өгсөний буяны чуулган илүүтэй гарах болой. Гурван мянган их мянган ертөнцийн орны амьтан тэдгээр бүгд “нэг удаа эргэж ирэгч” болох бөгөөд хэн хүн бээр тэр бүгдэд өглөг өгсөний буяны чуулганаас илүүтэй хэн хүн бээр “жич үл ирэгч” нэгнээ өглөг өгсөнөөх нь буян түрүүчийнхээс илүү олонтаа төрөх болой. Гурван мянган их мянган ертөнцийн амьтан бүгд “жич үл ирэгч нэгэн” болох бөгөөд хэн хүн бээр тэд бүгдэд өглөг өгсөний буяны чуулганаас хэн хүн бээр нэгэн “дайснаа дарсанд” (*архадад*) өглөг өгсөн тэр буяны чуулган нь түрүүчийнхээс илүүтэй болой. Гурван мянган их мянган ертөнцийн амьтан тэдгээр бүгд дайснаа дарсаны үрийг олох бөгөөд хэн хүн бээр тэд бүхнээ өглөг өгсөн буяны чуулган нь хэн хүн бээр “өөрөө ялгуулсан” нэгнээ өглөг өгсөн түүний буян нь түрүүчийнхээс илүүтэй их төрөх болой. Гурван мянган их мянган ертөнцийн амьтан тэр бүгд “өөрөө ялгуугсан” болох бөгөөд хэн хүн бээр тэр бүгдэд өглөг өгсөний буяны чуулган нь хэн хүн бээр нэгэн бодьсадвад өглөг өгөх нь түрүүчийн буяны чуулганаас үлэмж их болох болой. Гурван мянган их мянган ертөнцийн орны амьтан бүгд бодьсадва болох бөгөөд хэн хүн бээр тэр бүгдэд өглөг өгсөний буяны чуулганаас хэн хүн нэгэн түүнчлэн залрагсанаа сэтгэл сүсэлсэн ба гурван мянган их мянган ертөнцийн орон бурхадаар төгс дүүрсэнд хэн хүн сэтгэл сүсэлсэн ба хэн хүн *Хос судрын* номын зүйл үүнийг тэднээс сонссон тэрхүү буян нь дээрхээс үлэмж илүү билээ. Сарва-шура, хэн хүн *номын зүйл* үүнийг үсгэн дор асуусан, барьсан, уншсан, бүгдийг нь ухаарч

авсан зэргийг хэлээд яах вэ! Сарва-шура, *номын зүйл* үүнээ сэтгэлээр сүсэлж мөргөснийг ч хэлээд яах вэ!

“Сарва-шура, үүнийг юу гэж бодно? Хэн хүн бээр, эгэл нялхас амьтан бүгдээрээ үүнийг сонсож чадах болов уу, алин сонссон хэдий ч тэд сүсэглэж чадахгүй болов уу хэмээн эргэлзэж болно.”

“Сарва-шура, сонсогтун, эгэл төрөлхтөн нялхсаас их далайн гүн ёроолд хэн нь хүрч чадах вэ?”

“Бурхаан, хэн ч чадахгүй ээ” хэмээн айлтгав.

Зарлиг болруун: “Сарва-шура, хэн хүн гарынхаа алгаар их далайг барж дуусгах амьтан хаана байна вэ?”

“Бурхаан, байхгүй болой. Түүнчлэн залрагсаан, тэр байхгүй болой.”

Зарлиг болруун: “Сарва-шура, хэрхэн их далайг хатааж чадах амьтан гэж хаана ч байхгүйтэй адил Сарва-шура, дорд мууд дурлагч аливаа амьтан номын энэ зүйлийг сонсож чадахгүй болой. Сарва-шура, наян Ганга мөрний тоотой живаа бурхадыг үзэж чадахгүй болохоор тэд *Хос номын* зүйл үүнийг бичиглэж чадахгүй болой. Харин ерэн Ганга мөрний тоотой түүнчлэн залрагсдыг үзэж чадах тэдгээр л энэ номыг сонсож чадах буюу. Мөн зуун мянган живаа тагтаг түүнчлэн залрагсдыг үзээгүй хэн хүн тэдгээр нь номын энэ зүйлийг сонсохыг тэвчих болой. Сарва-шура, 100 живаа Ганга мөрний элсний тоот түүнчлэн залрагсдыг үзсэн тэдгээр нь *номын зүйл* үүнийг сонсох агаад сэтгэлээр сүслэх болой, баярлах болой, үнэхээр ёс дагуу ёсчлон мэдэх болой, *Хос номын* зүйл үүнээ сүслэхийг үл огоорох болой.

“Сарва-шура, сонсогтун. Хэн хүн бээр *Хос судар* үүнээс дөрвөн мөрөөр шүлэглэсэн нэгэн төдийг бичсэн тэдгээр нь 95,000 живаа тоот ертөнцийн орны цаана байгаа бурханы орон болох Сугавидийн (*Энхжингийн*) орон тэр адилд төрөх болой. Сарва-шура, тэдгээр амьтны насны хэмжээ нь 84,000 галав хүрэх болой.

“Сарва-шура сонсогтун, бодьсадва, их бодьсадва хэн бээр *Хос номын* зүйл үүнээс наанадаж дөрвөн мөрөөр шүлэглэсэн төдийг

сонссоноор тэдгээр бүгд энэ адил буюу. Сарва-шура, үлгэрлэвээс, зарим нэгэн амьтан хүн завсаргүй таван нүглийг үйлдсэн буюу үйлдэхүй дор оруулсан, үйлдэгч нэгнээ даган баяссан байсан ч *Хос номын* зүйл үүнээс дөрвөн мөрөөр шүлэглэсэн төдийг сонссоноор түүний үйлдсэн завсаргүй таван нүгэл тэдгээр арилахтай адил болой.

“Сарва-шура, сонсогтун, эрдэм бусдыг номлосугай. Энэ адил буюу, үлгэрлэвээс, зарим нэгэн бээр суварга эвдэх ба хуврагийг салгаж үйлдэх ба бясалгал үйлдэгч бодьсadge үймүүлж үйлдэх ба бурханы билгэ билгүүнд саад зэтгэр учруулах ба хүний амийг тасалсан зэрэг үйл үйлдэх бий. Тэдгээр нь хойшдоо гэмших ба гасалж үйлдэнэ. ‘Энэ төрөл дээрээ ч гутах бий. Дараа төрөлдөө ч гутах бий. Би тэнэг болой’ хэмээн ихэд санаад зовлонгийн амсуургыг амсах болой, үл тэсэхийн амсуургыг амсах болой. Сарва-шура, энэ амьтныг хамаг амьтан огоорох болой, муушаах болой. Тэр амьтан нь хөнөөлт, мунхаг гэж тооцогдох ба ертөнц болоод ертөнцөөс нөгчигсэн ном буянд мунхарсан нэгэн болно. Хэрхэн шатсан түлэгдсэн мод адил тэр хүмүүн олон галвын турш тийм болох болой. Хэрхэн сайхан зурсан урласан гэрийн багана нурууг шатааваас муухай болдогтой адил тэр хүмүүн ч тэр мэт болой. Энэ ертөнцөд ч үзэсгэлэн бус болох болой. Тэр хүн хаана, хэзээ, юунд очсон ч хамаг амьтан мөчөөрхөж шоолж, зодох, нүдэх ба өлсөж цангасан ч өчүүхэн төдийг ч үл өгөх болой.

“Тийм болохоор зовлонгийн амсуурга амсах, өлсөж цангахын үндэс гарах, зодуулж нүдүүлэхийн үндэс болох зэрэг нь суварга эвдсэн зэрэг завсаргүй таван нүглийг үйлдсэн зэргээс болсоныг санах болно. Ийм болохоор, ‘Би хаашаа явах билээ? Намайг аврагч нь хэн билээ?’ гэх зэргээр зовлонгоос гутрахын сэтгэл төрж тийн санах болой. ‘Ингээд бодохоор намайг аврагч хэн ч байхгүй юм байна, би уулын хавцал руу очиж, унаж үхье’ гэх бодол төрөх вий.

Ийн өгүүлрүүн:

‘Хилэнцийн үйлийг үйлдсэн болохоор би,
Үргэлжид түлэгдсэн хожуул адил бөгөөд
Энэ ертөнцөд ч үзэсгэлэн бус
Ирэх төрөлд ч үзэсгэлэн бус буюу.

Гэрийн дотроо ч үзэсгэлэн бус,
Гэрийн гадна ч үзэсгэлэн бус.
Гэмийн шалтгаар хилэнцийг үйлдэв,
Гээд муу заяанд одох болов.

Бусад төрөлд ч зовлонт болох болой,
Алин муу заяанд төрөл авах' хэмээн

Нулимс асгаруулан уйлж суутал
Тэнгэр нугууд ч үгийг нь сонсов:

‘Аяа, би муу заяанд одох тул
Хойд чанадын төрөлдөө сайн гэх ямар ч горьдлого тасрав’

Тэнгэр тэдгээр ийн хэмээн өгүүлэв:

‘Тэнэг амьтан чи!
Гаслант энэ бодлоо орхиод явагтун!

“Эцгийг алсан, эхийгээ алсан ба
Завсаргүй тавыг үйлдсэн надад,
Аврал болоод өмөг түшиг үгүй
Зовлонгийн амсуургыг амссаар сууна.
Уулын оройд очоод
Өөрийн биеэ орхихыг хүснэ.”

Тэнэг амьтан, бүү явагтун.
Хоролж үйлдэх сэтгэлээр
Олон нүглийг үйлджээ, та
Одоо харин нүгэл бүү үйлдэгтүн!

Олонтаа нүглийг үйлдсэн болохоор та
Омтоггүй зовлонт тамд очих болой.
Гасалж шаналж уйлаад ч
Газар түүн дээр хөлбөрөх болой.

Иймэрхүү хичээлээр бурхан үл болох бөгөөд
Бодьсадва ч үл болох болой.
Сонсоод сонсогчийн тонилох хөлгийг ч үл олох тул

Өөр оронд хичээл шамдлаар машид хичээгээрэй.
Аршийн суух газар ууланд очигтун.’

Аршийн суух тэр газар очиж, их арштай уулзаж,
Түүний өлмийд толгойгоороо мөргөх бөгөөд

‘Амьтны дээд та, намайг аврагтун!
Аюул, зовлонгоор ихэд нэрвэгдсэн нэгэн билээ, би
Амьтны зүрх болсон Их арш та, миний үгийг сонсоно уу!
Саатан болгоож, тунгаана уу.

Агшин төдийд буяны номыг хүртээгтүн.
Айж цочихын зовлонд эзлэгдсэн тул
Агшин бүхнийг амарлиулан соёрх.
Алин олонтаа үйлдсэн хилэнцээ наминчилму би.
Арш та надад зарлиг буулгагтун’

“Арш өгүүлрүүн:

‘Зовлонд энэлж, гасланд хатгуулсан та болбоос
Өлсөж, цангахын гэм ургасан
Горьдлого тасарч гурван ертөнцөд төөрсөн нэгэн байна
Амны идээ алин зохихыг өгч тэжээмүй’

Амь биеийг цэнгүүлэхийн тул
Арш бээр идээ өгмүй.

‘Сэтгэлд зохист амтат идээг идээд,
Амьтан бүхэн машид баясах болмуй.
Хамаг хилэнцийг арилгаж үйлдэх
Номыг танд дараа нь номносу.’

Тэрхүү амтат идээг
Нэгэн эгшинд ч идэж дуусгаад
Идээг идээд, гараа угаагаад,
Арш багшид эргэж мөргөөд,

Завилж өмнө нь суугаад
Алин үйлдсэн гэм буруугаа өгүүлэв.

‘Эцгээ алсан, эхээ алсан ба
Суварга шүтээнийг эвдэж би үйлдэв.
Бодьсадва нэгнийг
Бурхан болоход нь зэтгэрлэж үйлдэв, би’

Энэхүү үгийг сонсоод
Эрхэм арш ийн өгүүлэв:

‘Нүглийг үйлдсэн та
Аяа, нүгэлт хүн болой.
Гэсэн ч үйлдсэн нүгэл болоод
Үйлдэхээр оруулсан тэр бүгдээ наминчлагтун.’

“Тэр цагт тэр үед гаслангийн хатгуураар хатгуулсан ба айн цочиж
уйдсан ба аршид ийн өгүүлэв:

Намайг хэн аврах вэ?
Элдэв муу нүглийг үйлдсэн болохоор
Эрхгүй зовлонг амсах нь болов.

Чингээд нөгөө хүн хоёр өвдгөө газарт хатгаад, нөгөөх аршид ийн
өгүүлэв:

Өөрийнхөө үйлдсэн, үйлдэхээр оруулсан
Хилэнц бүхнээ наминчилмуй

Хилэнцийн үр бүү гартугай,
Зовлон тэдгээрийг бүү амстугай, би.

Тантай би шадарласнаар
Арш та, миний аврал болтугай.
Гэмшил үгүйгээр амарлиулах тул
Миний хилэнц үйл нугууд амарлих болом зэ.

“Чингээд тэр цагт нөгөөх арш нөгөө хүмүүнд өгүүлэв: ‘Би болбоос
төрөлхтөн таны аврал болсу. Таны суурь болсу. Таны өмөг түшиг
болсу. Тийм болохоор та айлгүй илт Номыг сонсогтун. *Хос судар*
хэмээх энэ номыг өчүүхэн төдий ч гэсэн та сонссон уу?’

“Би сонсож байсангүй ээ’ хэмээв.

“Энэрэнгүй сэтгэлийг эрхшээсэн тийм л хүн амьтан хүнд Номыг заахаас өөр бусад хэн бээр түлэгдсэн амьтанд Ном заах вэ?” гэж арш өгүүлэв.

“Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Тоолшгүй олон галвын өмнө, машинд тоолшгүй цагийн тэртээ Номт хаан Вимала-чандра (*Даваадимамэд*) хэмээгдэх нэгэн байжээ. Язгуурын хөвгүүнээ, Вимала-чандра хааны гэрт нэгэн хүү мэндэлжээ. Хаан Вимала-чандра бээр үзмэрч бярмануудыг дуудаж ийн хэмээн өгүүлэв: ‘Бярман нараа, энэ залуу хүүд ямар шинж тэмдэг байгааг өгүүлэгтүн’. Чингээд үзмэрч бярманууд өгүүлэв: ‘Их хаан минь ээ, нүгэлт болой. Сая төрсөн энэ залуу нүгэлт болой.’ Хаан өгүүлэв: ‘Юуны тул ийм болов, бярман нар минь?’ Үзмэрч нар ийн өгүүлэв: ‘Хаан минь ээ, энэ хөвүүн чинь долоон нас хүрээд, эцэг, эхийнхээ бие лагшинтай тэмцэх болох нь’. Хаан ийн хэмээн өгүүлэв: ‘Миний аминд саад болох боловч миний энэ хүүг бүү алагтун. Ертөнцөд хүн болж төрнө гэдэг чухаг ховор учраас хүмүүний биенд хорлол бүү үйлдэгтүн.’ хэмээв.

“Залуу хөвүүн түргэн бойжиж нэг сар болоход бусдууд хоёр нас хүрсэний чинээтэй өсөв. Гэсэн ч хаан Вимала-чандра, энэ хөвүүн миний үйлээр болсон гэдгийг мэдэж байв.

“Чингээд хаан бээр залуу хөвүүнд хаант улсаа өгөөд, ийн өгүүлэв: ‘Та хүч чадал ихтэй, алдар хүнд эзэлсэн их хаан болох болтугай. Номын ёсоор хаанчлах хэрэгтэй. Ном бусаар бүү захираарай.’

“Ингээд өөрийн хаант улсаа өгөөд, ‘хаан’ хэмээн нэр өргөв. Хаан Вимала-чандра орон гүрнийхээ хаан байхаа болив.

“Живаа тоот хааны түшмэд хаан Вимала-чандра байгаа тэр газарт хүрч, хаан Вимала-чандра-д ийн хэмээн айлтгав: ‘Ай их хаан минь, та юуны тулд өөрийн орон гүрэндээ хаан болж үл сууна вэ?’

“Хаан өгүүллрүүн: ‘Тоолшгүй олон галвын турш элдэв олон хаант төр, элдэв эд баялаг, төгс эдлэл, юу байгаа бүхнийг эрхшээж ирсэн хэдий ч хэзээ ч би цадахаа мэдэхгүй шунаж байж дээ.’

“Мөн тэр цагийн тэр үест, өнө удаан хугацаа өнгөрөөгүй байтал,

нөгөө хүү эцэг эхийн амийг аван, завсаргүй нүглийн үйлийг хураажээ.

“Ай хүмүүс минь, өнөөх хаан зовлонгийн амсуургыг амсаж, сэтгэл өвдөж, нүднээс нулимс гарч, уйлж суугааг нь би санаж байна. Тиймээс надад өрөвдөх сэтгэл ихэд төрж, тэр газар очоод, энэ хүүд Ном зааж, тэрхүү Номыг сонсоод цаглашгүй нүглийг үйлдсэн хилэнц бүгд үлдэлгүй, түргэнээ арилсан.”

“Өгүүлрүүн: ‘*Хос номын* зүйлийн судрын хаан үүнийг их арш нар их хатуужил гарган сонсвоос Номын орон болж, ханьцашгүй нүгэл бүхэн арилж, хамаг нисванис бүгд амарлих үүнийг олох болой.

Хэн хүн түргэнээс түргэн гэтлэх
Ном номлохыг сайтар сонсогтун.

‘Дөрвөн мөрт шүлэг төдийг
Тасралт үгүй номнох учраас
Хилэнц бүхэн арилах бөгөөд
Үргэлж орших хутгийг олох.
Хамаг нүглээс гэтэлсүгэй.’

Тухайлан өгүүлж тухайлан өгүүлсүгүй.
Тамын амьтны аймшигт хүлээснээс
Зовсон амьтныг зовлонгоос гэтэлгэх.

Хүмүүн тэдгээрт үүнийг заагаад,
Алгаан хавсран босох агаад
Түүнээ толгойгоор мөргөх ба
‘Сайн болой’ хэмээн сайшаан өгүүлэв.

Сайн болой, буяны садан нугууд,
Сайн болой, Хилэнцийг арилгагч,
Алин *Хос судрын* их ёсыг үзүүлсэн,
Үүнийг сонсооч нар сайн болой.

“Чингээд тэр цагийн тэр үест завсрын огторгуйд нэг түм хоёр мянган тэнгэрийн хөвгүүд алгаан хавсран, арш түүний дэргэд буугаад, хөлөнд нь мөргөөд ийн хэмээн өгүүлэв: ‘Ялж төгөлдөр нөгчигсэн,

Их арш минь, та урьдын хэдэн галвыг дурьдан санана вэ?’ хэмээн өгүүлэв.

“Мөн дөрвөн живаа гаруй лусын хаад, нэг түм найман мянга гаруй ягчисын хаад ирээд, арш түүний байгаа зүгт алгаан хавсран сөгдөөд, ийн хэмээн өгүүлэв: “Их арш минь, та урьдын хэдэн галвыг дурьдана вэ?” хэмээв.

“Арш бээр өгүүллүүн: ‘Зуун мянган живаа тагтаг тоолшгүй олон галав болой.’

“Өгүүллүүн: ‘Ямар буяны үйлээр агшин нэгнээ хилэнцийн үйл бүгдийг амарлиулж болох вэ?’

“Өгүүллүүн: ‘*Хос номын* зүйл үүнийг сонссоноор тийн болой. Алин хаана амьтан хүмүүс цуглаад, хэн нэгний номын зүйл үүнийг өгүүлэхийг сонссон ба сүсэглэсэн тэдгээр бүгд нь ханьцашгүй, үнэхээр туулсан, бодийн хутгийг олно гэж эш бошгийг үзүүлэв. Завсаргүй таван нүглийг үйлдсэн хэн хүмүүн бээр энэхүү тогтоол *номын зүйлийг* сонссоноороо завсаргүй таван нүглийн үйл бүгд нь төгс барагдах бөгөөд төгс арилах буюу. Зуун мянган живаа тагтаг тоолшгүй олон галвыг хүртэл муу заяаны үүд нь хаагдах болой. Гучин хоёр ертөнцийн тэнгэрийн үүд нээгдэх болой. Хэн хүн энэхүү *Хос номын* зүйлээс наанадаж дөрвөн мөр төдий үгсэн тасалбарыг сонссоноор ч түүний буяны үндэс нь энэ адилаар гарах билээ. Тиймээс хэн хүн цэцэг, үнэртэн, хүж, эрхи, түрхлэг, сүрчиг, номын баринтаг, хувцад, шүхэр, жанцан (*ялгуусны тэмдэг*), бадан зэргээр тахиж дээдлэн хүндэлсэн хийгээд өргөж хүндэлсэн, онцгойлж хүндэлсэн, тахиж хүндэлсэн, яруу сонсголонг өргөсөн, эгшиг дууг өргөсөн зэргээр нэгэн удаа үйлдсэн ба даган баяссан, сайтар номлосноо ‘Сайн болой, сайн болой’ хэмээн өгүүлсэн зэргийг хэлэх хэрэг юун.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Сарва-шура ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, *Хос судрын* номын зүйл үүнийг номносноор хэн хүн алгаан хавсран мөргөх тэдгээр хүмүүс залбиран мөргөх төдийн буяны чуулган ямар байх вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Хэн хүн бээр завсаргүй таван үйлийг үйлдсэн буюу үйлдэхүй дор оруулсан, үйлдэхэд даган баяссан тэр бүгдээр *Хос судрын* номын зүйл үүнээс наанадаж дөрвөн мөрт, үгсэн тасалбар төдийг сонсож, алгаан хавсран мөргөснөөр нөгөөх завсаргүй таван үйл бүгд нь төгс арилах болохоор, Сарва-шура, хэн хүн энэхүү *номын зүйл* бүгдийг нь сонсохыг хэлэх хэрэг юун? Энэ буяны цогцос нь түүнээс улам их болохыг хэлж байгаа хэрэг. Язгуурын хөвгүүнээ, *Хос судрын* утгыг ухаарч үйлдэхийн тулд чамд үлгэрээр зааж өгүүлсүгэй. Сарва-шура, энэ адил буюу. Нар хэзээд үл тусах Лусын хаан Анаватапта (*түвд: Мадайва*)-гийн орд харшаас таван их мөрний ус буулаа гэж бодъё. Зарим нэгэн хүмүүс таван их мөрний усны дуслыг тоолохоор боллоо гэж саная, Сарва-шура, тэр хүмүүс тэр дуслыг тоолж, хэмжээг онож чадна гэж үү?”

Айлтгаруун: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, түүнийг хэн ч чадахгүй болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, түүнтэй адилхан *Хос номын* зүйлийн буяны үндэс нь юу болохыг зуун галавт юм уу, мянган галваар ч тоолоод эцсийг нь онож чадахгүй болой. Сарва-шура, үүнийг юу гэж бодож байна вэ? Хэн хүн *номын зүйл* үүнийг агшин төдий номлосон түүний үүрэх зүйл нь бэрх биш үү?”

Айлтгаруун: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, бэрхийг үүрэх болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун. “Сарва-шура, *Хос номын* зүйлийг номнож чадах хэн боловч тэрбээр түүнийг үйлдэхдээ машинд их хатуужлыг давж үйлдэх мөн. Энэ адил буюу, үлгэрлэвээс, Анаватапта (*мон: Үл хайлах*) далайгаас таван их мөрөн бууж ирсэн болоод тэдгээрийн дуслыг тоолж, эцэс хязгаарыг онож үл чадна”.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэрхүү таван их мөрөн чинь алин юм бэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Энэ адил буюу: Ганга мөрөн, Сита мөрөн, Вакшу мөрөн, Ямуна мөрөн, Чандра-бхага мөрнүүд болой. Энэ их таван мөрөн нь их далай болж буух бөгөөд

мөрөн нэжгээд тус бүрт тав таван зуун гол байх болой. Сарва-шура, таван мөрөн тэдгээрт мянга мянган нөхөр огторгуйгаас буух бөгөөд тэдгээр бүгдээр есөн төрөлхтөнг ундаалдаг болой”.

Айлтгаруун: “Мянга мянган нөхөр тэдгээр хэн бэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “ Сундари (*түвд: Зидан, мон: Төгс үзэсгэлэнт*) нь мянган нөхөртэй, Шамкха (*Дүнжин, Лавайт*) нь мянган нөхөртэй, Ваханги (*Бавай, Буулгагч*) нь мянган нөхөртэй, Читра- сена (*Нацогдэ, Элдэв аймагт*) нь мянган нөхөртэй, Дхарма-вритти (*Чойцүл, Номын ёст*) нь мянган нөхөртэй буюу. Сарва-шура, таван их мөрөн тэдгээр нь мянга мянган нөхөр төгөлдөр бөгөөд тэд нар хурын үргэлжлэлийг буулгах болой.

“Сарва-шура, тэдгээр нь цаг цагт нь хурын дуслыг үргэлжид сайтар өгөх буюу чингэснээр цэцэг, жимс, үр тариа, зүлэг ногоо төрөх болой. Хэзээ Замбу тивд хурын үргэлжлэл үргэлжид бууснаар ‘уснаас төрөгч’ (*үүл*) төрөх бөгөөд уснаас төрснөөр тариалан, хотол баясгалант цэцэгсийн хүрээлэн бүгд цэнгэх болой, жаргах болой. Сарва-шура, энэ адилыг үлгэрлэвээс, есөн төрөлхтөний эзэн нь Замбу тив бүгдийг жаргуулж үйлдэх болой. Сарва-шура, түүнтэй адилхан *Хос номын* зүйл энэ нь ч хамаг амьтанд туслах бөгөөд хамаг амьтныг жаргалтай байлгахын тухайд Замбу тивд номлосон болой. Гучин гурван тэнгэрийн насны хэмжээ ямар байдаг түүнтэй адилхан бус болой, хүмүүнийх. Сарва-шура, Гучин гурван тэнгэр гэж хэнийг хэлнэ вэ гэж та асуувал, Тэнгэрийн эрхэт Индра (*Хурмаст*) оршдог тэр газрыг Гучин гурван тэнгэр хэмээмой.

“Сарва-шура, хэлний сайн явдлыг үйлдэгч амьтан тэдгээр бий. Гэтэл тэдгээрийн буяны чуулганыг хэмжиж чадахгүй билээ. Хэлний гэмт явдлыг үйлдэгч амьтан тэдгээр ч бий. Тийм явдалт амьтны там болоод адгуусны төрлийг үлгэрлэж чадахгүй болой. Аливаа амьтан алин там адгуус, бирдийн зовлонг амсаж эдэлж яваа тэр бүгдэд ямар ч аврал байхгүй билээ. Тэдэнд горьдлого тасарч, шаналж уйлах ба тамд унасан тэдгээр амьтад нь нүгэлт нөхрийн эрхэнд одсон нь үзэгдэнэ. Аливаа амьтан хэлний сайн үйлийг бүтээгч хэмээн өгүүлэгдэх ба тэдний буяны чуулганыг хэмжиж үл болох бөгөөд тэд

нар буяны садны эрхэнд одсон нь үзэгдэнэ. Хэзээд буяны садныг үзэх тэдэнд бурхан үзэгдэх болой. Хэзээ бурханыг үзсэн тэдэнд хамаг хилэнц нь арилах болой. Хэзээ есөн төрөлхтөний эзэн Замбу тивийг хайрлах тэр цагт замлингийн амьтан бүгд жаргалтай болохыг жишиж үл болмой.

“Сарва-шура, түүнтэй адилхан *Хос судрын* номын зүйл энэ нь ч Замбу тивийн амьганд бурхан болж үйлдэх юм. Алин хэн хүн *Хос номын* зүйлийг сонсож эс чадваас тэдгээр нь ханыцашгүй туулсан бодь хутгийг илт болгож туулсан бурхан болж үл чадна. Номын хүрдийг машид эргүүлж үл чадна. Номын ганди модыг цохиж үл чадна. Номын арслант ширээнээ сууж үл чадна. Гаслангаас нөгчигсөний агаарт орж үл чадна. Хэмжээлшгүй их гэрлээр гийгүүлж үл чадах болой. Сарва-шура, тэрчлэн *Хос номын* зүйлийг сонсож чадаагүй хэн хүн тэдгээр бодийн зүрхнээ сууж үл чадах болой.”

Сарва-шура бээр айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, сонин гайхамшигт зүйлээс өчүүхэн нэгийг айлтгаач. Амгалан залрагсдын сонин гайхамшигт явдлаас өчүүхэн нэгийг айлтгасу.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, та юу хүсэж байгаагаа асуугтун. Би таны сэжгийг арилгаж үйлдмүй.”

“Алин амьтан тэдгээр завсаргүй таван нүглээс төгс гэтэлж, жич үл буцахын газарт тус тус байгуулагч арш хэмээх тэр алин бэ?”

Зарлиг болруун:

“Бурхадын үг гүн буюу;

Сарва-шура, та намайг сонсогтун:

Хос судрын аймаг энэ нь багш бөгөөд

Аршийн дүрсээр заах болой.

Хос судар энэрэнгүй тул

Бурханы лагшинд ч хувилах буюу.

Ганга мөрний элсний тоо хэдий чинээ,

Төдийчинээ дүрс лагшинг ч үзүүлэх.

Бурханы дүрийг ч үзүүлэх бөгөөд
Номын охийг ч зааж үйлдэх

Бурхан гэж үзэх хэн хүнд
Энэ *тогтоол* нь бурхангай адил
Тогтоол хаа байгаа газарт
Үргэлжид Бурхад тэнд байх.

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүн, сонсогтун. Сарва-шура, эрт цагт тоолшгүй 99 галвын тэртээ 12 сая тоотой бурхад ажирсан буюу. Тэрчлэн заларсан Ратноттама (*түвд: Ринчэнчог*) хэмээх гарахад би бээр өглөгт баатар болж, 12 сая бурхадыг Чандра (*Санжайдаваа*) алдараар дээдлэн, идээ зоог, хүж, баринтаг, эрх, бэрээ болон хэрхэн жаргалтай амгалантай байх амны идээ олныг хийгээд басхүү жаргалтай байх төгс эдлэл бүгдээр тахин хүндлэв. Өргөл хүндлэлийг үйлдсэнээр тэрээр ханьцашгүй, үнэхээр туулсан бодь хутийг олох эш бошгийг сонссон болой.

“Сарва-шура, би бээр түүнчлэн заларсан Ратнавабхаса (*Ринчэнтамжиднаваа*) нэртэй 18 сая тоот бурхадын үед байсан бөгөөд тэр цагт бас өглөгт эрэмгийлж, 18 сая тоот бурхадыг Гарбхасена (*Нимбуудэ*) хэмээх алдараар өргөмжлөөд, хүж, эрх, бэрээ, чимэг, сугсалзах чимэг зэрэг юу зохистой нэгийг өргөн барьсан бөгөөд тэр цагт би ч гэсэн ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг олох эш бошгийг сонссоноо санаж байна.

“Сарва-шура, 20 сая тоотой бурхадыг санах буюу. Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Шикхи-самбхава (*Зүгнүд*) хэмээх бурхад ямагт болой.

“Сарва-шура, 20 сая тоотой бурхадыг дурьдан санах буюу. Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Кашялапа (*Санжай одсүрэн*) хэмээгдэх ямагт болой. Чингээд өглөг өгөхүй дор эрэмшиж, би бээр бурхад нарт хүжис, эрхэс, түрхлэг, үнэртэн зэргийг өргөснөөр тэрчлэн заларсан нугуудад багш адил санаж хүндэлсэн түүгээр багш адилаг өргөж хүндэлсэнтэй адил болсон тул би бээр ханьцашгүй үнэхээр туулсан бодийн хутгийг олох эш бошгийг олвой.

“Сарва-шура, Вимала-прабхаса (*түвд: Оддимамэд, мон: Хиргүй гэрэлт*) хэмээгдэх 16 сая тоот бурхад залрав. Тэр цагт тэр үед би эд баялаг төгс эдлэл ихтэй баян гэрийн эзэн байв. Байгаа бүхнээ бүгдийг өгье гэж бодоод 16 сая тоот тэдгээр бурхадад олбог, дэвсгэр, баринтаг хувцас, хүжис, эрхэс, түрхлэг болоод хэмжиж болох тахил юу бүхнийг тэдгээр бурхадад багш адил гэж хүндэтгэн тэр мэтээр өргөсөн бөгөөд тэр даруйд би бээр ханьцашгүй үнэхээр туулсан бодийн хутгийг олох эш бошиг сонссоноо санаж байна. Эш бошгийн цаг хэмжээ нь дуусаагүй байна.

“Сарва-шура, сонсогтун. Энэ ертөнцөд 95 сая тоот бурхад залран, тэд бүгд Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Шакъяамуни (*Шагжтүв*) бурхан хэмээгдэх байв. Тэр цагт би Номын хаан хэмээгдэж байсан бөгөөд би бээр тэрчлэн заларсан Шакъяамуни хэмээгдэх 95 сая тоот бурхадад хүжис, эрхэс, түрхлэг, олбог, суудал, хувцас баринтаг, шүхэр, дуаз, бадам тэргүүтнийг өргөн барьснаар тэр даруйд би бээр ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг олох эш бошгийг сонссоноо санаж байна.

“Сарва-шура, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Кракацунда (*Хорвоонжиг*) хэмээх бурхан 90 сая тоотой ертөнцөд гарсан бөгөөд тэр цаг тэр үед би эд баялаг ихтэй, баян чинээлэг залуу бярман байв. Байгаа бүгдээ өгьюү гэдэг сэтгэл төрөөд, тэдгээр бурхан бүгдэд хүжис, эрхэс, түрхлэг, олбог суудал, хувцас баринтаг тэргүүтнийг өргөн барьсан бөгөөд тэдгээр бурхадыг тус тусад нь аль зохистойгоор өргөн хүндэлсэн тэр даруйд ханьцашгүй үнэхээр туулсан бодийн хутгийн эш бошгийг сонссоноо би санаж байна. Эш бошгийг үзүүлсэн цаг хугацаа дуусаагүй байна.

“Сарва-шура, 18 сая тоот бурхад ертөнцөд залрав. Тэд бүгдээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан Канакамуни (*Сэртүв*) хэмээгдэх ямагт болой. Тэр цаг тэр үед би өглөгт баясаж, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад нугуудад хүжис, эрхэс, түрхлэг, олбог суудал, хувцас баринтаг, чимэг нугуудаар өргөн хүндлэв. Бурхадыг өргөн хүндэлж үйлдсэн тэр адилаар өргөн хүндэлсээр би тэр цагт ханьцашгүй үнэхээр

туулсан бодийн хутгийн эш бошгийг сонссоноо би санаж байна. Эш бошгийг үзүүлсэн цаг хугацаа дуусаагүй байна.

“Сарва-шура, 13 сая тоот бурхад ертөнцөд залрав. Бүгдээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан Авабхаса-шри (*Нанвабал*) бурхан ямагт болой. Би бээр Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад нугуудад олбог дэвсгэр, хувцас баринтаг, хүжис, эрхэс, түрхлэг, чимэг нугуудаар өргөн хүндлэв. Хэрхэн бурхад нугуудыг дээдэс лугаа адил өргөн хүндэлсэн тэр мэтээр дээдийн дээдээр бурхад нугуудыг өргөн хүндлэв. Бурхад тэдгээр ч утга лугаа төгөлдөр номхотхууны номын элдэв үүдийг номнож, тэр цагт би ханьцашүй үнэхээр туулсан бодийн хутгийн эш бошгийг сонссоноо санаж байна. Эш бошгийг үзүүлсэн цаг хугацаа дуусаагүй байна.

“Сарва-шура, 25 сая тоот Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Пушья (*Гаржил*) хэмээх бурхан ертөнцөд залрав. Тэр цагт би тойн хувраг байж, бурхадыг өргөн хүндэлсэн болой. Эдүгээ намайг Ананда (*Гунгаабуу*) хэрхэн хүндлэх адилаар би ч гэсэн бурхад нугуудыг өргөн хүндэлсэн бөгөөд тэр үед би ханьцашүй үнэхээр туулсан бодийн хутгийн эш бошгийг сонссоноо санаж байна. Эш бошгийг үзүүлсэн цаг хугацаа дуусаагүй байна.

“Сарва-шура, 12 сая тоот Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Випашюн (*Намсаг*) бурхан хэмээгдэх ертөнцөд залрав. Би бээр тэдгээр бурхадад олбог дэвсгэр, хувцас баринтаг, хүжис, эрхэс, түрхлэг нугуудаар өргөн хүндлэв. Тэр мэтээр бурхадыг өргөн хүндэлсэн тэр мэтээр тэр цагт би тойн хувраг болж, тэр даруйдаа би ханьцашүй үнэхээр туулсан бодийн хутгийн эш бошгийг сонссоноо санаж байна. Төд удалгүй Випашюн бурхан заларч, энэхүү *Хос номын* зүйлийг номносон бөгөөд би түүнийг ухаарч, тэр цагт Замбутивд эрдэнийн 7 зүйлийн их хур буусан буюу тэр цагт Замбу тивийн хамаг амьтан бүгдийн үгүйрэл арилж, тэр цагт би ханьцашүй үнэхээр туулсан бодийн хутгийг олох эш бошгийг олсон болой. Тэр цагаас хойш өнө удаан хугацаанд эшийг үл сонсов.”

“Ямар цаг, ямар хэмжээтэй вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Сарва-шура, сонсогтун. Тоолшгүй олон галвын тэртээ Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Дипамкара (*Мармэзад*) хэмээх бурхан ертөнцөд залрав. Тэр цаг тэр үед би Мегха (*Чэвүбэрэн*) хэмээх бярман байв. Дипамкара бурхан ертөнцөд залрах тэр цагт би бээр ариун явдалт залуу бярман байсан бөгөөд Дипамкара бурханыг хараад, удвал цэцгийг 7 удаа өргөж ханьцашгүй, үнэхээр туулсан бодь хутагт зориулсан бөгөөд тэр бурхан бээр, бярманы хөвгүүн намайг ирээдүй цагт тоолшгүй олон галвын хойно ертөнцөд Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Шакьямуни бурхан болно гэж эш бошгийг үзүүлсэн болой.

“Сарва-шура, түүнээс хойш би бээр дээрх огторгуйд 12 дал модны зайд суугаад, үл төрөхүйн номыг судалж тэсвэрийг олов. Мөн тоолшгүй олон галавт ариун явдлаар явав. Алин чанадад хүрсэн буяны ёсоор бүгдийг бүтээснээ өчигдрийн төдийд ч өнөөдрийн төдийд ч илт санаж байна. Сарва-шура, тоолшгүй зуун мянган живаа тагтаг зэрэг хэмжээлшгүй их олон амьтныг буяны Номд тус тус байгуулсан бөгөөд Сарва-шура, тийм болохоор ханьцашгүй үнэхээр туулсан бодийн хутагт илт болж бурхан болсон тул хамаг амьтанд туслая гэх сэтгэлийг хэлж яаж барах вэ? Сарва-шура, би амьтанд олон зүйлийн Ном заасан билээ.

“Хэрхэн дүрсээр номхотгох тэр адилуудад дүрсээр амьтанд Ном заав. Тэнгэрийн ертөнцөд тэнгэрийн дүрсээр Ном заав. Лусын оронд лусын дүрсээр Ном заав. Ягчисын оронд ягчисын дүрсээр Ном заав. Бирдийн оронд бирдийн дүрсээр Ном заав. Хүмүүний ертөнцөд хүмүүний дүрсээр Ном заав. Бурханы ёсоор номхотгох ёстой амьтанд бурханы дүрсээр Ном заав. Бодьсадын дүрсээр номхотгох ёстой амьтанд бодьсадын дүрсээр Ном заав. Алин амьтныг ямар дүрсээр номхотгох учиртай тэр л дүрсээр амьтанд Ном заав, би.

“Сарва-шура, тийм болохоор олон байдлаар элдэв дүрсээр амьтанд Номыг заав. Энэ ямар учраас гэвэл, Сарва-шура, амьтан нугууд Номыг олон янзаар сонсохын адилаар тэдгээр үнэнч амьтад буяны үндсийг элдэв олон янзаар ургуулдаг буюу. Тэд өглөг элдэв зүйлийг өгөх буюу. Бинваад буяныг ч үйлдэх буюу. Өөрийнхөө тусад унтах

нойргүй үйлдэх буюу. Үхлийг дурьдан санаж бясалгах буюу. Тэдгээр нь тэр мэтээр үйлдэх ёстой буяны үйлд орох буюу. Тэдгээр амьтан Номыг сонссоны учирт урьдын буяны үндсээ дурьдан санах бөгөөд тэр адилаар хүмүүн болон тэнгэрүүдийн өнөд удаан, утга төгөлдөр, тус, амгалант болох болой.

“Сарва-шура, тэр мэтээр *Хос номын* зүйлийг сонссон даруйд хэмжээлшгүй их тус эрдэмт болох болой.”

Чингээд амьтан тэдгээр өөр хоорондоо ийн хэмээн өгүүлэлдэв: “Мөн түүнчлэн эдгээрээс гадна алин үйлдсэн, хураасан буянаар ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг илт төгсгөж, бурхан болох бөгөөд хамаг амьтанд тус амгаланг хүсэх буяны Номын үйл тийн боловсорно.

“Номонд сэтгэл итгэмжилсэн тэд ийн хэмээн өгүүлнэ: ‘Үнэхээр үзүүлсэн дагуу Ном буян байх болой’ гэж хэлэх төдийд ч амгалан жаргалангийн үр машид ихээр боловсорч, ханьцашгүй Номын амгаланг олох болой. Харин ном буян нь үгүй болой, номын чанадад одох нь байхгүй болой хэмээх мунхаг, тэнэг амьтдын тийн боловсролын их үр нь муу заяанд л одох болой. Тийм хүмүүс жич буцаж, муу заяаны газарт шулуудах болой. Найман галвыг хүртэл тамын зовлонг амсах болой. 12 галвыг хүртэл бирдийн оронд зовлон эдлэх болой. 16 галвыг хүртэл асурын дотор төрөх болой. 9000 галвыг хүртэл дүлбэн болон мах идэгч нарын дунд төрөх болой. 1 түм 4 мянган галвыг хүртэл хэлгүй болох болой. 1 түм 6 мянган галвыг хүртэл эхийн умайд үхэл егүүтгэх болой. 1 түм 2 мянган галвыг хүртэл бөөрөнхий махан овоолго болох болой. 1 түм 1 мянган галвыг хүртэл харалган сохор амьтан болж зовлон эдлэх болой. Эцэг, эх нь ийнхүү санах болой: ‘Бид нар хэрэггүй дэмий зовлонг амсах болой. Бид хүү төрүүлсэн нь хэрэггүй болой. Есөн сарыг хүртэл хэрэггүй дэмий хэвлийдээ тээжээ’. Даарах, халууцахын зовлон амсах болой. Өлсөх, ундаасахын зовлонг ихээр амсах болой. Энэ насанд ч элбэг зовлонг эдлэх буюу. Хэдий эцэг эх нь гэртээ хүүтэй боловч баяр баясгалан үгүй, эцэг эхийн горьдлого бүрэн тасрах юм.

“Сарва-шура, энэ мэтээр дээдийн Номыг тэвчсэн амьтас там болоод адгуусны төрөлд шулуудах бөгөөд тэд үхэхийн цагтаа ч гаслан зовлонгийн их хатгуулгаар хатгуулах буюу. Сарва-шура, ‘Ном буян буй болой. Номын чанадад одох буй болой’ хэмээн өгүүлэх төдийгөөр тэдэнд буяны ёзоор төрөх бөгөөд түүгээр 20 галвыг хүртэл умар зүгийн Уттара-куру (*Муухай дуутын*) тивд төрөх болой. 25 галвыг хүртэл Гучин гурван тэнгэртэй хувь сацуу төрөх болой. Гучин гурван тэнгэрээс үхэл егүүтгээд, умрын Уттара-куру тивд ч төрж болно. Эхийн умайд үл төрөх болой. 100 мянган ертөнцийн орныг ч үзэх бөгөөд тэр бүгдээрээ Сугавидын орон болно. Бурханы орон бүгдийг ч үзнэ. Үзээд тэнд орших бөгөөд тэндээ илт туулсан бурхан болж ч болно.

“Сарва-шура, тэгэхээр *Хос номын* зүйл энэ нь их хүчтэй болой. Хэн хүн энэ номд сэтгэлээр сүсэлснээр үхэл егүүтгэхийн цагт айдсаасаа салалгүйгээр эс орхигдох болой. Тэдгээрийн ёс суртахуун огоот ариусах болой.

“Сарва-шура, зарим үед: ‘Бурхад өдөр шөнөгүй олон амьтныг гэтэлгэж байгаа хэдий ч одоо болтол амьтны орон барагдаагүй л байна. Их зонхи нь бурхан болохын ерөөл талбих, бас нэг хэсэг нь өндөр язгуурт ертөнцөд төрөх, бас их зонхи нь гаслангаас нөгчихүйг олох бий. Ямар шалтгаанаар амьтан шавхагдашгүй олон болно вэ?’ хэмээн өгүүлэх амьтан олон байна.

Бас бус зарим тэрсүүдийн явдалтан, гүндүжүва, жэрбүва нар: ‘Буянтан Гаутама-тай очиж хэлэлцсүгэй’ хэмээн санав. Мөн 8 түм 4 мянган бярман болоод тэрсүүдийн явдалтан болоод гүндүжүва болон хэдэн зуун тоот жэрбүва мэт болон Ражагриха-гийн эргэн тойронд ирэх бий. Тэр цагт Бурхан бээр инээмсэглэн зохиов.

Ингээд бодьсадва, их бодьсадва Майтрея (*түөд: Жамбаа*) суудлаасаа босож, номын баринтигаа нэгэн мөрнөөс буулгаад, баруун өвдгөө газарт хатган, Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ямар үндэс байна, ямар шалтгаан байна? Туулсан бурхад мөшөөн зохиох, эс мөшөөхийн учир юу вэ, шалтгаан юу вэ?”

Бурхан зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Өнөөдөр Ражагриха энд их чуулган чуулах болно.”

“Бурхаан, хэн энд цуглах вэ? Тэнгэр, лус, ягчис, хүн, хүмүүн бусууд уу?”

Бурхан бээр зарлиг болруун: “Майтреяа, өнөөдөр энд тэнгэр, лус, ягчис, хүмүүн ба хүмүүн бус тэдгээр бүгд цуглана. 8 түм 4 мянган барамсай нар ч ирнэ. 1 сая 9000 тэрсүүд явдалтан гүндүжүва нар, жэрбүва нар мөн энд цуглаад, надтай хэлэлцэж үйлдэнэ. Эдгээр бүгдийн хүслийг амарлиулахын тулд Ном зааж өгсүгэй. Тэдгээр бярман бүгдээр ханьцашгүй туулсан бодь сэтгэлийг олно. 9,000 сая тоотой тэрсүүдийн явдалтан, гүндүжүва, жэрбүва нар бүгдээрээ “үргэлжид орохуйн” үрийг олно. 1 сая 18,000 сая тоотой лусын хаад ч ирсэн байх бөгөөд тэд бүгд надаас Ном сонсоно. Сонсоны дараа тэд бүгдээр ханьцашгүй, үнэхээр туулсан бодь сэтгэлийг олно. Ариун тэнгэрийн язгуурын 60,000 сая тоотой тэнгэрийн хөвгүүд ч ирнэ. 30,000 сая тоотой чөтгөр шимнусын аймаг, нөхөр сэлттэйгээ ирнэ. 12,000 сая тоотой асурын хаад ирнэ. 500 гаран хаад ч нөхөр сэлттэйгээ Ном сонсохоор цуглана. Эд бүгдээр надаас Ном сонсоод, ханьцашгүй, үнэхээр туулсан бодь сэтгэлийг төрүүлнэ.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Майтреяа бээр Бурханы өлмийг тэргүүнээр мөргөж, Бурханыг гурвантаа эргээд, тэрээр үл үзэгдэх болов.

Дараа нь бодьсадва, их бодьсадва Сарва-шура суудлаасаа босож, номын баринтагаа нэгэн мөрнөөс буулгаад, баруун өвдгөө газарт хатган, Бурхан байгаа зүгт алга хавсран, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, 500 хаан тэдгээрийн нэр хэн бэ?”

Бурхан зарлиг болруун: “Сарва-шура, сонсогтун. Нанда (*түвд: Жалбугаваа*) хэмээх, Упананда (*Жалбунига*) хэмээх, Жинаршабха (*Жалбучүнчог*) хэмээх, Брахма-сена (*Жалбуцамбийндэ*) хэмээх, Брахма-гхоша (*Жалбуцамбийян*) хэмээх, Сударшана (*Жалбуданазэй*) хэмээх, Прияя-сена (*Жалбузавийндэ*) хэмээх, Нанда-сена (*Жалбугавийндэ*) хэмээх, Бимби-сара (*Жалбусүгжаннинбо*) хэмээх, Прасена-жит (*Жалбусалжал*) хэмээх, Вирудхака (*Жалбунагжибуу*)

хэмээх тэргүүтэн 500 шахам хаад тэдгээр бүрт 100,000 живаа бараа болоочид байна. Хаан Вирудхака-гаас бусад тэдгээр бүгд нь ханьцашгүй, үнэхээр туулсан бодийн хутагт оршсон ямагт болой. Дорно зүгээс 30,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Өмнө зүгээс 50,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Өрнө зүгээс 60,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Умар зүгээс 80,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Доод зүгээс 90,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Дээд зүгээс 100,000 сая тоотой бодьсадва нар дээшлэв. Тэд бүгдээр аравдугаар газарт оршсон ямагт болой.”

Тэдгээр бодьсадва бүгдээр Бурхантай уулзахын тулд Ражагриха хаана байгаа болон Бурхан байгаа тэр газар дээшлэв. Бодьсадва тэдгээр бүгдээр ханьцашгүй үнэхээр туулсан бодийн хутагт үнэхээр оршсон ямагт болой.

Чингээд Бурхан бээр бодьсадва, их бодьсадва Сарва-шурад зарлиг болруун: “Сарва-шура, та арван зүгийн ертөнцийн оронд очоод, бодьсадва бүгдэд: ‘Өнөөдөр Бурхан, Ражагриха хэмээх их балгадад Ном заах болой. Арван зүгийн ертөнцөд орших та бүгдээрээ алгаа хавсарч залбирагтун’ хэмээн өгүүлж үйлдээрэй. Тэд бээр үүнийг ойлгосон тэр даруйд та өөрөө Ном сонсохоор жич залраарай.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура суудлаасаа босож, Бурханы өлмийд тэргүүнээрээ мөргөөд, Бурханыг гурвантаа эргээд, рид хувилгааны хүчээр үл үзэгдэх болов. Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура арван зүгийн ертөнцийн оронд одож, тэндэхийн бодьсадва нарт: ‘Өнөөдөр Бурхан бээр Ражагриха их балгадад Ном заах болой. Та бүхэн ‘Сайн болтугай’ гэж айлдагтун, залбирагтун. Тиймийн учир нь та бүхэн өнөөдөр агуу их тус, амгаланг олох болой’ хэмээн тушаав.

Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура арван зүгийн ертөнцийн оронд одоод, хамаг бурхад бүгдийг өргөн хүндэлсэн бөгөөд бодьсадва нарт захиа хүргэсэн энэ адил нь үлгэрлэвээс, бяраа чадал төгөлдөр эр хүн нэг удаа инчдэх төдийн хугацаанд бодьсадва, их бодьсадва Сарва-шура, Ражагриха их балгад хаана байгаа, Бурхан хаана заларсан тэр газар хүрч ирээд, Бурханы мэлмийн өмнө

суун авай. Тэр цагт бярман нар бас бус тэрсүүдийн явдлаар явагчид, гүндүжүва, жэрбүва нар ч цуглав. Тэнгэр, лус, ягчис, олон хүмүүс, 500 шахам хаад, бараа бологч нарын хамт цуглав. Нүгэлт шулмасын аймгийнхан 33,000 сая бараа болоочдын хамт цуглав.

Мөн тэр цагт Ражагриха их балгад машид ихээр хөдлөв. Чингээд арван зүгийн ертөнцийн орон нугуудад тэнгэрийн зандангийн үртсэн хур буув. Тэнгэрийн цэцэгсийн хур ч машид ихээр бууж, Бурханы тэргүүн үснэрийн завсраар сайтар давхарлан оршив. Мөн тэр цагт Бурханы мэлмийн өмнө тэнгэрийн эрхэт Индра (*Хурмаст тэнгэр*) бээр очир сүрчив. Тэр цагт дөрвөн зүгээс дөрвөн их салхи гарч, Бурхан заларсан тэр их балгад руу салхи салхилуулж, далбаа хийсгэж, элдэв шороог хөөж балгадын гадна гаргаж, арван зүгийн ертөнцийн оронд анхилам үнэрт усны хурыг буулгав. Арван зүгийн ертөнцийн оронд удвал, лянхуа, гүмүда, цагаан лянхуа зэрэг цэцэгсийн хурыг ч машид буулгав. Тэдгээр цэцэгс бүгдээр амьтан тэдгээрийн орой тэргүүн дээр цэцэгсийн шүхэр болон оршив. Тэрчлэн бурхадын үснэр, тэргүүний дээрх огторгуйд 84,000 давхарлагат ордон болон сүндлэв. 84,000 ордны дотор долоон зүйлийн их эрдэнээс бүтсэн 84,000 ширээ бүтэв. Тэдгээр ширээ бүгд дээр бурхад оршин Ном заана. Чингээд гурван мянган ертөнцийн их гурван мянган ертөнц бүгдээр зургаан зүйлээр хөдлөв.

Чингээд бодьсадва, их бодьсадва Сарва-шура бээр Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхан багшаа, Ражагриха их балгадад энэ адилын рид хувилгаан гардаг нь ямар учиртай, ямар шалтгаантай вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Энэ адил буюу, үлгэрлэвээс, Хаан бээр нэгэн догшин хилэнт, амиа хоохойлогч, би-д баригч, өөрийгөө ихэд бодогч, үгээгүй ядуу хэн нэгний толгойг илжээ гэж бодъё. Тэр хүн хааны ордны үүдэнд ирээд дотогшоо орох гэтэл нь хааны түшмэд, бараа бологчид барин авч, тал талаас нь зоджээ. Тэр цагт нөгөө хүн зугтааж зүтгэсээр, ‘дотогшоо орох ёстой’ гэж орилохыг нь хаан сонслоо гэж саная. Тэр цагт: ‘Хэн нэг хүн эргэлзээгүйгээр намайг алахыг хүснэ’ гэдэг бодол хаанд төрнө биз дээ. Хаан хилэгнэж, бараа болооч нартаа: ‘Тэр хүнийг

аглаг ууланд аваачаад алагтун. Бараа болоочид аав, ээж, хөвгүүд, хүүхэд, эр, эм зардас, тушаал гүйцэтгэгч бүгдийг нь ч алагтун’ гэж тушаана. Ийнхүү тушаал өгсөнөөр тэд бүгд алагдаж, түүний элгэн садан бүгдээр барагдашгүй ихээр зовж шанална. Үүнтэй жишихүл, Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, ялж төгөлдөр нөгчигсөн бурхан Ном заасан даруйд, дээрх ууртай догшин хүн адилаар нялхас эгэл ардууд нь Тэрчлэн заларсанаа сүслэх мэт боловч Бурханы өнгө дүрс, тэмдэг, шинж зэргийг өөрийнхөөрөө ойлгоно. Энэ нь л Бурханы лагшин болой гэх зэргээр бодно. Тийм байдлаар хичнээн олон Ном заалгаж, сонсовч улам л уур хилэн нэмэгдсээр, ямар ч хэрэггүй, тусгүй зүйлийг ч чалчих болно. Хамаг юмс үзэгдлийг өөрийнхөө эд шиг санан, минийх хэмээн үзэх, минийх хэмээх шунах бодолдоо баригдсан цагт тэд Номын зүйлийг сонсож чадахгүй бас дуурсгаж, зааж ч чадахгүй. Хэн нэгэн судар болоод наанадаж нэг шүлэг эсвэл нэгэн үлгэр төдийг тайлбарлаж байсан ч ‘Бид мэдэж байна’ гэгцгээх ба тэд ерөөс түүнийг барихгүй бас чихээр ч үл сонсох бий.

“Яагаад ийм болов гэж гайхаж байж магадгүй. Учир нь тэд бүгдээр үүндээ л шунаж, догширч байх. Тэдний хэтэрхий их мэдлэгээс болж тэд юунд ч анхаарах сөгөөгүй болно. Нялхастай нөхөрлөх эгэл ардууд энэ адилын Номыг эзэмших үйлд чадал үл хүрнэ. Тэд энэ адилын Номыг эзэмших үгийг үл сонсоно. Тэдний хэтэрхий их мэдлэгээс болж тэд омгорхох болно. Энэ адилын хүмүүс зөвхөн өөрсдийнхөө л зохиолыг туурвина. Мөн тэд өөрсдийн зохиолдоо удиртгалыг ч бичнэ. Тэд өөрсдийгөө болон хамаг ертөнцийг ч мэхэлнэ. Тэд ямар ч сэтгэлгүйгээр орон балгадын (улс гүрний) идээг идэж шамшигдуулна. Тэднийгээ ч сайтар шингээж чадахгүй. Үхэхийн цагт их аюул ирэх болой.

“Тэдгээр амьтан түүнд ийн хэмээн өгүүлэв: ‘Та биднийг хөлгөнд сургачихаад яагаад өөрийгөө дарж чадаагүй байна вэ?’

“Тэдэнд ийн хэмээн өгүүлэв: ‘Нөхдөө, би өөрийгөө дарж чадахгүй нэгэн болой.’

“Амьтан тэдгээр элдвээр гаслан дуугарч, бусдын үйлийн уршгаар биш өөрийн үйлийн шалтгаар олон тоот садан нөхөд нь гагц тэр хүний тулд алагдахын адилаар эдгээр амьтад ч үхэхийн цагт гаслах дууг гаргаж, нүглийн нөхрийн учраас там, адгуусны оронд очихоо үзэх болно.

“Үүнтэй адилаар бярман, тэрсүүд та нарт би өгүүлье: ‘Та нар омгорхож бүү үйлд.’

“Энэ адил буюу, үлгэрлэвээс даль жигүүр нь гүйцээгүй шувууд тэнгэрийн ертөнцөд зорчиж, огторгуйд нисэж чадахгүйтэй адил тэр адилаар рид хувилгаан та нарт байхгүй тул гаслангаас нөгчсөн нирвааныг олж чадахгүй билээ. Учир нь үйлийн эрхээр шувууны төрөлд төрж, энэхүү бие нь өнө удалгүй эвдрэх бөгөөд үхэх буюу.

“Үхэхийн цагт амтлах сэрэхүйгээ алдахын цагт тэд: ‘Бид яагаад энэ биендээ шунан барина вэ? Бид ертөнцийн тэнгэрийн амгалан болон хүмүүний ертөнцийн амгаланг үл эдэлсэн буюу. Нирвааны амгаланд ч үл орших буюу. Бид энэ биедээ хэрэггүй дэмий шунах тул хаашаа одох бол? Бидний энэ шүтээн хэн болох бол, хаана төрөх бол, яаж үхэх бол?’ гэж бодоцгоож бүгд айцгаав.”

Чингээд Бурхан бээр бас бус тэрсүүд явдалтан бөгөөд гүндүжүва, жэрбүва нарт зарлиг болруун: “Та нар их эрдэнийн энэхүү Замбу тивт ирчихээд итгэл бүү алдагтун. Та нар Ном чухаг дээдээс гадуур бүү явагтун. Та нар над адилын бурхадаас юу хүссэнээ асуугтун. Би санаа бодол бүхнийг төгсгөж үйлдмой.”

Чингээд бирман, тэрсүүд явдалтангууд, гүндүжүва, жэрбүва нар бүгд суудлаасаа босож, нөмрөгөө буулгаад, алгаа хавсран бурханд айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөн, түүнчлэн заларсан бурхан бээр өдөр, шөнийн алинд ч амьтан бүхнийг зовлонгоос огоот гэтэлгэвч амьтны орон эс багасах хийгээд эс дүүрэв. Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар шалтгаан, ямар үндэсний учраас алин амьтан тэдгээр нь төрөх ба түрдэхийг тэнцүү үзүүлдэг вэ?”

Чингээд Бурхан бээр бодьсадва, их төрөлхтөн Бхайшажя-сэна (монгол: *Оточийн аймагт, түвд: Манжийдэ*)-д зарлиг болруун:

“Тэрсүүд нар их гэмшлээ арилгах агаад Номын их зулыг бадруулж үйлдэхийн тухайд их хөө хуягийг өмсөж, гарвал түүхийг асууж байна. Хожмын цагт хөгшин залуу амьтан нугууд төрөх бөгөөд түрдэхийг ухаарах цаг ирнэ. Бхайшажяа-сэна, хөгшин өтгөс нугууд ч идэр залуугийн адилаар юу ч мэдэхгүй байх бий.

“Бхайшажяа-сэна, энэ адил буюу. Үлгэрлэвээс зарим хүмүүс үс зүсээ угааж, шинэ хувцсыг өмсөж, гэрээс гарч явахад түүнийг үзсэн заримууд, ‘сайхан шинэ хувцас өмсчихжээ’ гэж ярих бий. Зарим хүмүүс толгойгоо угаагаад, хуучин муу хувцсаа цэвэрлээд, зарим нь хувцас дээлээ хэдий угаасан ч муухай харагдах бий. Хувцас нь муухайн адилаар, Бхайшажяа-сэна, энэ Замбу тивийн хөгшид сайхан бус юм. Идэр залуу амьтан төрөх, үхэл егүүтэхийг үзүүлнэ.”

Чингээд бярман болоод бас бус тэрсүүд явдалтнууд, гүндүжүва тэргүүтэн тэдгээр суудлаас босож, Ялж төгөлдөр нөгчигсөн түүнээ ийн хэмээн айлтгав: “Бурхаан, бидний дотор залуу нь алин, хөгшин нь алин бэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Та нар ахин дахин там, бирд, адгуус зэргийн оронд элдэв зовлон амсан эдэлсэн хэдий ч гэсэн өнөөг хүртэл түүндээ огт ханаж цадахгүй явж байгаа чинь хөгшин болсны шинж.”

Тэдгээр бярманууд тэнд байгаа лусын хаад бээр бурханд ийн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, дахин ертөнцийн зовлонгийн далайд элдэв нажодыг амсахгүйг хүснэ.”

Бас бус тэрсүүд явдалтангууд хийгээд гүндүжүва, нүцгэчин нар ийн хэмээн айлтгав: “Алин заримууд залуу байсан хэдий ч үнэн жам ёсыг ухаарах чадалгүй болой.”

Ийн хэмээн зарлиг болсон ба Ялж төгөлдөр нөгчигсөн түүнээ бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, юуны тухайд эдгээр олон амьтныг хотол өдөөх бэрхтэй хэмээн болгоов?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, сонсогтун. Бурхад ертөнцийн аймаг бүгдийг илт болгоох болой.”

Чингээд 94,000 сая залуус Бурханы мэлмийн өмнө суугаад, Бурханд мөргөсөн ч үгүй, үг өгүүлсэн ч үгүй дээшлэв. Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэна ийн хэмээн айлтгав: “Бурхаан, эдгээр амьтад танаас юу ч үл асууна. Бүгдээр юу ч үл ярих, бас эргэл мөргөл ч үл үйлдэнэ. Бурханаас ингэж үл айлтгахын учир шалтгаан юу юм болоо?”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, сонсогтун. ‘Идэр залуус үнэнийг илтээр онож чадаагүй болой’ хэмээгч амьтан тэдгээр нь залуу амьтад болохыг Бхайшажья-сэна, та ухаараарай.

Тэдгээр амьтад ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, бид залуу, идэр залуу болой. Түүнчлэн заларсаан, бид идэр залуу амьтан болой.”

Бурхан бээр зарлиг болруун: “Амьтан эдгээр нь ертөнцийг илтэд үзмүй. Одоо ертөнцийн хэмжээг өөрийн биенээс та нар үзүүлсүгэй.”

Тэр цаг тэр үед 94,000 сая идэр залуу амьтад биеэ орхилгүй, огторгуйн оронд оршсон бөгөөд арван газрын эрдмийг олсон болой.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэна ийн хэмээн айлтгав: “Зовлонг огоот барж үйлдэхийн тухайд бас огоот арилгаж үйлдэхийн тухайд хичээн шамдаж байдаг амьтан өөрийн хүссэнийг сайтар олсон болой. Ялж төгөлдөр нөгчигсөөн, эдгээр амьтан нь өнөөдөр төрсөн бөгөөд эдгээр амьтан нь өнөөдөр төгс гэтэлсэн бөгөөд бүгдээрээ аравдугаар газрыг машид олсныг нь үзлээ, би.”

Чингээд бярман, бас бус тэрсүүд явдалтнууд, гүндүжүва, жэрбүва, лусын хаад, хилэнцэт шимнусын аймгийнхан нөхөр сэлт бүгд мэхлэхээр ирж, Бурханд ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, өнөөдөр бид нар Бурханы хажууд ирсэн учраас номын зүйл энэ адилаг сонсож, бид нар бурханы амгалан тэр мэтийг олох болтугай. Ертөнцийн оронд Тэрчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхан энэ адил болох болтугай.”

Бурхан зарлиг болруун: “Тэрчлэн билээ, эрхэмүүд ээ, та нар Бурханы хажууд ирсэндээ гол нь биш, та нар *Хос номын* зүйл

эдгээрийг сонссоноор ханьцашгүй, үнэхээр туулсан бодийн хутгийг олох болно. Цаашлаад та нар өнө их удалгүй ханьцашгүй, үнэхээр туулсан бодь хутагт хүрч, илт туулсан бурхан болох болно.”

Бурхан бээр эдгээр үгийг айлдсан даруйд залуу идэр тэрсүүд тэдгээр бүгд үл төрөхүйн номд тэсвэрийг олов. Бүгдээрээ арван газарт орших бодьсадва болж, тэр бодьсадва бүгдээр дээрхи огторгуйд долоон дал модны өндөрт хөөрч, долоон их эрдэнээр дүүрсэн орд харшийг босгож, Бурханд тахил болгон өргөх ба элдвийг рид хувилгаанаар адистидлан, рид хувилгааны илт хуран мэдлийг илт болгон үйлдвэй. Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн түүний тэргүүн дээгүүр нисэж, Бурханд элдэв сайхан цэцэгсийг өргөж, бурхад бүгдийг сэтгэлдээ бодож, өөрийн биеэ ч бурхан хэмээн бодох хуран мэдлийг үүсгэв.

Олон зуун мянган живаа тэнгэрийн хөвгүүд ч Бурханы дээрээс цэцэгсийг өргөж, ийн өгүүлэв: “Их буянт Гаутама бол их олз болой. Их орон болой. Ертөнцийн итгэл болой. Самадийн хүчийг ологч болой. Мэргэдийг төрүүлэх дээд мэргэн билээ. Мөн алив энэ мэтийн амьтан бүхнийг мэргэн аргаар зовлонгоос төгс гэтэлгэн зохиогч бөгөөд ганцхан сайн зарлиг төдийгөөр, түүнээс илүү олон амьтныг зовлонгоос огоот гэтэлгэгч болой”.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна суудлаас босож, номын баринтагаа нэгэн мөрнөөс буулгаж, баруун өвдгөө газарт хатган, Бурхан байгаа тэр зүгт алгаан хавсран мөргөөд, Бурханаа ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ямар шалтгаан, ямар нөхцөлөөр тэдгээр язгуурын хөвгүүд ийн хэмээн өгүүлж, элдэв рид хувилгааныг олонтаа үзүүлнэ вэ? Бурхан таныг олонтаа магтана вэ?”

Бурхан зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, сонсогтун. Тэд чинь намайг магтсан бус өөрсдийн биеэ магтаж, өөрсдийн биеэ Номын дээд суудалд агуулсан буюу. Өөрийн биенээс Номын гэрлийг цацруулах буюу. Тэдгээрийг ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг олж, илт туулсан бурхан болоход бурхад ч туслах болой. Тэдгээр нь илт туулсан бурханы хутгийг олоод, Номыг заах болой.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэна ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн,

Үнэхээр туулсан бээр өдөр, шөнөгүй олон амьтныг огоот гэтэлгэх боловч одоо хэр нь амьтан барагдахгүй л байна.”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, та эхлээд Бурханаас энэ утгыг асууя гэж санадаг чинь сайн болой. Сайн болой, сайн болой. Бхайшажяа-сэна, энэ адил буюу. Үлгэрлэвээс зарим амьтан баян чинээлэг, эд хөрөнгө ихтэй, эд таваар, тариа будаа, хүү сан, барлаг зарц олонтой байдаг. Цаашлаад эр, эм албат боолууд, туслахууд, тараг сүү боловсруулах албат олонтой. Эд таваар нь уул овоо мэт, хотол баясгалант хүрээ цэцэрлэгтэй байх нь бий. Мөн энэ адил буюу, арвай, тутарга, овъёос, вандуй, сараам зэрэг үр тариатай байх нь бий. Тэр хүмүүн хаврын цагт тарианыхаа хөрөнгийг суулгаж, бас дараа нь тэр хөрөнгөө манаж боловсруулж, боловсорсон үрээ тус тусад нь хадгалах зэргээр ажиллах бий. Үлдсэн жаахан хэсгийг хавар хүртэл идшиндээ хэрэглэх, бас дахиад тариалах ч бий. Энэ мэтээр амьтан нугууд урьд хураасан тэдгээр үйлээ барах ба дахин бас буяны тариаланг эрэлцэж, буяны үндсийг суулгах болой. Буяны үндсийг суулгасан бол буян Номд шамдаж хичээж бүтээх ба Ном буянаа улам арвижуулж, түүндээ баясах бишрэхийг үйлдэх болой. Бхайшажяа-сэна, буянд баясаж, бишрэхийн сэтгэлийн үрээр олон мянган живаа тоот галвыг хүртэл буян үл барагдах болой. Тэр адилаар бодьсадва нар анх бодь сэтгэлийг үүсгэснээр буяны үндэс үл шамшаагдахын жамт болох бөгөөд товчилбоос, ном бүгдийг машид мэдэх болой.”

“Бурхаан, бодьсадва нар анхлан бодь сэтгэлийг олж байгаагаа зүүдэндээ яаж үзэх вэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, бодьсадва нар анхлан бодь сэтгэлийг олохын үест зүүдэндээ олон аюулыг үзэх бий. Яагаад гэвэл, үйл бүгд нь төгс арилж буйн учир. Харин хилэнцтэн амьтанд бол барагдашгүй зовлон нь үл арилах болой. Тэр цагт хилэнцэт зүүд үзэгдсэн ч бодьсадва нар айдаггүй болой” хэмээв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, бодьсадва нарт анх бодь сэтгэл төрөх цагт зүүдэнд нь аймшиг хэрхэн үзэгддэг юм бол?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, машид их бадарсан

дүрэлзсэн гал үзэгдэх бий. Үүнийг бодьсадва нар нисванис бүхэн нь шатаж байгаа нь тэр хэмээн ухаарна. Бхайшажья-сэна, хоёрдугаарт, бодьсадва нарт анх бодь сэтгэл төрөх цагт ус давалгаалж, машид хүчтэй давалгаалах ч үзэгдэх бий, тэд үл айна. Бхайшажья-сэна, учир нь гэвэл мунхагийн хүлээс бүхэн алдарч, хилэнц арилж байгаа нь тэр болой. Бхайшажья-сэна, гуравт, анх бодь сэтгэл олж байгаа бодьсадва нарын зүүдэнд их аюул үзэгдэх бий” хэмээв.

“Тэр алин бэ?”

Бурхан зарлиг болруун: “Толгойны үсээ хяргууллаа гэвч, Бхайшажья-сэна, тэд түүнээс үл айна. Учир нь гэвэл тэд, ‘Би өөрийн шунал, омог, мунхагаа хяргууллаа. Би бээр сансарын зургаан төрлийн зовлонгоо ялагч билээ’ хэмээн бодно. Чингэхээр тэр амьтан тамд орших бус, адгуус, бирдэд ч орших бус, асур нарын дотор ч орших бус, лус нарын дотор орших бус, тэнгэрсийн дотор орших бус. Бхайшажья-сэна, бодь сэтгэл анх төрсөн бодьсадва нар нь бурханы арилсан оронд төрөл авах болой. Бхайшажья-сэна, хожмын хойд цагт зарим бодгалууд бодь сэтгэлд ерөөн зоривоос тэд их тангараг авах учиртай. Тэднийг басамжилж үйлдэвч тэд сэтгэлээ үл алдан, зориг зүрх ч үл алдана.

“Бхайшажья-сэна, олон Номыг үзүүлэв. Хэдэн зуун мянган живаа тагтаг галвын завсарт би хатуужил бэрхшээл олныг эдэлсэн ч, Бхайшажья-сэна, эд хөрөнгийн тухайд юм уу, амьжиргааны тухайд юм уу, эрх хүчийн тухайд огтоос хатуужилд оршоогүй билээ. Бхайшажья-сэна, номын мөн чанарыг ухаарч мэдэхийн тулд хатуужлыг судалсан буюу. Гэсэн хэдий ч *Хос номын* зүйл эдгээрийг сонсох хүртлээ би ханьцашгүй, үнэхээр туулсан бодийн хутгийг олоогүй бөгөөд сонссон тэр өдөр л ханьцашгүй туулсан бодийн хутагт хүрч, илт туулсан бурхан болвой.

“Бхайшажья-сэна, номын зүйл энэ нь маш гүн болой. Номын зүйл үүнийг олох нь маш бэрх болой. Бхайшажья-сэна, бурхад гарах нь ч машид ховор болой. Бхайшажья-сэна, номын зүйл эдгээрийг баригч нар нь ч олоход машид бэрх болой. Хэн хүн энэхүү номын зүйлийг сонссон тэд бүгд ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагт хүрч, илт бурхан болох болой.

Бхайшажья-сэна, мянган галавт зовлонг үл эдлэх болой.
Бурханы орон огоот арилсаныг сайтар олох болой.
Хорихуй болон мөрийн ч үнэнийг машид мэдсэн хувьт болох болой.
Орон вишайг сайтар мэдсэн хувьт болох болой.
Буяны орныг машид мэдсэн хувьт болох болой.
Илт мэдэл болоод буяны орныг машид мэдсэн хувьт болох болой.
Буяны орон болоод хорихуйг машид мэдсэн хувьт болох болой.
Бхайшажья-сэна, юуны тулд ‘хорихуй’ хэмээсэн бэ?”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, Номын орон хэмээх утга хэмээсэн буюу.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, Номын орон гэж юу вэ?”

“‘Ном’ хэмээх нь хичээж туурвих ямагт болоод, ёс суртахууныг сахих ямагт болоод, ёс суртахуун төгөлдөр байх зэрэг нь Номын хүү сан болой. Ялж төгөлдөр нөгчигсөөн, Үүнээс Номын хүү сан гарах болох нь ээ.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, та Бурханаас энэ адилын утгыг асууж санадаг чинь сайн болой, сайн болой” хэмээв.

“Бурхад юуны тулд энэ ертөнцөд залардаг юм бэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, алин олныг сонссон, сайтар ихийг мэдсэн тэд л бурхад юуны тулд залардгийг мэднэ. Тэд бурхад заларсныг мэдэх ба бурхад заларсан орон амгалантай байдгийг сайтар мэднэ. Хэзээ бурхад ертөнцөд заларсан цагт амьтан хүн бүгдээр хамаг номыг машид ухаарах болой. Мэргэн аргаар ном юмсыг машид ухаарах болой. Ертөнц болон ертөнцөөс нөгчигсөн ном юмсыг машид ухаарах болой. Ертөнц болон ертөнцөөс нөгчигсөн бэлгэ билгүүдийг машид ухаарах болой” хэмээв.

“Бэлгэ билиг ямагтыг оносноор хэрхэн гаслангаас нөгчигсөнийг олох вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, тэд Номыг сайтар ухаарснаар, сайтар онох болно. Бхайшажья-сэна, тэд нар тэрчлэн

дээдийн Номыг хураангуйлж машид ухаарах цагт анхны үрийг олно. Номыг хэрхэн сонссон ёсоор барьж чадвал тэд Номыг эрхшээх болно. Бхайшажяа-сэна, энэ адил буюу, үлгэрлэвээс наймаа хийх гэж байгаа заримууд мянган лангийн алтыг авч, ашиг хонжооны тулд гадагш аваачих тэр цагт ээж, аав нь ийн өгүүлэх: ‘Хүү минь ээ, энэ мянган лан алтыг ав. Бидний болоод бусдын алтыг сайн авч яваарай’ гэж захиана.

“Нөгөө худалдаачин алтаа аваад явжээ. Нэг мэдэхэд нэг сар өнгөрсөн байв. Хамаг алтаа үрж зарж гүйцэв. Чингээд ихэд зовлонт болов. Зүрх сэтгэл нь гаслангаар хатгуулж, ичиж зовон, өөрийн гэртээ ч харьсангүй. Тэр цагт ээж, аав нь сонсож сэтгэлээр унажээ. Тэдний зүрх нь гаслангийн хатгуулгаар хатгуулж, дээл хувцас нь ч урагджээ. ‘Энэ муу хүү манай гэрт хүү минь болж төрчихөөд, гэр орныг минь түйвээж, амь зуух аргагүй болгов. Тэр бидэнд ямар ч тус болоогүй, харин биднийг их зовоов. Биднийг боолын боол болгов’ хэмээн тэд цөхөрч уйлалдав.

“Эх эцэг нь сэтгэлээр унаж, үхэв. Эх, эцэг нь гомдож, өнгөрснийг сонсоод, хүү ч сэтгэлээр унаж, үхэл егүүтгэсэн гэдэг. Бхайшажяа-сэна, Түүнчлэн залрагсад бээр энэ бүхний учрыг номлосоор байтал хэн хүмүүс номд эс сүсэлвээс, горьдлого тасарч, үхэхийн цагт тэд гаслангийн хатгуулгаар хатгуулж, үхэл егүүтгэх болой. Дээрх эцэг, эх хоёр алтны төлөө шаналж, зүрх нь гаслангийн хатгуулаар хатгуулж, өвөр болоод бусад бүгдийн алтнаас болж зовж үхсэнтэй адил буюу. Бхайшажяа-сэна, алин хэн хүн хэзээд дээдийн номд эс сүслэвээс л тэд бүгд хожим үхэхийн цагт боол зардас уухилан орилох мэт дууг хадааж, зовлонт амсуургыг эдлэн, урьд хураасан буянаа юу ч үгүй барчихаад, хойшоо залгах сайн буяны залгамжааг ч үйлдэлгүй өнгөрөх нь бий. Тэр хүмүүсийн зүрхэнд гаслангийн өргөс хатгаж, тэр цаг тэр үед тамын орон, адгуусны орон, эрлэг тамын ертөнцөд тэсэшгүй их хатуу зовлон эдлэхээ мэдрээд үхэхийн цагт ч ийн хэмээн санах вий: ‘Алин там, адгуус, бирд хийгээд эрлэг тамын ертөнцийг үзэхгүй байх арга болоод зовлонг эдлэхгүй байхын аргыг надад хэн зааж өгөх бол?’

“Нөгөөх хүүгийн эцэг эх ийн өгүүлэх болов уу:

“Хөвгүүн минь! Өвчин хэмээх их аюул
Бүү ирээсэй гэж ихэд шаналах,
Тэр хэрхэн билээ?
Өвдөөд айж үхэх нь олонтаа,
Гэтэл хүү минь өвдөж үхсэнгүй.
Өвчний зовлон аюулаас
Чи ангид билээ.’

‘Миний сүнс хаагдах тэр цагт
Биеэн би лавтай хорлох,
Үе гишүүн бүгд зовлонг болох,
Үхнэ гэдгээн би тэр цагт ухаарах.

Би нүдээр үл харах,
Би чихээр үл сонсох болой.
Хамраар ч үл мэдрэх бөгөөд
Биеэр ч юу урлахаа үл мэдэх.
Үе гишүүн бүгд зовлонг болох бөгөөд
Мод адил сэтгэх бодох зүйл үгүй.
Миний үхэл ирээгүй хэмээн өгүүлээд
Ээж минь, намайг зоригжуулаарай.’

“Эх өгүүллрүүн:

‘Хүү минь ингэж бүү өгүүлэгтүн.
Ингэж намайг бүү айлгагтун.
Чиний бие аймшигт гаслангаар нэрвэгдсэн тул
Элдэв юмсыг үзэх болно.’

“Хүү өгүүллрүүн:

‘Биенд зовлон юу ч алга,
Өвдөх юм алга, зовох юм алга,
Машид барагдашгүй үхэл л үзэгдэнэ.
Миний биеийг зовлон дарав.
Хамаг бие минь зовлонд
Хаа сайгүй хатгуулсныг үзээд

Хэнээс би аврал эрэх билээ?
Хэн намайг аварч чадах билээ?'

“Эх эцэг хүүд өгүүлрүүн: ‘Хүү минь,
Тэнгэр гэсгээж байгаа бизээ.
Гэвч тэнгэрт тахил өргөснөөр
Чи минь амьд гарах болов уу.’

“Хүү өгүүлрүүн:

‘Алив намайг амьдруулагч байваас
Та нар тэр мэтээр зохиосугай.
Хойш тавьж суулгүй түргэн
Тэнгэр удганаас асуугтун’ хэмээв.

“Чингээд нөгөөх эх, эцэг хоёр нь тэнгэрийн шүтээний дэргэд очоод, тэнгэрт хүж өргөв. Удган бээр тэнгэр нарт ч хүж өргөж, ийн хэмээн өчив: ‘Тэнгэр та нарыг гэсгээж байна. Тиймээс тэнгэрсийг хүндэлсүгэй. Амин тахилгын эд өглөгийг өргөсүгэй. Мал адгуус өргөсүгэй. Хүмүүнийг ч өргөсүгэй. Тэгвэл хүү тань өвчнөөс гэтэлнэ.’

“Эх, эцгүүд ийн бодов: ‘Бид чинь ядуу улс шүү дээ. Бид нар юугаа өргөх вэ? Хэрвээ тэнгэрсийг эс баясгаваас хүү минь үхэх буюу. Хэрэв баясуулж үйлдье гэхэд бид ядуу учраас хүмүүн болоод адгуус малыг хаанаас авах билээ’ гэж бодоод, машид түргэн эргэж гэртээ ирээд, гэрт байсан жаал жуул эд хогшлоо бүгдийг хамаад, мал худалдаж авахаар гарав.

“Бас тэр хоёр замд таарсан нэг хүнээс: ‘Нэг цэн алт өгөөч, арав хоноод өгье. Хэрвээ бид зээлээ төлж чадахгүй бол тэр өдрөөс эхлээд чиний боол болж ажлыг чинь хийе.’ гэж зээл хэлцэв.

“Ингээд тэр хоёр алтаа авч, хүн худалдаж авахаар явав. Нэгэн хүн худалдаж авсан ч тэр хүн нь алуулна гэдгээ эс мэдэв.

“Чингээд эцэг, эх хоёр нь төөрөлдөн, гэртээ буцаж эс ирэлгүй шууд шүтээний өмнө очиж, удганд: ‘Түргэлээрэй, золигт гаргаж тахил өргөөрэй’ хэмээв.

“Чингээд нөгөөх эх, эцэг хоёр мал ч алав. Хүнийг ч егүүтгэв. Удган тахил өргөлийг үйлдэхээр гал өрдөж суутал тэнгэр бууж ирээд, ‘Би хүүг чинь ивээлдээ авлаа’ хэмээхэд эх, эцэг хоёр баярлан хөөрөв.

‘Хүү минь л эдгэж байвал бид боол болох ч яамай’ хэмээцгээв.

“Эх, эцэг хоёр нь тэнгэр шүтээнээ тахьчихаад, эргээд гэртээ иртэл хүү нь өөд болж байхыг үзэв. Эх, эцэг энэлж шаналан, ээрч муурч, гаслангийн өргөсөөр зүрхээ хатгуулж, хамаг горьдлого нь тасран, үхэл егүүтгэв. Бхайшажья-сэна, энэ мэтээр хилэнцийн нөхдийг шүтэж бүү үйлдсүгэй.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, тэдгээр амьтад ямар оронд төрсөн болоо?” гэж асуув.

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, чимээгүй. Энэ мэтийг надаас бүү асуу.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, хэлэгтүн, Түүнчлэн залрагсаан, айлдагтун”.

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, ээж нь Уухилан дуудагч их тамд төрсөн болой, эцэг нь Хураан дарагч их тамд өрсөн болой. Хүү нь Машид халуун их тамд төрсөн болой. Удган нь Аюус тамд төрсөн болой” хэмээв.

“Бурхаан, нөгөө гэмгүй хүн хаана төрсөн болоо? Тэр ямар төрөл авсан болоо?”

“Бхайшажья-сэна, тэр хүн Гучин гурван тэнгэрийн оронд төрсөн болой.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар үндэс, ямар шалтгаанаар Гучин гурван тэнгэрийн оронд төрөх хувийг тэр хүн олсон бол?”

“Бхайшажья-сэна, сонсогтун. Үхэл егүүтгэх цагт тэр хүн Бурханд сүсэглэх сэтгэлээр ‘Бурхан дор мөргөмүй’ хэмээн нэгэнтээ хэлжээ. Бхайшажья-сэна, энэ буяны үндсээр тэр хүн 60 галвын туршид Гучин гурван тэнгэрийн орны амгаланг амсах бий. 80 галвын туршид төрлөө дурьдан санах бий. Төрөл тутамдаа гаслангийн

өргөснөөс хагацах бий. Тэнд төрсөн даруйдаа зовлон бүгд нь буцах бий. Тэдгээр амьтан бүгдээр нирваанд хүрч чадаагүй болой” хэмээв.

“Бурхаан, хамаг амьтан бүгдээр хэрхэн төгс төгөлдөр нирвааныг олох болоо?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, хичээл шамдлыг туурвисугай.”

“Хичээл шамдлыг туурвих гэж юу вэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, сонсогтун. Хичээн шамдсанаар олон сайн үр гарах болой. Энэ адил буюу: ‘Үргэлжид оршихуйн үр’ хэмээх нь хичээнгүйн орон болой. ‘Нэгэн удаа жич ирэх үр’ гэдэг нь хичээнгүйн орон болой. ‘Жич үл ирэх үр’ гэдэг нь хичээнгүйн үр болой. ‘Дайснаа дарсаны үр болон дайснаа дарсаны үрийг хорих’ хэмээгдэх нь ч хичээнгүйн орон болой. ‘Өөрөө ялгуугсадын үр хийгээд өөрөө ялгуугсадын үрийг мэднэ’ хэмээх нь ч хичээнгүйн орон болой. ‘Бодьсадвын үр хийгээд бодьсадвын орон’ хэмээх нь ч хичээнгүйн орон болой. Бхайшажяа-сэна, эдгээр бүгд нь ‘хичээнгүйн орон’ болой” хэмээн айлдав.

“Бурхаан, үргэлжид оршихуй хийгээд үргэлжид оршихуйн үр хэмээх нь юу болохыг үзүүлэгтүн.”

Бурхан бээр зарлиг болруун: “Энэ адил буюу, үлгэрлэвээс, нэг хүмүүн мод тарихаар суулгатал тэр өдөртөө үндэс нь нэгэн багцад төдий доош суув. Өөр нэг хүмүүн мөн адил мод тарьтал тэр өдөр нь салхи босож, нөгөө модных нь үндсийг ховхлов. Чингээд өнөө хүн модоо зөөж, нөгөө хүний газар очтол, ‘миний газрыг авах нь’ гээд хэрүүл тэмцэл гарчээ. Хоёр хүний хэрүүл тэмцэл болсныг хаан сонсоод, элч илгээж, ‘тэр хоёрыг надад авчрагтун’ хэмээжээ.

“Элч очиж, нөгөө хоёр хүнийг ‘хаан дуудаж байна’ гэж өгүүлтэл нэг нь их айж цочиж, муурч унаж гэнэ. Нөгөө нь айсан цочсон шинжгүй хааны дэргэд иржээ. Тэнд хүргэгдсэний дараагаар хааны ойролцоо сууцгаав.

“Хаан тэр хоёроос: ‘Та хоёр юунд хэрүүл тэмцэл болно вэ?’ гэж асуув.

“Хаан минь, сонсогтун. Бидэнд өөрийн гэх газар өчүүхэн төдий байхгүй, гэсэн ч атар жаахан газрыг олоод, мод суулгасан билээ. Салхины аясанд найгаад, өчүүхэн ургаж байсан ч ёзоор үндэс нь гүн суусангүй, навч, цэцэг, үр жимс ч ургасангүй. Хаантан минь, үндэс ёзоор нь багцадын чинээ доош ургасангүй. Надад ямар ч гэм байхгүй, гэтэл энэ хүн надтай тэмцэлдэж, ‘чиний буруу’ гэж хэрүүл үүдсэн болой. Намайг болгоогтун, хаан минь.’ хэмээв.

”Хаан гучин сая түшмэлүүдээ цуглуулж, ийн хэмээн тушаав: ‘Түшмэдүүд яригтун.’

‘Бид юун тухай ярих вэ?’ хэмээн түшмэдүүд асуув.

“Мод тарьсан тэр өдрөө үндэс ёзоор болоод навч, цэцэг, үр жимс нь ургахыг үзсэн үү, сонссон уу? Та нар долоо хоног юм уу, хагас сарын хугацаанд энэ хэргийг шийдэгтүн.”

“Түшмэл тэдгээр суудлаасаа босож, хаанд ийн хэмээн айлтгав: ‘Их хаан минь ээ, бид нар шийдэж чадахгүй, Ингэж нарийн хуваах гэрч бидэнд байхгүй ээ. Хаан минь, энэ их сонин юм байна. Түргэн тэр хүнээс лавлагтун. “Хэлсэн зүйл чинь үнэн үү? Хариултугай”’.

“Тэр хүн: ‘Их хаан минь, үнэн’ хэмээв.

“Хаан өгүүлрүүн:

‘Мод тарьсан тэр өдрөө
Үндэс нь доош суугаад, навч, цэцэг, үр нь гарчээ.
Яг тэр өдрөө гэж чи хэлж байна.
Энэ нь итгэхэд бэрх байна.
Энэ адилыг урьд үзэж, дуулсангүй.’

“Чингэтэл нөгөө хүмүүн алгаа хавсран,
Хаанд ийн хэмээн өгүүлэв:
‘Та өөрөө нэг мод тариад
Хэрхэн үндэслэхийг хараарай.’

“Чингэтэл гучин сая түшмэд босож ирээд, нөгөө хоёр хүнийг шоронд хорив. Хаан тэрээр нэгэн мод суулгахад, тэр модны үндэс ч суусангүй, навч, цэцэг, үр нь ч гарсангүй. Хаан ихэд уурлаж: ‘Та нар түргэн явж, мод унагах сүх авчрагтун’ гэж өгүүлэв. Тэр даруйд авчирсан агаад нөгөө хүний тарьж ургуулсан модыг үзээд хаан ихэд хилэгнэж, навч, цэцэг, үр жимсийг нь тасалж, модыг хугальюу гэтэл нөгөө нэг мод нь арванхоёр мод болж ургав. Арванхоёулыг нь тасалтал их эрдэнийн долоон үндэс сэлт, навч сэлт, үр жимс бүхий хориндөрвөн мод болж ургав. Ингээд хориндөрвөн мод бүгдээс нь алтан хонгорцог, алтан өдтэй долоон эрдэнийн шувууд хориндөрвөн ширхэг ургав. Хаан улам уурсан, гартаа сүх бариад цавчиж эхэлтэл модны холтосноос рашаан ус гарав. Хаан улам уурсаж, нөгөө хоёр хүнийг шоронгоос авчрахыг тушаав. Түшмэдүүд, ‘за’ хэмээн гүйлдэцгээж, нөгөө хүнийг гаргаж ирээд мод байгаа газар авчрав.

“Хаан өгүүлрүүн: ‘Нэг модыг тасалтал хоёр болж нэмэгдсээр хориндөрвөн мод болчихлоо. Энэ модыг чи тарив уу? Миний тарьсан модонд үндэс, навч, цэцэг, үр жимс ч гарсангүй билээ.’

“Нөгөө хүмүүн айлтгав: ‘Хаан минь ээ, энэ бол миний буян болой. Тэр адилын буян танд алга байна л даа’ хэмээв.”

“Чингээд гучин сая түшмэд бүгдээр хоёр өвдгөө газарт хатган, нөгөө хүмүүнд ийн хэмээн өгүүлэв: ‘Урьдын хаан бидэнд үл тохирно. Та одоо бидний хаан болтугай.’

“Нөгөө хүмүүн тэдгээр түшмэдэд ийн хэмээн өгүүлэв:

‘Хааны их эд баялаг надад хэрэггүй.
Эд таваар, үр тариа ч надад хэрэггүй.
Би бурхадад сүсэлж биширснээр л
Хоёр хөлтний дээд нь болох болтугай!

Амарлингуй нирвааны агаарт
Алив бурхад залрах тэнд би одох болтугай .
Гаслангаас нөгчигсөн нирвааны гэрт одох
Ийм л Номыг та нарт би номлосугай.
Хөлөө завилан суугаад
Сэтгэлээ чандлан баригтун.

Урдын хийсэн үйлийн үрээр би,
Хааны гянданд хүргэгдсэн бизээ.
Харин сайтар ерөөлийг талбисан болохоор л
Миний үйл барагдсан бизээ’ хэмээв.

“Чингээд 24 сая тоот очирт хошуунаас яруу сайхан эгшиг хадав. Тэр цаг тэр үед 3 түм 2 мянган орд харш сүндлэв. Орд харш тэдгээр бүгдийн хэмжээ нь 25 багцад болой. Тэдгээр орд харш бүхнээ алтан хошуут, алтан хацарт, алтан отгот 25 сая шувууд оршвой.

“Тэдгээр бүгд хүмүүний хэлээр ярих:

Хаан та, сайныг эс үйлдэв.
Та тэр модыг тасалснаар
Нэг зуун сая тоотой модыг таслав.
Түүнийг бид 24 болгож үзүүлэв.

Алин амьтан энэ модыг тарьсныг
Та мэдэхгүй байна.
Хилэнцийн сэтгэлээр тасалсан тул
Хүмүүн та зовлон амсах болой.

“Хаан өгүүллрүүн:

Би энэ утгыг нь мэдээгүй болохоор
Их хатуужилтаа, эш бошгыг үзүүлэгтүн.

“Шувууд бээр өгүүллрүүн:

Энэ ертөнцийг гийгүүлэн үйлдэгч
Эрхэмсэг сартваахи болох билээ.
Орчлонгийн зовлонт гяндангаас
Олон амьтныг гэтэлгэж үйлддэг билээ.

“Хаан өгүүллрүүн:

“Тарьсан мод нь эс ургасан
Хоёр дахь хүн нь хэн бэ?
Ямар хилэнцэт үйлийг үйлдсэн бэ?
“Хоёр төрөгч” та нар өгүүлэгтүн.

“Шувууд өгүүллрүүн:

Тарьсан мод нь эс ургасан тэр хүн
Тэнэг Дэва-датта (*түвд: Лхайжсин*) юм.
Өчүүхэн төдий буян хийгээгүй бол
Тарьсан мод нь хэрхэн ургах билээ?

“Чингээд тэр цаг, тэр үед гучин сая тоотой түшмэдүүд номын зүйл үүнийг сонсоод, бүгд аравдугаар газарт оршвой. Илт мэдэл тус тусыг олов. Хаан тэрээр аравдугаар газарт оршиж, Номыг илт онох мэдлийг даган олов.”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэна ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ямар учир, ямар үндэс шалтгааны үүднээс гучин сая тоот түшмэд нар аравдугаар газарт орших болов, илт мэдлийг тус тусдаа олов?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, сонсогтун. Эшийг үзүүлсүгүй.”

Чингээд тэр цагт Бурхан мөшөөлийг үзүүлэн зохиов.

Тэр цагт Бурхан нигуураасаа элдэв олон өнгөт гэрлийг цацруулав. Хэдэн зуун мянган тоот өнгө нь энэ адил буюу. Хөх, шар, улаан, цагаан, литийн өнгө, болор, мөнгөн өнгө гэх мэт 8 түм 4 мянгыг цацруулж, хэмжээлшгүй тоолшгүй ертөнцийн орныг гийгүүлэн үйлдэв. Жич буцааж татаад Бурханыг гурвантаа эргээд, Бурханы оройн үснэрт шингэв.

Чингээд бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэна суудлаасаа босож, номын баринтагаа мөрнөөсөө буулгаад, баруун өвдгөө газарт хатгаж, Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Бурханаа ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурхад үндэс шалтгаангүй мөшөөхгүй тулд мөшөөн зохиосны үндэс алин, шалтгаан юу вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, ертөнцийн дөрвөн зүгийн орон бүхэнд байгаа ард олон бүгд миний хажууд цуглахыг үзсэн үү?” хэмээв.

“Бурхаан, үзсэнгүй болой.”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, тиймээс ард олон цуглахыг сайтар үзэгтүн, ухаарагтун.”

Чингээд бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна тэр бүгдийг сайтар харсан буюу: Зүүн зүгт 7 мянган багцадын чинээтэй мод ургаж, түүний нэг талд нь нэгэн живаа 25,000 сая ард олон цуглаж, тэр хүмүүс үл ярих, үл өгүүлэх, үл идэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэхийн байдлаар оршино.

Өмнө зүгт нь мөн 7 мянган багцадын хэмжээтэй мод ургаж, түүнээ 25,000 сая ард олон цуглаж, үл хэлэх, үл ярих, бүхнийг үл өгүүлэх, төгс үл өгүүлэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэх зэргээр оршино.

Өрнө зүгт мөн 7 мянган багцадын чинээтэй мод ургаж, түүнээ 25,000 сая төрөлхтөн цуглаж, үл хэлэх, үл ярих, бүхнийг үл өгүүлэх, төгс үл өгүүлэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэх зэргээр оршино.

Умард зүгт 7 мянган багцадын чинээтэй мод ургаж, түүнээ 25,000 сая төрөлхтөн цуглаж, үл хэлэх, үл ярих, бүхнийг үл өгүүлэх, төгс үл өгүүлэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэх зэргээр оршино.

Доод зүгт 7 мянган багцадын чинээтэй мод ургаж, түүнээ 25,000 сая төрөлхтөн цуглаж, үл хэлэх, үл ярих, бүхнийг үл өгүүлэх, төгс үл өгүүлэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэх зэргээр оршино.

Дээд зүгт 7 мянган багцадын чинээтэй мод ургаж, түүнээ 25,000 сая төрөлхтөн цуглаж, үл хэлэх, үл ярих, бүхнийг үл өгүүлэх, төгс үл өгүүлэх, үл хөдлөх, үл босох, юу ч үл өгүүлэх зэргээр оршино.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна ийн хэмээн айлтгав: “Алин айлтгасны хариуд эш бошгийг үзүүлэн, Бурхан та надад чөлөө гаргана уу. Ялж төгөлдөр нөгчигсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан Бурхаан, нэгэн зүйлийг айлтгаму?” хэмээсэнд,

Бурхан бээр бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэнад ийн хэмээн зарлиг болгов: “Бхайшажяа-сэна, юу хүссэнээ асуугтун. Асуусан тэр

бүхэнд нь эшийг үзүүлэх учраас та сэтгэл баяртай байгтун” хэмээн зарлигласан ба бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна Бурханаа ийн хэмээн айлтгав:

“Бурхаан, юуны учир дөрвөн зүйлийн ертөнцөд олон ардууд цуглаж, дээд, доод олон төрөлхтөний чуулган 50,000 сая тооноос илүүтэй оршихын учир юу вэ, шалтгаан юу вэ, үндэс юу вэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, Та яваад тэдний ирсэн тэр ертөнцийн орноо суугч бурхадаас асуугтун.”

“Хэний рид хувилгааны хүчээр явах вэ?” гэж Бхайшажья-сэна асуув.

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, та өөрийн рид хувилгааны хүчийг гаргаж ирэгтүн.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна бээр Бурханыг гурвантаа эргэн, тэр ямагт үл үзэгдэх болов. Тэр бээр 96 сая ертөнцийн орон бүхнийг гэтэлж, Чандра-прадипа (*мон: Саран зул*) хэмээгдэх ертөнцийн нэгэн оронд, 80,000 сая бодьсадвагаар хүрээлүүлэн Түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан Бурхан Чандравати-кшетра (*мон: Сарант*) залран, Ном зааж байв.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна Чандравати-кшетра хэмээх Ялж төгөлдөр нөгчигсөн бурханы мэлмийн өмнө суугаад, Бурхан түүний зүгт алгаа хавсран мөргөж, Бурхан түүнээ ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, ямар шалтгааны учир Түүнчлэн заларсан Шагжтүв бурханы мэлмийн өмнө 10 зүгээс цугласан олон төрөлхтөн тэдгээрийг Саха ертөнцийн оронд би харахгүй байна вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, тэдгээр бүгдээр тэнд цугларан оршсон болой.”

“Бурхаан, юуны учир вэ?”

Бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна Түүнчлэн заларсан Чандравати-кшетра хэмээх бурханы орны зүг, тэр Бурхан заларсан зүг одож, тэр Бурханы мэлмийн өмнө суугаад, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, 96,000

сая ертөнцийн чанадад очтол тэдгээр оронд, тэнд байгаа адилаын олон амьтан байсангүй.”

Бурхан зарлиг болруун: “Тэдгээр орны амьтад чинь сэтгэл үгүй модноос гарцгаасан болой” хэмээв.

“Бурхаан, яаж сэтгэлгүй модноос гарах билээ? хэн үүнийг үзсэн юм, хэн үүнийг сонссон юм бэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, сэтгэлгүй модноос төрдөг гэдгийг сонсоогүй, үзээгүй гэж үү?” гэв.

“Бурхаан, би үзээгүй ч үгүй, сонсоо ч үгүй билээ.”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, үзэхийг хүсвээс би зааж өгье” гэв.

“Бурхан Ялж төгөлдөр нөгчигсөөн, би үзье. Амгалан залрагсаан, би харъя.”

Чингээд Чандравати-кшетра хэмээх бурхан мутраа сунган, мутраас нь 100,000 сая ард гарав. Тэдгээр ардын чуулган тус бүр зуу, зуун гараа сунган хүж, эрхис, элдвийн сайхан түрхлэг зэргүүдийг Бурханд өргөв. Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, Бурханд хүж, эрхэс, үнэртэн өргөж байгаа энэ олон хүнийг үзэв үү?” хэмээв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, үзлээ. Тэрчлэн залрагсаан, харлаа.” хэмээв.

Бурхан зарлиг болруун: “Эдгээр ард, цугласан хүн бүхэнд сэтгэл байхгүй болой. Эдгээр хүмүүст санаа байхгүй болой.”

Чингэтэл нөгөөх 100,000 сая хүмүүс тэдгээрт байсан зуун гар бүгд унав.

Бодьсатва, их бодьсатва Бхайшажья-сэна түүнийг үзээд Бурханаа ийн хэмээн айлтгав: “Бурхаан, юу болох нь энэ вэ, Амгалан залрагсаан, энэ юу вэ? Алив хүмүүний зуун гар агшин төдийд л унав. Бурхаан, зуун гартай нь гэтэлж чадаагүй байхад хоёр гартай хүнийг хэрхэхийг хэлээд яах вэ дээ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, энэ адилаар сэтгэлгүй амьтан чинь сэтгэлгүй болж төрөх болой. Сэтгэлгүй болж түрдэх болой. Бие нь ч гэсэн сэтгэлгүй болохыг мэдэж аваарай, Бхайшажяа-сэна” гэв.

“Бурхаан, тэдгээр амьтны залуу нь алин, хөгшин нь алин бэ?

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, залуу ч амьтан байна, хөгшин ч амьтан байж болно” гэв.

“Бурхаан, залуу нь алин бэ, хөгшин нь алин бэ?

Бурхан зарлиг болруун: “Одоо унаж байгаа тэдгээр нь хөгшин болой. Модноос төрж байгаа нь залуу болой” гэв.

“Бурхаан, залуу байгаа амьтныг нь үзүүлэн зохио.”

Чингээд Чандравати-кшетра хэмээх бурхан баруун мутраа сунгатал арван зүг тус бүрээс 100,000 сая ард ирэв. Дээр, доор зүг бүхнээс 50 сая ардыг авчрав. Цугласан ард Бурханы өлмийд толгойгоороо мөргөөд, Бурханд юу ч үл өгүүлэн, юу ч үл ярин, үл өгүүлэхийн байдлаар оршив.

Бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна Бурханаа ийн хэмээн айлтгав: “Бурхаан, юуны учир эдгээр амьтад Бурханаа юу ч үл өгүүлэн, хотол даяар юу ч үл ярин сууна вэ?

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, үл мэднэ үү? Эдний нутагт сэтгэл үгүй учраас ярих үгүй, хотол даяараа ярих үгүй. Номын цогцсыг ч үл мэдэх болой. Учир нь, Бхайшажяа-сэна, энэ газарт зарим нэг залуу хүн үзэгдэвч төрөхөө үл мэдэх, түрдэхүй, өтлөхүй, өвдөхүй, гаслах, эмгэнэн уйлах, гуа лугаа хагацах, гуа бус лугаа учрах, садагнах, салах, үхэх, цаг бусаар үхэх барагдашгүй зовлон тэд бүгдийг үл мэдэх болой. Үзэх хэдий ч сэтгэл гансарна гэж үгүй болохоор мэднэ гэж хаанаас байх билээ? Бхайшажяа-сэна, эдгээрт ахин дахин сайтар номнох хэрэгтэй.”

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна Бурханаа ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ном сураагүй тэдгээр залуус хаанаас гарч ирэв, хаа үхэх, хаана төрөх билээ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, сонсогтун. Хүний биеийг төгс баригч тэднийг мөнгөний дархан үл урлав, зэсийн дархан үл урлав, модны мужаан үл урлав, шаварчин ч үл урлав. Хааны аюулаас ч үл гарав. Бас бус эр хүн, эм хүн нийлсэн буюу, хилэнцийн үйлнээс л гарсан буюу. Тэдгээр амьтан худалдаа наймааны үйлд ахин дахин суралцсан тул эдний зовлон хэмжээлшгүй их, амсуурга нь хэмжээлшгүй их гарна. Тэр оронд тэдгээр амьтан урьд хийсэн нүглийн үйлийн тийн боловсролыг амсана. Бхайшажяа-сэна, өнөөдөр энд байгаа эдгээр амьтан нь зовлонгийн амсуургыг амсана, Бхайшажяа-сэна, ийм учраас тэд юу ч үл өгүүлэх, юу ч үл ярих болой. Бхайшажяа-сэна, ийм учраас л тэдгээр залуус нь буян ч үл мэдэх, төрлөө ч үл мэдэх, хорихуйг ч үл мэдэх болой. Тэд хүний биеийг олохоо ч үл мэдэх учраас л эдгээрийг ‘залуу’ хэмээсэн болой, Бхайшажяа-сэна” хэмээв.

“Бурхаан, залуу амьтан гэдэг хэрхэн төрөх, хэрхэн түрдэх вэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, энэ адил буюу. Зарим хүмүүс галд мод хийхэд тэр модонд гал авалцахын адилаар, Бхайшажяа-сэна, эхлээд хүний биед төрөх болой. Төрсөн хойноо амсуурга сэрэхүйг эдлэх болой” хэмээв.

“Бурхаан, энэ газар чинь хэн эхлээд төрөх вэ? Төрсөн хойноо хэн газлангаас нөгчих вэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, Бурхан төрөх болой, Түүнчлэн залрагсад л төгс гэтлэх болой. Үлгэр энэ адил буюу, Хаан хүн зарим нэгэн хүмүүсийг хүлээд, харанхуй шоронд суулгах бий. Нөгөө хүн харанхуй шоронд ороод харанхуй байшинг харанхуй л гэж үзнэ шүү дээ. Гэтэл урьд нь зовлонт амсуургыг амсаж мэдэрсэн бас бус хүмүүс: “Энэ хүнийг ингэж болохгүй. Урьд нь зовлонт эдлээгүй болохоор амиа алдаж ч мэднэ” гэж бодоод, галын цучил тэр гэрийн дотор оруулж орхих бий. Нөгөө шоронд байгаа хүн тэр галыг үзэх болой. Үзэхийн цагт санаа нь амран, баясна. Гэтэл нөгөө гал улам бадарч дүрэлзэж, гэр байшин бүгдийг нь шатааж, нөгөө хүнийг ч шатаахад хүрнэ. Шатаж байна гэж үгийг сонсоод хаан уурлаж, ‘үүнээс хойш миний улсад хэзээд ямар ч хүнийг шоронд

бүү хий’ гэж санахвий.

“Хаан бээр: ‘Миний улсад байгаа ард олон хэзээ ч бүү айгтун. Бүү цочигтун. Та нар аюулаас бүү айгтун. Үүнээс хойш миний оронд цаазаар таслах буюу шоронд оруулж бүү үйлдэгтүн. Алив амьтныг амь лугаа бүү хагацуул’ хэмээн өөрийн орны хүмүүст өгүүлэв.

“Ийнхүү тэднийг тайвшруулсан адилаар, нисванис бүхнээ шатаасан Ялж төгөлдөр нөгчигсөн бээр хамаг өвчин бүхнийг ихэд амарлиулав, Бхайшажяа-сэна. Чингээд гэр нь шатваас хүн нь шатах буюу, бие нь шатах буюу, тиймээс амьтанд туслах хийгээд амгалантай байлгахын тухайтад оршиж, хүлэгдсэн амьтныг хүлээснээс нь чөлөөлж үйлдэх тэр адилаар бурхад ч гэсэн хүсэл шунал, уур омог, балай мунхагийн хирийг тэвчсэн агаад хамаг амьтны зул болж, ертөнцөд залрах бөгөөд амьтан бүхнийг там, бирд, адгуус, асурын орноос төгс гэтэлгэн зохиох бөгөөд хөгшин, залуу амьтан бүхнийг ч төгс тонилгон зохиох болой.”

Чингээд дээд тэнгэрийн завсраас эдгээр шүлэг гарсан болой:

Ялгуугсдын орон нь сонин гайхамшигтай бөгөөд
Арилсан орон тэдгээр нь илт хуран үйлдсэн болой.
Тэр оронд хөрөнгө тавих нь
Хэзээд үл шамшаагдах буюу.

Ялгуугсадын орон нь арилсан орон,
Бурханы шашинд сайшаагдах бөгөөд
Хамаг амьтныг дээш татахын тухайд
Бурхан бээр аргыг зохиосон болой.

Хэдий нирвааны төвд оршивч
Газрын дээр хаа сайгүй үзэгдэх буюу
Үргэлжид ертөнцийг амарлиулж үйлдээд,
Бурхад өглөгийн орныг ариусгах буюу.

Залуу амьтныг гэтэлгэж үйлдэх,
Хөгшид өтгөсийг ч гэтэлгэж үйлдэх,
Хамаг амьтныг гурван орноос
Огоот гэтэлгэж эцэст нь хүргэх.

Тамын амьтны үүдийг хаах,
Адгуус бирдийг тонилгож үйлдэх,
Энэхүү ертөнцийг ч амариулж үйлдээд,
Ертөнцийн чанадад жаргалтай болгох буюу.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр мөшөөлийг зохиож, зарлиг болруун:

Сайн сайхныг үзвэл сайн болой.
Бурхад ялгуугсадыг үзвээс сайн болой.
Дээдийн Ном эрдмийн орон тул сайн болой.
Бурсан хуврагийг үзвээс сайн болой.
Хос номын зүйлийн сургааль ч сайн болой.
Хилэнц нүглийг эвдвээс сайн болой хэмээв.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна бээр Ялж төгөлдөр нөгчигсөн байгаа тэр зүгт алгаа хавсран сөгдөөд, Ялж төгөлдөр нөгчигсөн түүнээ ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, мөшөөн зохиосны шалтгаан юу вэ, үндэс юу вэ?”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, та залуу амьтан эдгээрийг үзэв үү? хэмээв.

“Бурхаан, үзсэн болой, Амгалан залрагсаан, үзсэн болой.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, эдгээр бүгдээр өнөөдөр энэ цагт арван газарт орших болов.”

Чингээд бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна 80,000 багцадын дээр огторгуйд оршиж, 80,000 сая тэнгэрсүүд бурхадын дээр цэцгийн хур буулгав. Залуу тэдгээр амьтад алгаа хавсран мөргөв. Бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна газар тэнгэрийн завсарт оршихын зуур ийн хэмээн өгүүлэв. Гурван мянган ертөнцийн их гурван мянган ертөнцийн орон бүхнийг дуугаар дүүргэх ба 32 их тамын орны амьтад ч дууг нь сонсов. 32 тэнгэрүүд ч тэр дууг сонсов. Гурван мянган ертөнцийн их гурван мянган ертөнцийн орон бүгд зургаан зүйлээр машинд хөдлөв. Их далайн доторхи 8 түм 4 мянган лус ч хямрав. 30,000 сая тоотой мангас энэ Замбу тивд ирэв. Бирд, ягчис, мангас 25,000 сая тоот ч Адакавати (*түвд: Жанложин*)-

ийн орд харшаас ирэв. Бурханы мэлмийн өмнө их чуулган болж, бүгд хурав. Чингээд Бурхан бээр тэдгээр залууст Номыг заасан ба арван зүгийн ертөнцийн орноос 100,000 сая тоотой бодьсадва, их бодьсадва нар өөр өөрийн рид хувилгаанаар залрав.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна бээр Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Бурханд ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, бодьсадва нар машид ихээр цугларчээ. Амгалан залрагсаан, олон байна. Бурхаан, тэнгэр, лус ч мөн олон цуглажээ. Живаа тоотой мангас матар зэргүүд Адакавати орд харшаас ирж цуглажээ” хэмээв.

Чингээд Бурхан бээр бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэнад зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, бууж ирэгтүн”.

Бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна рид хувилгааны хүчээр дээрээс бууж ирээд Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ‘Номын цогцос’, ‘Номын цогцос’ хэмээгдэх юу вэ? Бурхаан, юу төдийгөөр ‘Номын цогцос’ хэмээх вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүнээ, ‘Номын цогцос’ хэмээх нь алин зөв явдлыг бүрнээ эрэлцсэн хийгээд алин хэн хүн зөв явдлыг төгс олоод, хамаг хилэнцээ тэвчих явдал болой. Язгуурын хөвгүүнээ, залуу амьтан бээр буруу явдлаа тэвчээд, дамжиггүйгээр *тогтоол тарнийг* сайтар олох ба хамаг ном лугаа үнэхээр төгс болсон тэдгээрийг үзэв үү?” хэмээв.

“Бурхаан, ямар аргаар хамаг амьтан цуглаж, Номын цогцосыг сонсоно вэ?”

Чингээд Бурхан бээр бодьсадва, их төрөлхтөн Бхайшажья-сэнад зарлиг болруун: “Бхайшажья-сэна, олон амьтан бээр төрсөн болгон зовлонтой гэж үл сонсжээ. Өтөлсөн ямагт нь зовлон гэж үл сонсжээ, өвчтөн зовлонтой байх, гаслантан зовлонтой байх, уухилан орилох нь зовлонтой байх, садан лугаа хагацах нь зовлонтой байх, дайсан лугаа учрах нь зовлонтой байх гэдгийг сонсоогүй амьтан олон байдаг. Үхэх гэдэг хамаг зовлон мөн тул бие болоод аминаас хагацах буюу. Бхайшажья-сэна, энэ бүгдийг ‘зовлон’ хэмээх болой”.

Чингээд залуу амьтас тэдгээр энэ номыг сонсоод, Бурхан байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, бид нар ч гэсэн үхэх болох нь ээ?” хэмээв.

Бурхан зарлиг болруун: “Та нар болоод хамаг амьтан тэр адил болой.”

Тэд нар айлтгав: “Бурхаан, хэрхэн үхлийн цаг ирэхэд юугаар дарагдах бол?”

Бурхан зарлиг болруун: “Язгуурын хөвгүүдээ, үхлийн цаг ирэхэд тийн мэдэл буюу эглийн тийн мэдэл хоригдож хаагдах ба ‘хааж үйлдэгч’ хий болон ‘тийн мэдлийг мунхруулагч’ хий болон ‘тийн мэдлийг хямруулагч’ хий болон тэдгээр гурван хийгээр үхэл ирэхийн цагт тийн мэдлүүд нь эцэстээ хүрч живэх буюу эндүүрэх буюу хямарч үйлдэх болой.”

Тэд дахин айлтгав: “Бурхаан, үхэхийн цагт тийн мэдлийг хорьж, биеийг эвдэж үйлддэг гурван хий алин бэ?”

Бурхан зарлиг болруун: “Нөхөд өө, ‘мэс’ хэмээгдэх, ‘шаардлага’ хэмээгдэх, ‘таслагч’ хэмээгдэх тэдгээр нь биеийг эвдэж үйлдэх болой” хэмээв.

“Бурхаан, ‘бие’ хэмээгдэх нь юу мөн бэ?”

Бурхан зарлиг болруун: “Нөхөд өө, ‘машид бадрах’ хэмээгдэх болой, ‘шатаагдах’ хэмээх болой, ‘нус цэр’ хэмээгдэх болой, ‘хэрхрэх’ хэмээгдэх болой, ‘хүүрийн газар’ хэмээгдэгч болой, ‘муу оюут’ хэмээгдэгч болой, ‘хүнд үүрэгт’ хэмээгдэгч болой, ‘төрлөөр төгс хатгуулагдагч’ хэмээгдэгч болой, ‘төрлөөр бүхнээ хямрагч’ хэмээгдэгч болой, ‘аминдаа огоот энэлэгч’ хэмээгдэгч болой, ‘үхэл шалтгаалах болоод садан лугаа хагацагч’ хэмээгдэгч болой. Нөхөд минь ээ, эдгээрийг ‘бие’ хэмээх болой.”

Тэд айлтгав: “Бурхаан, хэрхэн егүүтэх вэ, хэрхэн амьдрах вэ?”

Бурхан зарлиг болруун: “Нөхөд өө, ‘тийн мэдэл’ хэмээх нь үхэх болой, Насан төгөлдөр өө, ‘буян’ нь амьдрах болой. Нөхөд өө, ‘бие’ хэмээгдэх нь үхэх болой, сая живаа шөрмөсөөр холбогдсон

болой, 8 түм 4 мянган шар үсний нүх төгөлдөр, 12,000 үе хэсгээр холбогдсон, 360 ясаар гагнагдсан, 84 язгуурын өт хорхой оршсон энэ биенд тэдгээр амьтан бүгдээр үхэх ч байна, үхэл нь хорихуй буюу. Хэзээ хүмүүн түүнээ үхэл ирэх цагт ч тэдгээр өт хорхой бүхний горьдол тасрах бөгөөд тэдгээр амьтан нэг нь нэгийгээ идэх зэргээр хий хямарч хөдлөх бий. Тиймээс тэдгээрийн зовлонг ч амсах бас байна. Заримууд хүүгийнхээ төлөө гаслах бий, заримууд охиныхоо төлөө гаслах бий, заримууд садангийнхаа төлөө гаслах бий, тэр бүгд гаслан зовлонгийн хатгуулгаар нэрвэгдэх болой. Нэг нь нэгийгээ идэхээр тэмцэж, нэг нь нөгөөгөө идсээр, хоёр амьтан үлдэх бөгөөд долоо хоногийн туршид тулалдана. Долоо хоногийн зуур нэг нь нөгөөгөө дарах болой. Нэг нь чөлөөт болох болой.

“Насан төгөлдөр өө, ‘Ном’ хэмээх нь юу вэ гэвэл, хэрхэн санана? Хэрхэн өт хорхойнууд нэг нь нөгөөгөө идэж, үл зохилдон байсаар үхдэгтэй адил эгэл нялхас төрөлхтөн амьтан ч гэсэн нэг нь нөгөөдөө үл зохилдох үйлийг үйлдэж, төрөхөөс үл айж, өтлөхөөс үл айж, өвдөхөөс үл айж, үхэхээс ч үл айх буюу. Хэрхэн хоёр өт хорхой хоорондоо байлдахын адил эгэл төрөлхтөн нугууд өөр хоорондоо тэмцмү. Чингээд үхэл ирэхийн цагт буянтан нугууд өгүүлэх: ‘Амьтан, чи юунд итгэдэг вэ? Өчүүхэн төдий гэмийг ч үл харсан гэж үү? Төрөхийн гэмийг үл үзэв үү? Өтөлж өвдөхийн гэмийг үл үзэв үү? Үхэхийн гэмийг үл үзэв үү?’ гэж асуух вий.

“Тэд бээр:

‘Насан төгөлдөр өө,
Би бээр төрөхийн гэмийг үзэв,
Өтлөх, өвдөхийн гэмийг үзэв,
Хамаг бүгдээр эцэстээ үхэхийн гэмийг үзэв’ хэмээв.”

“Өгүүллрүүн: ‘Юуны тулд алив буяны ёзоорыг эс үйлдэв? Юуны тулд хоёр ертөнцөд амгалан арвижихын буяны цогцос номын ёзоорыг үл үйлдэв? Нөхөд минь ээ, дахин асуусу. Та нар юуны тулд төрөх болоод үхлээс төгс гэтэлгэх буяны чуулганыг эс үйлдэв? Та нар юуны учир ёсчлон сэтгэлдээ үйлдэж, тус тус шинжилж эс үйлдэв? Та нар газар дэлхийд ганди модыг цохих дууг хэрхэн эс сонсов? Бурхадын оронд

буяны хөрөнгийг мэндлүүлэх хүж эрхэс, зул өглөг өгөх тэргүүтнийг эс үзэв үү? Бурханд идээ зоог ундаа өргөх ба дөрвөн нөхөр сэлтээр цэнгүүлж үйлдэхийг эс үзэв үү? Гэлэн, гэлэнмаа хийгээд гэнэн, гэнэнмаа хэмээх номд илт сүжиглэсэн тэдгээр нь дөрвөн нөхөр болой.’

“Тийнхүү тэдэнд туслах үгийг өгүүлэв: ‘Өгүүлж ярьсан хэдий ч та нар өчүүхнийг ч үйлдсэнгүй. Хүмүүн, та нар Замбу тивд ирээд, нүгэл л үйлдэж дээ.’”

“Чингээд Номын хаан бээр үхсэн хүнд даган орох шүлгийг өгүүлэв:

‘Тэрчлэн зарарсан бурхадыг үзэх агаад
Гандийн цохих дууг сонссон хэрнээ
Гаслангаас нөгчин нирваанд одох
Номыг заалгаж сонссон ч, эс үйлдэв.’

“Чингээд тэрбээр хариу өгүүлэв:

‘Би гэдэг нялхасын ухаант бөгөөд
Хилэнцэт нөхрийн эрхэнд одоод,
Шунал эндүүрэлт сэтгэлийн эрхээр
Хилэнцийн үйлийг үйлдсэн болой би.

Шунал хүслийг шүтсэн агаад
Амьтан хүнийг ч алсан буюу би.
Хувраг тойдын эд юмсыг үрсэн тул
Хэмжээлшгүй түүний өр нь ирэх бизээ.
Хорлож хөнөөхийн сэтгэлээр
Суварга шүтээнийг ч эвдлэв би.
Элдэв муухай үгийг өгүүлж,
Өөрийнхөө ээжийг ч зовоож үйлдэв.
Өөрийн биеэр үйлдсэн
Элдэв муугаа сайтар мэдэв.

Уухилан дуудагч их тамд
Машид олон төрөл авахаа мэдлээ.
Хураан дарагч тамд ч
Зовлонг эдэлж, улмаар цаашдаа

Машид халуун хийгээд Их аймшигт аюус тамд
Хэмжээлшгүй зовлонг хожим амсах билээ.

Лянхуа мэт машид хагаран
Хүйтэн тамын зовлонд унаж,
'Хар тэг татуулах' их аюулд ч
Зуунтаа төрөл авах билээ.

Хожим тамын амьтан тэдгээр нь алагдсан ч
Ахин тэрхүү аймшигт зүйлсийг үзнэ.
Зуун багцадын чинээтэй
Их аюулд ахин дахин унах вий
Эндээс гарах аргаа үл олно.
Хожим нь харанхуйд унах бий.
'Хутганы ирт' хэмээх тамд
Мянган хутганы ирэнд ч очих бий.

Живаа мянга зуун тоотой
Хутганы ирний өмнө ч одох бий.
Өөрийн хийсэн муу үйлээр
Тэр хутганд биеэн зүсүүлэх бий.
Барагдашгүй их хуу салхи гарч,
Хамаг биеийг минь эвдлэх ч бий.
Үргэлжид энэ адилаар тамд төрж,
Өөрийн биеэ зовоох бий.
Бие минь ихэд энэлж шаналахыг
Амьтан тэдгээр үзэх болно.

Гэрээн аврахаар, бусдын хураасан хөрөнгийг
Би эзэгнэж булаасан бий.
Миний хөвгүүн, миний охид,
Тэрчлэн ах, дүү, эгч нар минь ч
Миний эжий, аав,
Тэрчлэн садан, хамаатан олон,
Боол, зарц нар ч
Тэрчлэн үхэр мал, албат зарц,
Муу бүхний тухайтад би хилэнцийг үйлдлээ.

Алт мөнгөний сав хийгээд
Зөөлөн, нарийн бүс хийгээд
Гэрийнхээ төлөө гэж үйлдсэн
Тэр бүгд хуурмаг ажгуу.
Эр эм хүмүүс цугларсан
Гэрийг машид дурайлган үйлдэв.

Биван ятгын яруухан эгшгэнд
өөрийнхөө сэтгэлийг номхруулалгүй баясав.
Үнэрт усаар биеэ сүрчивч
одоо ач хариулсан зүйл алга.

Бие минь чи сэтгэлгүй ч
Чиний төлөө би хилэнцийг үйлдэв.
Хожим хойчид ганц болов амьтан
Миний аврал болохгүй бизээ.
Их хуй салхи босож,
Биеийг минь хичнээн энэлгэсэн ч

Амт шимт төгөлдөр хоолоо идсээр
Элдэв зүйлийн амтанд шунав.
Элдвийн эрхэс үзэсгэлэнтэй сайхан олныг
Эрхэмлэж дээжлэн хүзүүндээ зүүв.

Дүрсэнд нүд минь эндүүрсэн тул
Нүдэнд аврал гэж хаана байх вэ.

Үзэж харсаны дараа үйлдсэн нүглийн минь
Үндэс нь нүд билээ.
Гараа очроор таслахын шалтаг нь
Миний чих болой.

Хоёр гартаа бугуйвч зүүх,
Хуруу үендээ бөгж зүүх,
Хоолойнодоо шүр сувд унжуулах зэргээр
Хоёр хөлөө ч ихэд чимэв,

Шагайндаа ч чимэг зүүн,
Цаашлаад алтан болгож үйлдэх бий.

Биендээ элдэв зүйлийн их эрдэнэс хийгээд
Алтан бугуйвчаар ч дүүргэх бий.

Их эд баялагт сайтар хичээж,
Сэтгэл ихэд тачаав.
Машид зөөлөн торгонд горьдох ч бас бий.
Машид их тачааж, түүнийгээ шүтэх ч бас бий.

Олбог дэвсгэр элдэв зүйл дээр ч
Өөрийн биеэ энхрийлэх нь бий,
Үнэрт сайхан усаар угаалга үйлдэх агаад
Үнэрт сайхан усаар биеэ сүрчих бий.

Тэнгэрийн эд гавар, зандангийн сайхан үнэртнээр
Агаарыг утах бий.
Сайхан өнгө зүстэй хэдий ч
Хүдрийн заараар улам гоодох бий.

Замбага тэргүүтэн цэцэгсийн үнэрээр
Жич сүрчиж,
Нарийнаас нарийн
Гашгайн цагаан торгоор биеэ ороох бий

Зааны нуруунд сундлах хэдий ч
Морины нуруунд авирахаар илт шунах,
Би чинь хаан хүн шүү дээ хэмээгээд
Олон ардын өмнө хүрч үзэгдэх,

Дуу хөгжим бүжигт сайтар суралцсан,
Татвар эмстэй машид дотносох,
Ан гөрөөнд машид баясан,
өөрийн сумаар амийг нь хөнөөх,

Ийнхүү эцэс хойчид юу болохыг үл мэдэж
Элдвийн нүгэл хилэнцийг үйлдэх ба
Өөрөө бусдын махыг идсэн учир
Миний энэхүү зовлон барагдашгүй ихээр
Ирэх нь тэрээ.
Эрлэгийн элчийг үл мэдэх нь

Миний адилын нялхасын ухаан тул
Би өөрийнхөө биеийг тэтгэж үйлджээ.

Өнөөдөр надад үхэл ирэх болбол
Авран үйлдэгч хэн ч алга.
Садан тэд бүгдээрээ
Миний нүүрийг харахаас өөр юу байх вэ?

Юунд хуучин муу гашуудлын хувцас өмсөв?
Юунд ихэд гингэнэн чанга орилолдов?
Юунд үсээ задлан арзайлгав?
Юунд гашуудан цусаа гоожуулав?

Юунд толгойдоо шороо цацна вэ?
Юунд цээжээ дэлдэн хашгирна вэ?
Амьд байхдаа үйлдэх хилэнцээ тэвчбээс
зохистой тул, юунд та нар гашуудна вэ?

Өөрийн биеэ чоно, нохой болоод хэрээ шувуу
тэдгээрт л идэш хоол болгохоор л өгнө бишүү.
Тэр цагт ямар ч хэрэггүй биеэ тэжээсэн гэж үү,
Үхлийн могойн эрхэнд тул
Дахиад л тэд төрөх билээ.

Ийм л аюулаас гэтлэхийн тулд
тэр адилын эмийг шүтэж үйлдсүгэй.
Эмчийн надад өгсөн алив эм
Надад хэрэггүй.
Нисванисын могойноос гэтэлгэх
Эдүгээ номын эм эдгээрийг
Үхэх цагт минь надад өгч үйлдсүгэй

Надад махыг бүү өгөгтүн.
Хэдий биеэн тэжээвч
Дамжиггүй магад эвдрэх буюу.
Алин хэзээд зовлонг гаргах
Хилэнцийн цогцосыг юунд авах?
Энэхүү биеэ энхрийлэн тэжээвч
Элдэв буруу үйлийг үйлдэх буюу.

Охид, хөвгүүд, та нар юуны тухайд
Алжаалт намайг нүдээр ширтэнэ вэ?
Энэхүү өвчнөөс намайг аврагтун!
Миний охин, хөвгүүн минь,
Юунд дэмий гингэнэнэ вэ?
Та нарыг тэжээж үйлдэхийн тухайд
Бусдын эдийг ч би хулгайлав.

Эдүгээ харин үхэл ирсэн цагт
Горьдох юм алга. Яадаг билээ?

Муу заяаны төрлөөс машид айх,
Үхлийн зовлонгоор бүрэн эзлэгдэв.
Амсуурга хуран мэдэхүй,
Хуран үйлдэхүй болоод
Ухаан мэдрэл минь ч машид шанална.

Шуналаар нялхас тэнүүчлэх ба
Дуусашгүй муу үрийг ч олох бий.
Муу язгуурт төрөөд,
Дахин гасланд хүлэгдэх бий.

Надад буян өчүүхэн байгааг мэдээд,
Бусдад ч зовлон авчрав би.
Өглөг, шагшаабад бүрэн доройтон,
Ном буянд араараа зүглэх.
Дахин төрөл авахаа мэдэхгүй тул
Нисванисын могойгоор нисванист болж,

Мунхарч гүйцсэн нялхсууд
Хаашаа гэтлэхээ мэдэхгүй тэнэх бий.
Тонилохын хутгийг үл мэдээд
Эндүүрч элдэв нүглийг ч үйлдэх.

Нисванист болохоор нялхас тэнэх,
Сэтгэл машид хямралдах,
Элдэв хүлээс баглааст биенээ
Гал бадарч, бүгдийг шатаах.

Алин зовлонтой тэр газарт л
Биеийг олж эндүүрэн тэнэх,
Юунаас чухам амгалан гардгийг
Басхүү амгалан юу болохыг үл мэдэх тул

Бурханы орон гэдэг амгаланг гаргагч буюу.
Номын хүрд гэдэг эмийн дээд буюу.
Үнэн шагшаабад нь зөв ёс суртахуун буюу.

Эдгээр нь Амгалан залрагсадын ариун эгшиг мөн болой” хэмээв.

Чингээд Ялж төгс нөгчигсөн бээр бодьсадва, их бодьсадва
Бхайшажяа-сэнад зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, амьтан нугууд
үхэхийн цагт ийнхүү гаслан дуулдаг хэдий ч сайтар үйлдсэн буянт
үйлийн үрийн тийн боловсролоос өөр бусад тэдгээрийг авардаг
аврал хэнд ч байхгүй болой” хэмээн ийнхүү зарлиглаад, дараахь
шүлгийг айлдсан болой:

Хилэнцийн үйлийг үйлдсэн болохоор
Амьтан тамд унах буюу,
Шатах хувцсыг өмсөх буюу,
Буцалмал төмрийг уух буюу,

Биенд нь оч гал бадрах буюу,
Шатаж түлэгдэх нь барагдашгүй агаад
Тамын амьтны их аюулаар
Түүний бие бүхэн түлэгдэх буюу.

Жаргах гэдгийг огт үл мэдэх бөгөөд
Ном буяныг ч үл мэдэх.
Ном бусаар нялхас тэнэх болохоор
Амгалан жаргаланг өчүүхэн ч үл олох.

Сүсэг, шагшаабад зэргийг хотол шүтвээс
Билиг ухаан, их дияаныг олно.
Буяны садныг шүтсэн бол
Бурханд түргэн хүрэх буюу.

Ертөнцөд бурхан болж залрахын тулд
Хичээж шамдаж номыг туурви.

Хамаг амьтныг гэтэлгэхийн тухайд
Буяны мөрийг зааж өгсүгэй.

Асрахуйн сэтгэл төгөлдөр байж,
Ариун явдлын дээдэд сэтгэлээ агуул.
Бхайшажяа-сэна, та нар үүнийг сонсоод
Эрхэм дээдээр бүтээж үйлдсүгэй.

Нирвааныг ологсод ба бурхад
Зарлиг нь магтагдсан их хөтөч,
Ертөнцийн аав, ээж гэдэг нь,
‘Бодь сэтгэл’ хэмээгдэх билээ.

Ертөнцөд энэхүү номыг заах
Буяны садан дээдсийг олоход машид бэрх.
Бурханы номыг сонсогч алин тэр хүн төдөлгүй
Бурханы газар эрхэм түүнээ одох.

Амарлингуй бурхан хөвгүүд сэлт дор
Алин хэн бээр биширч сүслэвээс
Тэр бүх амьтан бүгдээр тонилж үйлдээд
Ертөнцийн итгэл болох” хэмээв.

Чингээд Ялж төгс нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна ийн хэмээн айлтгав: “Бурхаан, юуны учир газар ийн хөдлөв?” хэмээн айлтгав.

Ялж төгс нөгчигсөн бээр бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэнад ийн хэмээн зарлиглав: “Бхайшажяа-сэна, үүнийг үзэгтүн.”

Бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна дөрвөн зүгт газар хагарсан байхыг үзэв, хагарсан газрын хавцлаас 20 сая тоотой хүмүүс гарч ирсэн агаад доороос нь 20 сая хүмүүс, дээрээс нь 25 сая хүмүүс гарахыг үзэв. Тэдгээр залуус үүнийг хараад Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, энд төрсөн энэ хүмүүс хэн юм бэ?” хэмээв.

Бурхан зарлиг болруун: “Та нар тэр хүмүүсийг сайн харцгаа.”

“Сайн харлаа.”

Бурхан зарлиг болруун: “Тэр олон амьтан та нарыг жаргаахын тулд төрсөн болой” хэмээв.

“Эдгээр амьтад чинь бас үхэх үү?” гэж асуув.

Бурхан зарлиг болруун: “Нөхөд минь ээ, та нартай л адилхан тэр амьтад үхэх буюу” хэмээв.

Нөгөө залуу хүмүүс анх төрсөн тэр газраасаа Бурханы зүг алгаа хавсран мөргөж, Бурханд ийн хэмээн айлтгав: “Бурхаан, бид нар дахин төрж, үхэх хүсэлгүй байна” хэмээв.

Бурхан зарлиг болруун: “Тэгвэл та нар хичээнгүйн хүчийг олохыг хүснэ үү?” хэмээв.

“Бидэнд Бурханыг илтэд үзүүлээч, бидэнд Номыг сонсгооч, бидний сэтгэлийг таатай зөв болгооч, Сонсоод сонсгогч нарын хуврагийн чуулганыг үзүүлээч. Их рид хувилгаант бодьсадвын чадлыг ч үзүүлээч. Бид ийм зүйлийг үзмээр байна, бид төрөх, үхэхийг үзмээргүй байна, Бурхаан” хэмээлдэв.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна рид хувилгааны хүчээр 500 бодьсадватай хамт суудлаасаа босож, тэд бүгдээр рид хувилгааны хүчээр тэнгэр газрын савслагаар одож, тэнгэрт завилж суун, бясалгал дияаныг үйлдэв. Тэдний биенээс арслан гарав, бар гарав, могой гарав, заан гарав, их рид хувилааныг хувилган үзүүлэв. Уулын оройд завилан сууж, 2 түмэн багцадын зайтай орон зайд нисэв. 10,000 сая нар, сарыг буулгаж үйлдэв.

Чингээд Бурханаа нөгөө залуус ийн хэмээн айлтгав: “Бурхаан, ийм их гэрлийг гаргах, ийм их рид хувилгааныг ертөнцөд үзүүлэх үндэс нь юу вэ, шалтгаан нь юу вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Язгуурын хөвгүүдээ, та нар энэхүү ургаж буй нар, сарыг харагтун” хэмээв.

“Бурхаан, бид үзлээ, Амгалан залрагсанаа, харлаа” хэмээв.

Бурхан зарлиг болруун: “Ийнхүү бодьсадва нар өөрийн биенээсээ гэрэл гаргаж, рид хувилгаан номын чадлыг үзүүлж байгаа нь

олон амьтанд туслах ба олон ардыг амгалантай байлгах, ертөнцөд энэрэнгүй сэтгэлийг үзүүлэх, амьтанд их буяныг хураалгах, тэнгэр болоод хүмүүний тусыг үйлдэх, хамаг амьтныг жаргалтай тустай байлгахын тухайгад Ном зааж байгаа нь энэ билээ. Энд хүмүүний биеэр хүч чадал, хичээл шамдлаар олдгийг үзүүлж байгаа нь энэ болой” хэмээв.

“Бурхаан, гэрэл гэгээ цацруулан үйлдэх чадлыг олохын тулд Номыг зааж соёрхогтун” хэмээн айлтгав.

Бурхан бээр бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэнад ийн хэмээн зарлиг болруун: “Бхайшажья-сэна, та гурван мянган ертөнцийн их гурван мянган ертөнцийн орон зургаан зүйлээр хөдлөхийг үзэв үү?”

“Бурхаан, үзсэн болой, Түүнчлэн заларсаан, үзсэн болой” хэмээв.

‘Би бээр Бурханаас нэгэн утгыг асууж үйлдье’ хэмээн санахын төдийд Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна та юу хүссэн, юу бодсоноо асуугтун. Би таны асуусанд эшийг үзүүлэх бөгөөд таны санаа ч амрах бизээ. Үзүүлэх болой, тийн ялгаж үзүүлэх болой. Бхайшажья-сэна, алин өнгөрсөн, ирээдүй, эдүгээ цагт гарах бүгдийг үзүүлэх болой” хэмээв.

“Ялж төгс нөгчигсөөн, эргэлзээг арилгахын тулд заан соёрх. Бурхаан, би бээр Ялж төгөлдөр нөгчигсөнийг 84,000 тэнгэрийн хөвгүүдээр хүрээлэгдэх ба 84,000 сая бодьсадваар хүрээлэгдэх ба 12,000 сая лусын хаадаар хүрээлэгдэх ба 18,000 сая дүлбэмээр хүрээлэгдэх ба 25,000 сая бирд болоод махан идэштнээр хүрээлэгдлээ гэж үзэв.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, энэ олон амьтан чинь ном сонсохын тулд хуран чуулж, хажууд минь ирсэн нь энэ бөгөөд Бхайшажья-сэна, эдгээр амьтад өнөөдөр орчлонг эвдэх болой. Хамаг амьтанд тус болох хүслээр өнөөдөр л аравдугаар газрыг олох болой. Аравдугаар газарт машинд оршоод, нирвааны агаарт даган орох болой.

Өтлөх болон үхэхээс гэтлэхийн тулд
Амгаланг олох үйлийг үйлдэх бөгөөд

Нисванисын цалмыг эвдэж үйлдээд,
Бурханы номыг олох буюу” хэмээв.

“Бурхаан, амьтны орон гэдэг элдвийн үйлээс гарна. Ямар учраас тэд Бурханыг тойрон оршино вэ?”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, сонсогтун.

Амьтан үл мэдэхээс болж, мунхарсан тул
Тонилно гэж хаанаас байх вэ?
Залуу амьтан эдгээрүүд
Өнөөдөр л тогтоол тарнийг олох больюу.

Арван газрыг олохын тухайд
ном бүхнийг сайтар мэдэх,
Арван газрыг олсоны дараа
Бурханы үйл үйлдвэрийг үйлдэж болох.

Номын хүрдийг ч эргүүлж болох.
Номын хурыг ч сайтар буулгах.
Энэ мэтээр амьтан цугласан тул
Миний номд баяссан биз.

Тэнгэр, лус, бирд хийгээд
Асур тэнгэр тэргүүтэн машид олноор
Арван газарт ч орших бөгөөд
Номын дууг ч дуурсах буюу.

Номын хэнгэргийг ч дэлдэх буюу.
Номын лавайг үлээх буюу.
Залуу амьтан эдгээрүүд
хичээл шамдлын хүч төгөлдөр болох.

Тэрчлэн залрагсдын олсон адилаар
Тэдгээр бүхэн өнөөдөр Номыг олох буюу.”

Чингээд 5,000 залуус суудлаасаа босож, Ялж төгс нөгчигсөн байгаа тэр зүгт алгаа хавсран мөргөөд, Ялж төгс нөгчигсөн түүнээ ийн хэмээн айлтгав:

Алин хэзээд хязгаар нь үл олдох
Сансар үүнээ төрөх, үхэх буй.
Бие гэдэг хүнд ачаа ажээ, Бурхан минь,
Барагдашгүй их аюул орших тул

Зам мөр ч үл олдох буюу.
Тэрчлэн мөр ч үл үзэгдэнэ.
Аврал минь, бид сохор тул
Бид бүхнийг хураан соёрх оо.

Баатар танаас бид аврал эрмү,
Сартваахи та Номыг заан соёрх.
Бидний ухаан өчүүхэн билээ.
Амгалан жаргалыг олж эс чадмуй.

Бид нарт Номыг номлож соёрх.
Барагдашгүй зовлонгоос гэтэлгэн зохиогтун.
Алин ямар төрөл тутамдаа
Бурхантай учрах болтугай, бид нар”.

Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна тэдгээр залуусын
байгаа газарт хүрч ийн хэмээн өгүүлэв:

Та нугууд идээ унд зооглогтун.
Сонин гайхамшигт амтыг ч мэдрэх буюу
Дараа айдасгүй болсон хойноо
Аливаа айдасгүйгээр Номыг сонсогтун.

Өгүүлрүүн:

Ариун архад, та хэн бэ?
Бид нугууд таныг үл мэднэ.
Та болбоос машид үзэсгэлэнтэй харагдана.
Бие тань амгалантай, алдар ихтэй.

Бирд, там, адгуусны орны
Их аюулаас та гэтэлжээ.
Ертөнцийг чимэгч нэгний адилаар
Та хилэнц бүхнийг амарлиулжээ.

Таны гарт сав байх,
Их эрдэнийн долоон зүйлээр төгөлдөр,
Биендээ их эрдэнийн тоорцог хийгээд
үзэсгэлэн төгс цогцоор чимсэн нь үзэгдэнэ.

Амарлингуй та бээр үг өгүүлэхэд
Бид хариултыг нь тавьж үл чадмой.
Бид бүхэнд идээ унд хийгээд
сайхан амтат ундаа ч хэрэггүй больюу.

Хоолноос өтгөн гарах болой.
Тэрчлэн ундаанаас шингэн гарах болой.
Шим шүүснээс цус гарах болой.
Тэрчлэн цуснаас урваж мах гарах тул

Идээ унд юу идсэн ч
Бидэнд хэрэгтэй зүйл юу ч алга.
Торго хийгээд тэрэм хоёрыг найруулах ба
Нарийн хээтэй хувцас өмсөөд ч хэрэг үгүй.

Алтан бөлзөг зүүгээд ч хэрэг үгүй.
Сувдан эрхи зүүгээд ч хэрэг үгүй.
Бугуйвч зүүгээд ч хэрэг үгүй.
Тэр бүгд мөнх бусын жамт болой.

Бид муу заяанд үл одох
Амь насыг эрэлцэх болой.
Бид тэнгэрийн амгалан хийгээд
Номын өглөгийг эрэлцэнэ.

Буяны садан нугууд ч хэрэг болох бөгөөд
Гэсэн хэдий ч Загарвардийн хаанаас буцах болой.
Машид сайхан тивээ орхиод
Загарвардийн хаан үхэхэд хүрдэг.

Хүүхдүүд нь араас нь үл дагах бөгөөд
Эхнэр, охид нь ч үл дагах.
Долоон зүйлийн их эрдэнэ эрхшээсэн хэдий ч
Араасаа дагуулж чадахгүй болой.

Олон ардыг хураасан хэдий ч
Араасаа дагуулж чадахгүй болой.
Бас өмнөө оруулж ч чадахгүй болой.
Тэр мэтээр зэрэгцээд явж ч чадахгүй болой.

Нэгэн төрөлдөө хаан болсон ч
Мөнх бус учраас аанай тэнэх бөгөөд
Элдэв нүгэл хилэнцийг олонтаа үйлдсээр
Уухилан дуудах тамын амьтан болж унах бий.

Долоон зүйлийн их эрдэнэ хийгээд рид хувилгаанаар
Дөрвөн зүгтээ хүрээлэгдэвч
Алин хэзээ Уухилан дуудах там боловсрохын цагт
Нөгөөх рид хувилгаан нь хаашаа одох юм болоо?

Газар дэлхийн хаана ч байсан алга болох учир
Үхсэний хойно рид хувилгаан байлаа ч үл дийлэх
Настан минь, бидэнд айлдагтун.
Бурхад хаана байгаа газар хүргэгтүн.

Эх эцгийн адилаар
Түүнийг үзэхийг машид хүснэ.
Бидний хувьд эжий ч алга, эцэг ч алга,
Ах дүү, садан ч алга.

Ертөнцийн эрхэм нь Түүнчлэн залрагсад билээ.
Тэд бүгд эцэг болоод эх минь билээ.
Тэд бүгд нар болоод сар билээ.
Амгалант мөрийг сайтар заагч болой.

Алин хэзээд хойшдоо ч үл төрөх,
Тэр ямагт зовлонг эцэслэн зохиогч билээ.
Их аюулт нисванисын далай хийгээд
Их далайгаас гэтэлгэгч онгоц тэр билээ.

Тэрбээр амьтныг сайтар гэтэлгээд,
Жич дахин үл буцаах болой.
Бодийн дээдийг сайтар зааж,
Дээдийн Номыг ч тэрээр номлох болой.

Бидэнд идээ унд хэрэггүй
Хаан төрийн үрийг ч үл хүсэх буюу
Тамын аюулаас айх учир
Ертөнцийн тэнгэрт үл одмой.

Хүний насанд амгалантай бөгөөд
Хамгийг болгоогчийг үзнэ.
Өөртөө гэмтэй үйлийг олонтаа үйлдсэн тул
Нас богиносож, тэнэх мөн.

Тэдгээр нь үхлийг үл мэдэх ч
Хүсэн шунах таашаал хийгээд хаан төрийг мэдэх
Төрөх хийгээд түрдэх учраар хууртагдсан нугууд
Үл мэдэх хийгээд үл аюух буй.

Мөнх бусад төөрөлдсөн нугууд
Нарийн Номыг үл мэдэх агаад
Нарийн үүргийг ч үл үйлдэх тул
Амарлингуйн агаарыг ч үл мэдэх болой.

Үхэл егүүтгэхэд гэмших сэтгэл үгүй
Ахин дахин төрөх буюу.
Өнөд удаан зовлонгоор хатгуулах бөгөөд
Үргэлжид бэрээгээр зодуулах хийгээд
Бусад нэгнийг булааж дээрэмдэх бөгөөд
Хүлж зодож, алах бий.
Урдын нүглийн шаардлагаар
Тэр бүгд таван хүлээс баглаанд хүлэгдэх болой.

Түр зуур тасрах нэг бий.
Гэсэн ч гаслангийн хатгуулгаар хатгагдах.
Тийн мэдэл хоригдоод ирэхэд
Өрөвдөлтэй дуугаар гаслан дуудах:

‘Намайг хэн аврах болоо?
Алт, мөнгө, шил болор хийгээд
Төгс эдлэл бүгдээ өргөө.

Намайг боолын боол болгож үйлд.
Зарцын зарц болгож үйлдэх элдэв үйлийг ихээр бүтээе.’

Ингэхлээр хаан төрийн эд баялаг ч надад хэрэггүй болой.
Эд таваар, үр тариа бус болой.
Миний бие ч надад хэрэггүй болой.
Хилэнц үйлдсэн болохоор үл гэтлэх болой.
Иймээс, настан та минь, бидэнд
Идээ унд хэрэггүй болой.

Хичнээн сайхан тансаг идээ зооглосон
Хаад эзэд ч үхэж байх.
Ундааны дээдийг уусан
Тэнгэрийн хөвгүүд ч үхэж байх.

Есөн амт нь бүрдсэн
идээ ундыг машинд бэлтгээд
Хааны өмнө өргөхөд
идээ зоогийг хэлээр амтлаад

Хаад бүгдээр амтанд л шунах
Нүглээн үл багасгах үйлийг л үйлдэх,
Алин хэзээд шим шүлтгүй
мөнх бусын амтанд л тачааж үйлдэх.

Би нугуудад ундаа хэрэггүй.
Хоол унд ч хэрэггүй.
Биднийг зовлонгоос гэтэлгэх
Ном л харин хэрэгтэй.

Шунахуйн хүлээснээс сайтар гэтэлгэх
Нисванисын хүлээснээс лавтай тонилгох,
Хамаг хүлээснээс баттай ангижруулах
Бурхан түүнийг л авралд баримуй.

Ертөнцийг аюулаас аврагч
Их аршид бид авралыг эрнэ.
Амьтныг аврахдаа баясгалант түүнд
Бид мөргөхийг хүснэ.

Таны алдарыг эрэлцэж үйлдмүй.
Нэр алдараа үзүүлэн зохио.

Бхайшажяа-сэна өгүүлэв:

Та болоод хамаг төрөлхтөн бүгдээр
Тэрчлэн нэрийг сонсохыг хүснэ.
Живаа тоот залуу амьтан
Түүнчлэн залрагсадыг эргэн мөргөмой.

Тэд бээр ийн өгүүлэв:

Та болбоос Бурханы шавь билээ.
Таны алдар нэр ихэд алдарт билээ.
Хамаг амьтан бүгдээр
таны нэрийг сонсохыг хүснэ.

Өгүүлрүүн:

Миний нэр болбоос Бхайшажяа-сэна (*мон: Оточийн аймагт*),
Амьтан нугуудын эм билээ.

Оточ бүгдийн дээд буюу
Та нарт учрыг номлосугай.
Элдэв өвчин туссан амьтны
Элдэв зовлонг амарлиулж үйлдэх буюу.

Хүсэл шунал гэдэг хамгийн аймшигт өвчин.
Ертөнцийг эдлэн үйлдэгч барагдашгүй их зовлон.
Хэн хүнийг ухаангүй болгон тэнүүлэгч
Мунхаг хэмээх өвчин хатуу чийрэг бөлгөө.

Там болоод адгуус бирдийн төрөлд
Амьтныг хөтлөх
Нялхас бид нар уур омогт эзлэгдсэн
Тийм болохоор яаж амгалантай байх вэ?

Тэд бээр ийн өгүүлэв:

Буяны Ном энэ адилыг сонссоноор
Бид хамаг зовлонгоос гэтлэх больюу.

Нялхасын ухаан мунхаг учраас
Зовлон бүхнээс гэтлээд
Хилэнцийн үйлээ тэвчинэ.
Бид Номын өглөгийг ч хүртэх болтугай.
Хамаг хилэнцийг сайтар тэвчээд,
Барагдашгүй аюул бүгдийг огоорох хэрэгтэй.

Өвчин бүхнийг амарлиулан үйлдэгч
Оточийн хаан нь Оточ буюу.
Зовлон шаналгааг анагаан үйлдэгч
Үнэхээр туулсан бурханыг түргэнээ үзэх болтугай.

Түүнчлэн залрагсад мөргөхийн тухайд
Архад, та түргэн дээшлэгтүн.
Эргэж мөргөөд бидний үгийг
Ертөнцийн сартваахид айлдана уу

Энэхүү өвчнийг түргэн амарлиулан зохио.
Хамаг биеэр минь гал бадрах бөгөөд
Түлэгдэх шатахын барагдашгүй зовлонт
Үл амарлих галыг даран зохио.

Биеийн ачаа гэдэг их хүнд
Машид барагдашгүй хүнд ачаа үүрсэн.
Зовлонгийн хатгуулгат бид нарыг
Дээд авир ёстон, нигүүлсэнгүй болгоо.

Эгэл ардууд үргэлжид уур хилэн хийгээд
Балай мунхагийн ачааг үүрэх бөгөөд
Ачаанаас гарахаа үл мэдэх тул
Ахин дахин ачаа үүрнэ.

Тонилохуйн мөрөө үл мэдэх бөгөөд
Тонилохуйн замаа үл үзэгч нугууд
Үхнэ гэдгээн хаа нэг мэдэх боловч
Айж эмээнэ гэж ердөө үгүй.

‘Бид хэзээ мөнхөд ч үхэхгүй болой’ гэж санаж,
Амар аажим суух

Үргэлжид эндүүрэх тул
Хэдий тэд өөрийн эхийг
Үхэхийг харавч, үл ухаарна.

Тэд эцгийгээ ч үл санах бөгөөд
Үргэлжид өвдөж зовох учир
Нисванисын үйлээр машид хямраад,
Хэрхэн өгсөн идээг л идэх болой?

Зовлонд шаналснаа үл мэдэх бөгөөд
Өөрсдөө алжааж байгаагаа үл ухаарах буюу.
Энэ адил таны зовлон
Эргүү мунхагийн сууриас л төрсөн болой.

Хуран мэдэхүй, хуран үйлдэхүй,
Сэрэхүй зэрэг нь ч
их аюулын хүнд ачаа болой.

Алин хэзээд Номыг үл мэдсэн тул
Нялхас шуналаас болж үргэлж тэнэх.
Биеийн ачаанд эргэлдэн явсаар
Ертөнцөд тусгүй төрлийг олох.

Ариун хувцас, сайхан угаалга
Элдэв зүүлт, түрхлэг хэрэгтэй болох.
Биендээ алин сэтгэлд зохистой
Бас сайхан амттай идээг хэрэглэх.

Сонсголонтой сайхан дуу таван хөгжим зэргийг
Чихээр сонсож, таашаал авах.
Их эрдэнийн долоон зүйлээс бүрдсэн
Өнгө дүрсэнд нүдээр шунах бий.

Тансаг сайхан амт бүхнийг
хэлээр эдэлж амсах бий.
Хөнгөн зөөлөн хүрэлцэхүйг
Биеэр эдэлж үргэлжид таашаах бий.

Биенээс гарсан хоёр махыг
баясгалантайгаар бүтээснээр
Ухаан үгүй энэхүү бие төрөх бий.
Энэ мэтэд баяслыг олох нь хэн билээ?

Сайхан гутлыг өмсөж гүйх
Тэр мэтэд миний сэтгэл л баясан үйлдэх бөгөөд
Үхэл ирэхийн цагт дээл хувцас болоод
Энгэсэг түрхлэг ч аврал үл больюу.
Бие махбод минь ч аврал болохгүй болохоор
Дээл, түрхлэгийг хэлээд яах вэ.

‘Хүмүүн’ хэмээх нь бие мөн бөгөөд
Амьсгал хийгээд их хүч чадлыг олсон буюу.
Сонсох, шинжихийн чадлыг олж
Их эрдэм төрөх бий.

Урд цагт морь, заан тэргүүтнээр дагалдуулан
Цэнгэн, аялж явлаа.
Тонилохуйн Номыг үл мэдэх учраас
Хилэнцийн үйлэнд би шунана.

Ертөнцийн чанадад юу болохыг үл мэдэх учраас
Тоглоом наадмаар хилэнц үйлдэхэд ч орно.
Би гэдэг ахин дахин төрөх буюу.
Үхэл гэдэг ахин дахин ирэх буюу.

Ахин дахин гасланг амсах буюу.
Гаслан уйлавч дахин хүлэгдэх.
Ижий нугуудаа үхэхийг үзэх.
Эцэг болоод элгэн садан хийгээд эгч дүүс, үр хүүхдээ,
Эхнэр хатад нугуудаа үхэхийг ч үзэх.

Хурж үйлдсэн бүхэн хоосон болсоор байтал
Сэтгэл ухаантай юм бол хэн шунах билээ?
Шуналаар эзлэгдсэн сэтгэлээр
Би үргэлжид тэднийг баттай мэтээр бодох

Амарлингуй Ном нь үл тухайлагдах агаад
Үхэхүй дор илт баясах гэж үгүй.
Тиймээс шунахуйн түйтгэрт сэтгэлээр
Өглөгийг үл өгөв, би
Шунал лугаа тэнцэх нүгэл үл гарах,
Гэтэл эдүгээ түүнээс үл буцжээ.

Хаа сайгүй эндүүрлээс болж бид төрөх.
Хаа сайгүй амьтан бүгд эндүүрэн одох.
Хаа сайгүй эндүүрэх дуу аялгууг сонсох.
Номын бус зүгийг огоот барих.

Нирваан болоод дияаныг эрэлцэж
Биеийг ачаа болгож үл үүрнэ.
Ертөнцийн тусад амьтны эрхэм болохоор
Бурхан болоод багш болох болтугай.

Бурхан бол ертөнцийн эх, эцэг хийгээд
Гэгээрэх зам мөрийг сайтар зааж,
Замбу тив бүхэнд ч
Их эрдэнийн хурыг буулгана.

Номыг хураах гэж юу болохыг
Тэнэг амьтад үл мэдэх буюу.
Бодь хутагт сэтгэлээ зориулж чадваас
Номыг хураах чадлыг олмуй.

Хурсан бүхэн хоосон бөгөөд
Тэрчлэн төгс эдлэл, эд баялаг ч хоосон
Би өөрөө ч хоосон болохыг үзвээс л
Ухаарч горилохын хэрэггүй болно.

Бхайшажяа-сэна, архад та бээр,
Бид нарын энэ үгийг сонсогтун.
Бодьсатва нарын тусад
Та элч болж дээшлэн соёрх.

Сансарын гэмийг дурьдан санадаг тул
Бодьсатвад уйсал гэж үгүй.

Хичээл туурвил төгөлдөр их хатуужил зэргээр ч
Эрдэм болгоныг хэзээд хураана.

Багш хаана буй тэр газар очигтун.
Бурхад амгалантай орших агаад
Бурхад өчүүхэн төдий ч үл уйдна.
Бидний төлөө айлтган зохио:

‘Та нар бол шимнус чөтгөрийг ялсан ба
Тэр хүч тэнхээтэй хэдий ч та дийлэх бий.
Хамаг амьтныг огоот барих
Номыг түргэн бадруулсугай.’

Алин хэзээ бурхан болгох
Номыг бид нар сонссонгүй.
Бид бүхэнд туслахын тухайд
Архад та нар түргэн дээшлэгтүн.

Гучин хоёр бэлгийг эрхшээсэн
Түүнчлэн залрагсдыг үзсэнгүй байсаар
Бид нар явах нь байна шүү хэмээн
Бүгдээр сүслэж, бишрэн оршвой.

Бхайшажяа-сэна өгүүлрүүн:

“Та нар юу харна вэ?
Түр ч атугай дээшээ нэг хараадах.”

Тэд дээш харцгаав.
Гурван мянга таван зуун давхарлагат орд харш
эргэн тойрон асар уужим,
долоон их эрдэнээр машид чимсэн,
их эрдэнийн тороор үзэсгэлэнтэй хээлсэн,
Төвд нь цэцэг машид дэлгэрсэн,
тэнгэрийн хүжис хэвнэг сугсалзсан тийм нэгэн ордон
байгааг үзэв.

Тэд асуув:

“Давхарлагат орд харш,
их эрдэнийн торт
лянхуан тоорцог зүг бүхэнд дэлгэрсэн
энэ адил үзэгдэх нь юу вэ?”

Бхайшажяа-сэна өгүүлрүүн:

Эдгээр орон нь таны өнөөх үзэх гэсэн
Бурхадын тухайд билээ.
Ертөнцөөс гэтэлсэн түүнээ,
Ертөнцийг гэрэлтүүлэгч түүнээ,
Сартваахи түүнээ мөргөгтүн.

Тэдгээр бээр өгүүлэв:

Гэвч бид тэдэнд хүрэх зам мөрийг мэдэхгүй,
Бурханыг үзэхгүй байна.
Тийнхүү мөрийг мэдэхгүй тул
Хаа очиж мөргөх билээ?

Бхайшажяа-сэна өгүүлрүүн:

Хэмжээлшгүй огторгуйн орон мэт
Хүрэлцэж үл чадна.
Рашаан шимийг хайрлаж,
Сайтар заасан багшид
Мөргөхийн тухайд одож үл чадмой.

Хэрхэн Сүмбэр уул орших мэт
Тэр багш заларч оршсоор л буй.
Сүмбэр уулыг үлж болох байх,
Сүн далайг хэмжиж болох байх.

Гурван мянган ертөнцийн нарийн тоосыг тоолж болох,
Харин бурхан төрөхийг л мэдэж үл чадмуй.
Арван зүгийн бодьсадва нар
Ертөнцийг гийгүүлэн зохиосноо мөргөмүй.

Өгүүлрүүн:

Ертөнцийн итгэл та, биднийг болгоо!

Бидний санааг төгсгөн зохио.

Бидний, сэтгэлээр багшдаа

залбиран мөргөсөн зэргээс

Бид үрийг нь амсах болтугай.

Бхайшажяа-сэна өгүүлрүүн:

Багш тэр нь үнэрт үл тачаах буюу,

Эрхэст бус түрхлэгт бус.

Багш тэр нь алин бээр

хуран үйлдсэнийг гэтэлгэх буюу,

Амьган нугуудын үндсийг барих болой.

Хэн бээр сэтгэлээ номхотгох агаад

Бурхан дор авралыг одуулснаар

Түүнийг чөтгөр шимнус барагдашгүй ихээр эсэргэлдэвч

Үл дийлэх болой.

Үхлийн эрхэнд үл одох болой.

Тогтоолыг түргэн олох болой.

Тэрээр сэтгэлээр машид сүсэлж,

Төдөлгүй бурхадыг үзэх больюу.

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөн, түүнчлэн залрагсан бээр галабингаан сэтгэлд зохист дуун эгшгээр мөшөөн зохиов. Чингээд бодьсадва, их бодьсадва Бхайшажяа-сэна суудлаасаа босоод, Ялж төгөлдөр нөгчигсөний байгаа зүгт алгаан хавсран сөгдөөд, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, аливаа Ялж төгөлдөр нөгчигсөний нигуурын үүднээс 8 түм 4 мянган гэрэл цацрах бөгөөд тэрхүү гэрэл нь гурван мянган их гурван мянган ертөнцийн орон бүхэнд түгэв. Гучин хоёр их там бүхэнд түгэв. Гучин хоёр тэнгэрийн орныг гэрэлтүүлэв. Тэдгээр гэрлийн өнгө нь элдэв бөгөөд энэ адил буюу: ногоон, шар, улаан, цагаан, литийн өнгөт, болрын өнгөт, мөнгөн өнгөт бөгөөд тэдгээр гэрлүүд Бурханы нигуурын үүднээс гарч, гурван мянган их мянган

ертөнцийн орон бүгдийн амьтан бүхнийг амгаланд байгуулаад, жич наашаа буцаж Бурханыг долоон удаа эргээд, Бурханы зүгдэрт шингэн одохын цагт мөшөөн зохиосны үндэс алин, шалтгаан алин бэ?”

Чингээд Ялж төгөлдөр нөгчигсөнөө бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна бас ийн айлтгав: “Ялж төгөлдөр нөгчигсөөн, надад завшаан тохиовол Ялж төгөлдөр нөгчигсэн, түүнчлэн залрагсан, дайснаа дарсан, үнэхээр туулсан бурханаа, би зарим зүйлийг асууя.”

Ялж төгөлдөр нөгчигсэн бээр бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэнад ийн хэмээн зарлиг болбой: “Бхайшажья-сэна, та юу хүссэнээ, юу бодсоноо асуугтун. Би таны асуусанд эш бошгыг үзүүлэх тул таны сэтгэл баярлах бизээ” хэмээв.

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, 30 000 сая тоотой залуус бээр Түүнчлэн залрагсадын нарийн Номыг заалгаж ухааравч хөгширч өтөлсөн амьтныг болохоор: “Өтөлтлөө Ном мэдсэнгүй, цаг үргэлжид Ном бус нүгэлд шуналаа” гэх зэргээр хамгийн муухайгаар яруу бусаар хэлбэл хорлол гарч байгаа нь тэрээ. Бурхаан, яагаад яруу үг, сэтгэлд зохистой зүйлийг хэлж байсан бэ?”

Бурхан зарлиг болруун: “Бхайшажья-сэна, яагаад ийн өгүүлэхийг мэдэхгүй гэж үү? Тэд Бурханд зөөлөн агаад машид яруу сайхныг өгүүлнэ. Хэдий Ном сонссон ч тэр Номынхоо утгыг олох хэрэгтэй. Олж чадвал эрдэм төгс болно. Тэр бүгдээр тогтоолыг онох болно. Өнөөдрөөс хойш тэд аравдугаар газарт орших болно, өнөөдөр тэд Номын их хэнгэргийг дуугаргах болно. Өнөөдөр тэд Номын эрдэм бүхнийг төгсгөх болно. Бхайшажья-сэна, эдгээр давхарлагат ордонг харна уу?”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, харна, Амгалан залрагсаан, харна.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажья-сэна, өнөөдөр эдгээр залуус энэхүү орд харшид сууж, Номыг илт онох эрдмийг олно. Өнөөдөр буяны ном бүхнийг төгс төгөлдөр үйлдэнэ. Өнөөдөр Номын их хэнгэргийг дэлдэнэ. Тэнгэрийн олон орноо өнөөдөр Номыг илт онох ухааныг олно. Тамын оронд буруутаж одсон олон

амьтад ч Тэрчлэн залрагсдын билгэ билгүүнийг үзэж сонсоод, орчлонг нурааж ялж гарна. Тэр цагт 90,000 сая тоотой хөгшид өтгөс амьтан бүгдээр үргэлжид оршихуйн үрийг олов. Тэд бүгдээр Ном буянд төгөлдөр болов. Тэд бүгдээр хамаг зовлонгоос огоот ангижрав, Бхайшажяа-сэна. Тэд бүгдээр Түүнчлэн залрагсдыг үзэх бүтээлийг олов, Бхайшажяа-сэна, тэд бүгдээр их Номын зарлиг төгөлдөр болов, Бхайшажяа-сэна. Бхайшажяа-сэна, дөрвөн зүгт харагтун.”

Бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна бээр дөрвөн зүг бүхнээ харсан ба зүүн зүгт 50 сая Ганга мөрний элсний тоотой бодьсадва үзэгдэв. Өмнө зүгт 60 сая Ганга мөрний элсний тоотой бодьсадва ирэв. Баруун зүгт 70 сая тоот Ганга мөрний элсний тоотой бодьсадва ирэв, умар зүгт 80 сая тоот Ганга мөрний элсний тоотой бодьсадва ирэв. Доод зүгээс 90 сая Ганга мөрний элсний тоотой бодьсадва, дээд зүгээс 100 сая Ганга мөрний элсний тоотой бодьсадва нар өөдлөв. Тэд бүгд нэгдээд, Бурханы өлмийн өмнө нэгэн зүгт цуглав.

Бодьсадва, их төрөлхтөн Бхайшажяа-сэна бээр Бурханаа ийн айлтгав: “Бурхаан, огторгуй завсарын орон зайд үзэгдэх хар дүрс, улаан дүрс юуных вэ?”

Зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, огторгуйн орон зайд үзэгдэх хар дүрс, улаан дүрс юу болохыг мэдсэнгүй гэж үү? Бурхад болгоох болой. Энэ бол чөтгөр болой, Бхайшажяа-сэна, үзэхийг хүснэ үү?”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, эрэлцмү, Амгалан залрагсаан, эрэлцмү.”

Бурхан бээр зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, 100 сая тоот Ганга мөрний элсний тоот сацуу бодьсадва нар ирэв.”

“Ялж төгөлдөр нөгчигсөөн, эдгээр бодьсадва нар энд цугладгийн учир шалтгаан юу вэ?”

Зарлиг болруун: “Бхайшажяа-сэна, залуу амьтнаар шалтаг болгож, амьтан бүгд нь самади бясалгалын хүч төгөлдөр болой. Бхайшажяа-сэна, элдэв янзын дүрс хэлбэртэй амьтан энд цугласан ба рид хувилгааны адистид элдэв хүч чадлаар энд цугласныг үзэв үү?”
хэмээв.

“Би бээр 100 живаа тоот Ганга мөрний элстэй тэнцэх бодьсадва нар мөн зуун мянган живаа тагтаг тоот Ганга мөрний элсний тоотой тэнцэх бодьсадва нар рид хувилгааны хүчээр оршихыг үзэх бөгөөд элдвийн дүрс, элдвийн өнгө, элдвийн хэлбэр бүхий эдгээр бодьсадва бүгдээр хутагтын Номонд орших буюу. Эдгээр бодьсадва нөхөр сэлт бүгдээр Номын агаарт оршиж байгааг үзэх болой.”

Ялж төгөлдөр нөгчигсөн бээр ийн хэмээн зарлиг болоод, бодьсадва, их төрөлхтөн Сарва-шура хийгээд бодьсадва, их бодьсадва Бхайшажья-сэна хийгээд хөгшин, залуу бодьсадва нар, нөхөр сэлтийн хамт ба тэнгэр, хүмүүн, асур, үнэр идэштэн зэрэг ертөнцийнхөн даган баясаж, Ялж төгөлдөр нөгчигсөний зарлиг дор илт магтав.

Хутагт Хос судрын номын зүйл төгсөв.

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D) Т.Булган